Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY


Брэндэд ойрхон ирээдүй

Тусгайлан сонирхох тусгаар Монгол

Монголын эдийн засаг, санхүү, бизнесийн сэтгүүл 2013. 03 сар. №04, 05 (038, 039) www.mongolianeconomy.mn




Нийт хөрөнгийн харьцаа




2012 оны 12-р сарын байдлаар, нийт хөрөнгийн хэмжээгээр Худалдаа, хөгжлийн банк нь банкны салбарын 22.9 хувийг эзэлж байна. Тайлант хугацаанд Худалдаа, хөгжлийн банкны нийт хөрөнгийн хэмжээ 2 их наяд 623 тэрбум төгрөгт хүрч өөрийн хөрөнгийн хэмжээ 295.2 тэрбум төгрөгт хүрлээ.

Нийт зээлийн харьцаа




2012 оны 12-р сарын эцсийн байдлаар, Худалдаа, хөгжлийн банк нь Монгол улсын байгууллагын харилцагчдийн 29.5 хувийг эзэлдэг хамгийн том зээлдэгч юм. Нийт зээлийн хэмжээгээр банкны салбарын зээлийн 22.2 хувийг дангаараа эзэлж байна.

Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн харьцаа



2012 оны 12-р сарын эцсийн байдлаар, нийт салбарын 20 хувийг эзэлж байна. Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа бөгөөд энэ онд 1391.1 тэрбум төгрөгт хүрлээ.

Цэвэр ашгийн харьцаа



2012 оны 12-р сарын эцсийн байдлаар, нийт банкны салбарын ашгийн 32.7 хувийг эзэлж байна. Дээрх зурагт Худалдаа, хөгжлийн банкны өсөж буй ашгийн хэмжээг харуулав.

TDB

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК


ТАНЫ БИЗНЕСИЙН

НАЙДВАРТАЙ ТҮНШ

- МОНГОЛЫН ХАМГИЙН ТОМ БАНК
- МОНГОЛЫН ШИЛДЭГ КОРПОРАЦИУДИЙН ХАМГИЙН ТОМ ЗЭЭЛДЭГЧ
- ОЛОН УЛСЫН ЖИШИГТ ХҮРСЭН, ГАДААД ХАРИЛЦААГААР МОНГОЛДОО ТЭРГҮҮЛЭГЧ БАНК
- ҮҮЛ ҮҮРХАЙН САЛБАРТ ШИЛДЭГ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ БАНК
- МОНГОЛЫН АНХНЫ БӨГӨӨД ЦОРЫН ГАНЦ БОНД ГАРГАГЧ БАНК

Bloomberg
TV MONGOLIA

2012 ОНЫ 10-Р САРД
АМЖИЛТТАЙ НЭЭЛЭЭ







МОНГОЛ УЛСЫН ШИЛДЭГ БАНКААР ШАЛГАРЛАА

МОНГОЛ УЛСЫН ХУДАЛДААНЫ САНХҮҮЖИЛТЫН ШИЛДЭГ БАНКААР ШАЛГАРЛАА

МОНГОЛ УЛСЫН ШИЛДЭГ БАЙГУУЛЛАГЫН БАНКААР ШАЛГАРЛАА

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Бага тойруу-12, Жуулчны гуламж-7, ХХБ-ны төв байр
Утас: (976-11) 317368, 1977 | Факс: (976-11) 317368 | info@tdbm.mn | www.tdbm.mn



GOBI ORGANIC
MONGOLIAN CASHMERE



Gobi-Mongolian Organic Cashmere Дэлгүүр
Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,
Чингэсийн өргөн чөлөө, Үйлдвэрчний гудамж
Утас: 11 343677, Факс: 976 11 343081
Вэбсайт: www.gobi.mn, facebook.com/GobiCashmere
Имэйл: marketing@gobi.mn, export@gobi.mn



СҮҮ Хувьцаат Компани

ҮНДЭСНИЙ МАНЛАЙ ҮЙЛДВЭР

"СҮҮ" ХУВЬЦААТ КОМПАНИ

.. Эрүүл урт удаан наслах амьдрахуйн нууцад нэвтрэх аялал минь үрэлжилсээр ..

Хүмүүний эрүүл оршихуйн эх үндэс нь төрж өссөн нутаг, ус агаар, газар шороо түүнд зохицон бий болсон хоол хүнс билээ.



ҮНДЭСНИЙ *Үндаа*



Утас: 631950 • www. mongolmilk.mn

www.facebook.com/mongolmilk.mn

Нөгөөн хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:
Д.Бэхбаяр /9999-4248/

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:
И.Отгонжаргал /8800-6228/

ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:
Б.Энхмарт

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР: Теренс Эдвардс
ОРЧУУЛАГЧ: Р.Гантулга
Б.Заяа

СЭТГҮҮЛЧИД: Б.Баяртогтох
Б.Энхцэцэг
Э.Зоригт
Х.Хулан

ДИЗАЙНЕР: Ш.Оюундарь
ВЭБ МАСТЕР: Б.Лхагвачулуун

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР: Д.Барианжав /8880-0825/
Д.Баттулга /9902-2279/
Б.Энхцэцэг /9901-5476/
БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР: С.Цэнд-Аюуш /8870-3633/

"ECONOMY" ТВ СТУДИ
РЕДАКТОР: Б.Үүрийнтуяа
ЗУРАГЛААЧ: Ц.Бат-Отгон

ХАЯГ:
Улаанбаатар, ЧД IV хороо,
Анкарагийн гудамж-23 Тод Тауэр-604 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/ х-2762
www.mongolianeconomy.mn
info@mongolianeconomy.mn

УТАС/ФАКС: 976 - 7011 5476

БОРЛУУЛАХ ЦЭГҮҮД:
"Интер ном"
"Цэцэг төв"
"Минж плаза"
"Алтантүлхүүр" номын дэлгүүр
"Номин" супермаркетийн бүх салбар
"Макс" супермаркетийн бүх салбар
"Преско" супермаркет
BTSI супермаркет
"Аз орчлон" номын дэлгүүр
"Билэг" их дэлгүүрийн номын тасаг
"Гранд Плаза" дахь супермаркет
"Мир" номын дэлгүүрийн
"Grand plaza"
"Metro mall"
"Sky" супермаркет
"Улаанбаатар" их дэлгүүр дэх салбар
"Max mall" салбарууд

"Улаанбаатар принт" ХХК-д хэвлэв
www.ubprint.mn



2013 оны Монголын эдийн засгийн чуулган өмнөх жилүүдийнхээсээ хэд хэдэн онцлогтой. "Монголын эдийн засгийн форум" төрийн бус байгууллагаас зохион байгуулдаг ч энэ удаагийн чуулга шинэчлэлийн Засгийн газраар овоглож байна. Засгийн газрын зорилго, бодлого үйл ажиллагаа Усан могой жилийн Эдийн засгийн чуулганаар хэлэлцэх асуудлуудад тусчээ.

Дэлхийд Монголыг таниулах брэндийг ямар салбараас хэрхэн бий болгох талаар хоёр өдөр төлөөллүүд ярилцаж санаа бодлоо хуваалцах ч хэрэгжүүлэх ажил хэрэг болгох эрх нь Ерөнхий сайдад байгаа тул асуудал нааштайгаар шийдвэрлэгдэж магадгүй гэсэн хүлээлт хувийн хэвшлийнхэнд байна. Өөрөөр хэлбэл, өмнөх Монголын эдийн засгийн чуулганаар өргөн хүрээний олон асуудлыг ярилцахаар төлөвлөдөг байсан бол энэ удаа цөөхөн бөгөөд гол асуудлаа барьж авах чиглэлийг шинэ Засгийн газраас өгчээ.

Гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлах хууль хэрэгжиж эхэлсэн, Оюутолгойн гэрээ, Ашигт малтмалын тухай хуулийн өөрчлөлт, шинэчлэлтийн талаар яригдаж буй энэ үед Эдийн засгийн чуулган болж байна. Төлөвлөсөн сэдвээсээ

Эрхлэгчийн зурвас

халихгүйгээр төрийн бус байгууллага, хувийн хэвшлийнхний саналыг сонсож, ажил хэрэг болгож ажиллах зорилгыг жил бүрийн энэхүү уулзалт тавьж ажилласаар ирсэн. Хамгийн гол нь үр дүн. Дараа жилийн чуулганаар үр дүнг ярилцаж, ямар асуудал ажил хэрэг болж, ямар брэнд дэлхийд эх орноо сурталчилсан бүтээгдэхүүн болох нөхцөлийг тавьсан, хэрхэн дэмжсэн талаар ярилцвал илүү ач холбогдолтой болов уу.

Түүнчлэн чуулганы нэгэн тусгай зочин нь Голландын Ерөнхий сайд асан Вим Кок юм. Тэрбээр олон улсад “polder model” нэрээр алдаршсан загварыг хэрэгжүүлсний үр дүнд 1980-аад оны “Голланд өвчин” ерээд оны “Голланд гайхамшиг” болж хувирсан гэдэг.

“Mongolian Economy” сэтгүүл жил бүрийн Монголын эдийн засгийн чуулганы мэдээллийн түншээр хамтран ажиллаж ирсэн билээ. Энэ уламжлалын хүрээнд Монголын эдийн засгийн чуулганд зориулсан тусгай дугаарыг бэлтгэн таньд хүргэж байна. Чуулганаар хэлэлцэх асуудлууд, монгол брэнд сэдвээрх нийтлэл, ярилцлагуудыг сэтгүүлдээ түлхүү оруулаа. Монгол брэндийг гаргаж ирэх чуулганы, таны ажилд амжилт хүсье.

Эрхлэгч Д.БЭХБАЯР

Entrepreneur-2011



МҮХАҮТ-ын 2011 оны онцлох
ENTREPRENEUR

The Business Council of Mongolia



Монголын бизнесийн зөвлөлийн 2012 оны
“ШИЛДЭГ ХЭВЛЭЛ”
MONGOLIAN ECONOMY

МОНГОЛЫН
ЭДИЙН ЗАСГИЙН ЧУУЛГАН

МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ФОРУМ-2013
ХӨТӨЛБӨР

Даваа гараг, 2013 оны 3 дугаар сарын 4

08:00 – 09:00	Оролцогчдын бүртгэл
09:00 – 09:20	Нээлтийн үйл ажиллагаа: Монгол Улсын Ерөнхий сайд
09:20 – 09:35	Хүндэт зочны үг: Азийн Хөгжлийн банкны Дэд ерөнхийлөгч Лакшми Венкачаталам
09:35 – 10:30	Нэгдсэн хуралдаан: “Эдийн засгийн орчин ба Монгол брэнд”
10:30 – 10:45	Цайны завсарлага
10:45 – 12:15	Салбар хуралдаан “ Монгол брэнд ба боломж”
	СХ 1: Хүнсний бүтээгдэхүүн Монгол хүнс Монголд брэнд болох нь
	СХ 2: Хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүн Монгол брэнд болох нь
	СХ3: Аялал жуулчлал Монгол брэнд болох нь
12:15 – 13:15	Үдийн зоог
13:15 – 14:45	Нэгдсэн хуралдаан: Хөгжлийн санхүүжилт
14:45 – 16:15	Нэгдсэн хуралдаан: Хөдөлмөрийн зах зээл ба хүний нөөц
16:15 – 16:30	Цайны завсарлага
16:30 – 18.00	Нэгдсэн хуралдаан: Хууль эрх зүйн орчин
18:00 – 18:30	Нэгдсэн хуралдаан: Өдрийн тойм

Мягмар гараг, 2013 оны 3 дугаар сарын 5

08:00 – 09:00	Оролцогчдын бүртгэл
09:00 – 09:15	Нээлтийн үг: Монгол Улсын Ерөнхийлөгч Ц. Элбэгдорж
09:15 – 09:45	Хүндэт зочны үг: Голландын Ерөнхий сайд асан Вим Кок
09:45 – 10:30	Нэгдсэн хуралдаан: Эдийн засгийн төрөлжилт
10:30 – 11:00	Цайны завсарлага
11:00 – 12:30	Тусгай хэлэлцүүлгүүд
	ТХ1: Усны санаачилга (Дэлхийн эдийн засгийн Форумтай хамтарсан арга хэмжээ)
	ТХ2: Төр хувийн хэвшил, мэргэжлийн холбоод, ОУ-ын байгууллагын хамтын ажиллагаа
	ТХ3: Ногоон хөгжил (Дэлхийн эдийн засгийн форумтай хамтарсан арга хэмжээ)
12:30 – 13:30	Үдийн зоог.
13:30 – 14.30	Лекц
	Лекц 1 : Др. Жулиа Слоан, Нью Йоркийн Колумбийн Их Сургулийн Профессор
	Лекц 2 : “Next Stop” наадмын Оны залуу бизнесмэн Б. Бямбасайхан
14:30 – 16:00	Нэгдсэн хуралдаан: Бизнесийн орчин
16:00 – 16:30	Цайны завсарлага
16:30 – 17:30	Нэгдсэн хуралдаан: Өдрийн тойм, чуулганы хаалт

Н.Алтанхуяг: Монгол брэнд гаргахад төрийн зүгээс хийх ажлаа шууд эхлүүлнэ



Монголын эдийн засгийн чуулган болж буйтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг “Mongolian Economy” сэтгүүлийн тусгай дугаарт байр сууриа илэрхийллээ. ...12

Тусгайлан сонирхох тусгаар Монгол

Оновчтой тодорхойлолт хүнд сэтгэл хөдлөл мэдрүүлдэг гэж аялал жуулчлалын брэндийг тодорхойлжээ..18

Брэндэд ойрхон ирээдүй



Гадаад зах зээл дээр брэнд болох зорилт тавьсан бол эхлээд хэрэглэгчийн анхаарлыг татах, сонирхлыг өдөөх, эдэлж чанарыг нь танихыг хүсэмжлэх, худалдан авах гэсэн брэндийн маркетингийн дөрвөн суурь үйлдэл байдаг..22

Хэт олон эхлэл, зогсолт

Доктор Профессор Найжл Финч нь Сиднейн Их сургуулийн Бизнесийн сургуулийн элсэлт хариуцсан захирлаар ажиллаж байна. Тэрбээр Ази болон хүч түрэн гарч ирж буй эдийн засагтай орнуудын хөгжил, бизнесийн хууль, эрх зүйн зохицуулалтаар мэргэшсэн нэгэн юм...43



ЭДИЙН ЗАСАГ

10 Шинэ боломж

12 Н.Алтанхуяг: Монгол брэнд гаргахад төрийн зүгээс хийх ажлаа шууд эхлүүлнэ

14 “Аз жаргалтай” малын мах

18 Тусгайлан сонирхох тусгаар Монгол

22 Брэндэд ойрхон ирээдүй

26 Үндэсний брэнд “төрүүлэхэд” Засгийн газрын дэмжлэг хэрэгтэй

29 Хаалгаа нээгээч, дэлхийн зах зээл

34 Брэнд бий болгож, хөгжүүлэх нь

38 Брэнд бий болсон түүхээс

40 Хөгжлийн асуудлуудыг хамтдаа шийдвэрлэх нь

43 Хэт олон эхлэл, зогсолт

НОГООН ЭДИЙН ЗАСАГ

46 Шинэ соёл иргэншил

УУЛ УУРХАЙ

50 Анхны баяжмал



ОНЦЛОХ

ШИНЭ БОЛОМЖ

И.ОТГОН

Шотланд виски, Итали хоол, Франц вино, Герман чанар, Япон автомашин гээд улсаараа овоглосон брэнд цөөнгүй. Түүнчлэн Dior, Chanel, Dolce and Gabanna, Omega, Toyota, Honda, Liebherr зэрэг хувцас загварын болон үйлдвэрлэлийн үндэсний брэнд ч тоолж барахгүй олон. Монголчуудын өдөр тутмын хэрэглээнд дэлхийн олон орны төрөл бүрийн брэнд нэмэгдсээр. Хэдий тийм ч хэн бүхэнд танил “Монгол брэнд” гэсэн ойлголт харьцангуй бага байгаа билээ. Энэ удаагийн Монголын эдийн засгийн чуулганы нэгдсэн хуралдаан “Монгол брэнд ба боломж” сэдвээр болохоор байгаа нь монголчуудад шинэлэг, сонирхолтой сонсогдох аж. Брэндийн тухай судалгааны бүтээл, материал нийлүүлэх судлаач, багш нар манай сэтгүүлийн редакци руу нэлээд



Фотог Э.Бямба-Очир

хандаж буйгаас үзэхэд энэ сэдэв яригдах цаг нь болсон, нийгэм-эдийн засагт хүлээгдэж буй асуудал гэдэг нь илүүтэй мэдрэгдэж байсныг энд тэмдэглэх хэрэгтэй болов уу.

Бүтээгдэхүүний брэнд, компанийн брэнд, үйлдвэрлэгчийн брэнд, бүс нутгийн брэнд, хувийн шошго гээд брэндийн төрөл дотроо олон аж. Бид эхлээд дотоодын брэндийг бий болгох тухай ярих уу, гадаад зах зээлийн асуудлыг авч үзэх үү, аль алиныг нь хэлэлцэх үү. Эдийн засаг нь хурдацтай хөгжиж буй Монгол Улсын хувьд мах, сүү, арьс шир аль алиныг нь л брэнд болгомоор байна. Гэтэл гаднын брэндийн үүсэл хөгжил, мөн чанарыг гадарлах зөвлөх мэргэжилтнүүдийн тодорхойлж буйгаар брэнд гэдэг бол итгэл үнэмшил, амлалт, мэдрэмж гээд хийсвэр сэтгэхүйн ойлголт яригдах аж. Тийм болохоор бид яг хаанаас эхлэх вэ гэдэг нь тунгааж бодох л асуудал. Гэхдээ монгол үнээний сүүгээр хийсэн тараг, ааруулыг брэнд болгоно гэж зүтгэх нь одоохондоо муйхар бодол болох ч Монголд брэндэд ойрхон ирээдүйтэй салбар бас бий. Тэр нь ноос, ноолуур юм. Энэ салбарын үйлдвэрлэл эрхлэгчдийн нэг хэсэг нь брэндийн тухай төдийлэн бодож амжаагүй байхад нөгөө талд нь том үйлдвэрлэгчид брэндийг хөгжүүлэхийн төлөө хөрөнгө мөнгө, хүч хөдөлмөрөө харамгүй зарцуулах болов. АХБ-ны Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний маркетинг, брэндийг хөгжүүлэх төслийн захирал Юрган Мендритцки энэ талаар хэлэхдээ “Брэндийн хөгжлийн ойлголт Монголын ноос, ноолуурын жижиг үйлдвэрийнхэнд бараг байхгүй, томоохон компаниудын хүмүүст суусан байна. Жижиг үйлдвэрүүд бүтээгдэхүүн үйлдвэрлээд, зарахаа л боддог. Тэд үнээр л өрсөлдөж байна” хэмээн тодорхойлсон. Нээрээ ч тийм. Жишээ нь “Говь” компани сүүлийн 4-5 жилийг олон улсын брэндийн туршлагыг судалж, танилцахад зориулжээ. Гэтэл ноос, ноолуурын зарим жижиг үйлдвэрийн хувьд гаднаас ирсэн захиалгыг цаг хугацаанд нь нийлүүлж л байвал болоо гээд сэтгэл цадаад, юун брэнд манатай суудаг тухай тус салбарын үйлдвэрлэгчдийн төлөөлөл нуугаагүй.

Дан ганц уул уурхайд суурилах биш, Монгол Улс юун төлөө мал аж ахуйн орон гэгддэг билээ. Малын гаралтай түүхий эдээ боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн болгон, улмаар брэнд бий болгох чиглэлд хаана хаанаа анхаарч ажиллаж мэдэгдэхүйц үр дүн гаргах шаардлага бий. Бусад орны туршлагаас харахад ялангуяа хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнүүд ихэнхдээ дэлхийн брэнд болсон байх нь бий. Энд гэхдээ төр,түмний дэмжлэг ихээхэн хувь нэмэртэй нь ойлгомжтой. Харин Монголын хувьд хөдөө аж ахуйн брэнд маркетингийн асуудалд тун бага анхаарч ирсэн тул дөнгөж өнөөдөр л энэ тухай ярьж, нэгдсэн ойлголттой болохоор цугларааД буй хэрэг. Гэхдээ хэрэгцээ шаардлагаа мэдрээд нийгэм эдийн засгийн бүх талын төлөөллийг оролцуулж, ярьж эхэлнэ гэдэг ирээдүйн амжилт байж болох талтай.

“Mongolian Economy” сэтгүүл Монголын эдийн засгийн чуулганд зориулсан энэхүү тусгай дугаартаа Монголын брэндийг хэрхэн бий болгох талаар олон хүний санаа оноо, үзэл бодлыг тусгалаа. Энэ сэдвээр сэтгүүлчийн бичсэн нийтлэлүүдээс гадна мэргэжлийн хүмүүсийн үнэ цэнэтэй судалгаа, зөвлөгөөг ч оруулав. Арьс шир, ноос ноолуур, мах, сүүний үйлдвэрлэл гээд ерөнхийдөө хөнгөн үйлдвэрийн салбар брэндийн талбарт хүч үзэхэд бэлэн зогсоно. Алиныг нь ямар төрлийн брэндээр хөгжүүлэх, хувийн хэвшил юу хийж ирсэн, цаашид юу хийж чадах, төр, засгийн дэмжлэг ямар байх гээд булт олноороо хэлэлцэж, буруу зөвөө нээлттэй ярилцаж суугаа нь олзуурхууштай. Азийн цээжинд од болон гялалзаж буй Монгол Улс брэндийн нэр хүндийг бий болгож, уул уурхайн бусад боломжоо ашиглан эдийн засгийн олон суурьтай болох нь ээ. ■

ЧУУЛГАН

Н.АЛТАНХУЯГ:
МОНГОЛ БРЭНД ГАРГАХАД ТӨРИЙН ЗҮГЭЭС ХИЙХ АЖЛАА ШУУД ЭХЛҮҮЛНЭ



Монголын эдийн засгийн чуулган болж буйтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг "Mongolian Economy" сэтгүүлийн тусгай дугаарт байр сууриа илэрхийллээ.

И.ЖАРГАЛ

Байгалиараа гэдэг ойлголт Монголын гол таних тэмдэг

-Жил бүр болдог "Монголын эдийн засгийн чуулган"-ы далайц, хүрээг та хэрхэн үнэлдэг вэ? Засгийн газрын тэргүүний хувиар энэ жилийн чуулганаас ямар үр дүнг хүлээж байна вэ?

- Ер нь олон салбарын төлөөллийг оролцуулж, олуулаа хэлэлцэж байж аливаа асуудлын шийдэл нь зөв гарна. Төрийн байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгэм гэсэн гурван тал зэрэгцэж суугаад үзэл бодол, мэдээллээ солилцож байна гэдэг их чухал. Ингэж оролцооны тэнцвэр хангаж чаддагт л Монголын эдийн засгийн чуулганы гол үнэ цэнэ оршдог юм. Бидний хүсээд, яриад байгаа шинэчлэлийн гол цөм ч бас олон талын оролцоог бүх шатанд хангах юм шүү дээ. Шинэчлэлийн Засгийн газраас үнэт баялаг болсон хүн рүүгээ чиглэсэн олон бодлого, үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр мөрийн хөтөлбөртөө тусгасан. Хамгийн чухал амлалтын нэг бол иргэдээ ажилтай орлоготой болгох. Үүнтэй энэ чуулган ч гэсэн хамааралтай.

-Энэ жилийн чуулганаар "Монгол брэнд" сэдвийн хүрээнд төвлөрч ярилцахаар болсон нь анхаарал татаж байна. Чухам яагаад энэ сэдвийг чухалчлан хөндөх болсон бэ?

-Монголчууд өөрсдөө үйлдвэрлэгч болж, эх орныхоо зогсолтгүй хөдөлгүүр нь байвал эдийн засаг тогтвортой хөгжинө гэж үзээд Монгол брэнд гэсэн том зорилго өмнөө тавьсан хэрэг. Энэ удаагийн чуулганыг чухам үүнд чиглүүлж байгаа учраас нэлээд том үр дүн хүлээж байна. Монголын эдийн засгийн гол хөдөлгөгч нь уул уурхай гэж бид олон жил ярилаа. Хэдийгээр энэ нь хэн ч үгүйсгэхгүй үнэн боловч эдийн засаг ганц салбараас хамааралтай байж болохгүй. Тиймээс ч эдийн засгаа төрөлжүүлж, олон тулгууртай болгон солонгоруулахад төрийн бодлого чиглэдэг. Монгол

хүний хийж болох, үйлдвэрлэж чадах олон шинэ салбарыг төр дэмжин нээж өгөх ёстой. Бид нэг л асар том хүсэл тэмүүлэлд нэгддэг шүү дээ. Энэ бол үндэсний биш, бүс нутгийн биш, дэлхийн түвшний брэндтэй болох тэмүүлэл. Бидэнд тийм боломж, нөөц хангалттай бий. Гагцхүү брэндийг хэн, хэрхэн үйлдвэрлэх вэ гэдэг хамгийн том асуулт байсаар ирлээ. Брэндийг хувийн хэвшил өөрсдөө л үйлдвэрлэнэ. Иймээс хувийн хэвшлийнхэн маань Монголыг таниулах брэнд гаргахад ямар бэрхшээл байна, хаанаа юуг бид хамтран шийдэх хэрэгтэй байна гэдгийг Монголын эдийн засгийн чуулганаар хэлэлцэнэ. Авлига, хүнд суртал, ачаалал дараалал, лиценз, тусгай зөвшөөрөл, бүртгэл гээд чухам ямар байдлаар төр саад болж байна, гадаад зах зээл нээх, экспортыг дэмжих эрх зүйн орчин бүрдүүлэх, татварын хөнгөлөлт эдлүүлэх зэрэг арга замаар яг хаана нь төрийн дэмжлэг шаардлагатай байна гэх мэтчлэн олон асуудлын гаргалгаа шийдлийг бид сонсоно. Нөгөө талаас, эдгээр асуудлыг шийдвэрлэхэд төр бэлэн байна уу гэдгийг судлаачид, иргэний нийгмийнхэн шинжилж, санал бодлоо илэрхийлнэ. Мэдээж, төр бодлого чиглэлээ хэлнэ. Ингэж хоорондоо ярьж ойлголцон нэг цэг дээр хүрнэ гэдэг маш чухал. Төрийн дэмжлэг, хувийн хэвшлийн хүсэл, зориг тэмүүллийн нэгдэл дээр үндэсний брэнд бий болно шүү дээ. Брэнд гаргах гэдэгт нарийн чимхлүүр олон агуулга багтана. Брэнд гэдэг үг “шатаах, тамгалах” гэсэн норвеги үгнээс гаралтай. Өөрөөр хэлбэл, энэ зүйлийг зөвхөн би хийж чаддаг гэдгээ батлан тамгалж байгаа хэрэг. Монголын хувийн хэвшлийнхэн энэ өрсөлдөөн дунд чухам юуг чадна гээд тамгалж чадах вэ? Тэр зүйлийг төр дэмжихэд бэлэн байна. Харин юу байх вэ гэдгийг Монголын эдийн засгийн чуулганаараа ярилцана. Үндэстнээ илэрхийлэх гол тодорхойлолт маань чухам юу вэ гэдгээс л эхэлнэ. Жишээ нь, үйлчилгээний бизнесээр солонгосчууд асар өндөр нэр хүндтэй. Тэндээс ямар ч үйлчилгээ авсан сэтгэл хангалуун гарна гэсэн ойлголт дэлхийн хүмүүст бий болчихсон байна. Энэ бол брэнд. Японд очвол сайн чанарын электрон бараа, Германаас сайн чанарын автомашин авна гэж бусад нь итгэдэг. Хүний нөөц ихтэй Хятадад зах зээлээ тэлбэл сайн худалдаа явуулах боломжтой гэж итгэдэг. Энэ маягаар үндэстэн бүхэнд брэнд байна. Тэгвэл Монгол ямар нэрээр танигдах боломж байна вэ гэхээр “Монгол бол натурал” гэж хардаг болох хэрэгтэй байна. Байгалиараа гэдэг ойлголт бидний гол таних тэмдэг болмоор байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улс цэвэр байгалийн гаралтай бараа бүтээгдэхүүнээрээ брэнд болох ёстой. Хувийн хэвшлийнхэн маань ийм брэнд гаргахад төрөөс учруулж буй тээгийг арилгаж, үндэсний брэндээ дэлхий дахинаа таниулахад бодит дэмжлэг үзүүлэн хөгжүүлбэл түүнийг дагаад маркетинг, үйлчилгээний соёл төгөлдөршинө.

-“Монгол брэнд” сэдэвт чуулганаас гарсан санал санаачилгыг богино хугацаанд хэрэгжүүлээд үр дүнд хүрэх боломж бий юү. Өмнөх жилүүдийн форумаас гарсан зөвлөмж, санал санаачилгууд хэрхэн хэрэгжиж байгаа нь одоогоор тодорхой харагдсан зүйл алга байна л даа.

-Аливаа үйл ажиллагаанд олон янзын санал шүүмж гарах нь мэдээж. Өмнөх жилүүдийн эдийн засгийн форумын талаар олон нийтийн зүгээс надад хэлж байсан санаа юу вэ гэвэл, ярьсан асуудлын үр дүн гарахгүй байна, ноднингийн ярьсан зүйл яасан бэ гэсэн шүүмжлэлтэй асуулт тавьдаг. Чуулган хөндсөн сэдвээсээ их хамаарч байна л даа. Өмнөх жилүүдэд ногоон эдийн засаг, инноваци гэх мэт урт хугацааны бодлогын сэдэв сонгож ирсэн. Энэ бол өнөөдөр яриад маргааш нь шийдвэрлэгдэж, үр дүн гардаг асуудал биш. Байгаль орчны асуудал гэхэд л он удаан жилийн турш зөв бодлого хэрэгжүүлж байж үр дүн нь харагдана. Тэглээ гээд ярихгүй орхиж болохгүй, хөндөж байх ёстой чухал сэдвүүд. Энэ уламжлалыг ч бид энэ жил орхигдуулахгүй, форумын хоёр дахь өдөр дээрх чиглэлүүдээр мөн л ярина. Харин үндсэн сэдэв болох монголчууд нэгдээд юу босгож чадах вэ гэдгийг тодорхойлох чиглэлээр нэлээд том хүрд эргэнэ гэдэгт эргэлзэхгүй байна. Монгол Улсын брэнд гаргах тал дээр бүх талын чиг зорилго нэгдсэний дараа төр өөрийн зүгээс хийх ажлаа шууд эхлүүлэх болно. Жилийн дараа гэхэд тодорхой барих юмтай болно гэдэгт итгэлтэй байна.

-Засгийн газраас чухам аль салбарт үндэсний үйлдвэрлэлээ түлхүү хөгжүүлэх бодлого баримталж байгаа вэ? Байгалийн, натурал гэх Монголын брэндийн гол тодотголыг аль салбарт дэмжин хэрэгжүүлэх чиглэл төлөвлөгөө байна вэ?

- Засгийн газрын бодлого хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт үндэсний брэнд бүтээгдэхүүн гаргахыг түлхүү дэмжих бодлого барьж байгаа. Үйлдвэрлэлийн болон бусад чиглэлээр манай хувийн хэвшлийнхэнд маш том зорилго, хүсэл тэмүүлэл байна. Ардчилсан намаас орон даяар хэлэлцүүлсэн “Монгол хүн-2020” хөтөлбөрийн хүрээнд бүх салбарынхныг маш өргөн хүрээнд сонссон, түүнийгээ ч шинэчлэлийн Засгийн газрын мөрийн хөтөлбөр, бодлогод тусгасан. Тиймээс хувийн хэвшлийнхний санаа зорилго Засгийн газрынхтай нэг чиглэлд байгаа гэж үзэж болно. Энэ удаагийн чуулганаар илүү нягт баримт тооцоотой бодитой зүйл ярьж, илүү ажил хэрэгч хандлага руу орно. Иймд хувийн хэвшил, иргэний нийгэм, эрдэмтэн судлаач, төрийн албан хаагчид гээд форумын бүх талын төлөөллүүд идэвхтэй оролцож, санал санаачилгаа бүтээлчээр гарган хэлэлцүүлэхийг уриалъя. ■

МАХ

“АЗ ЖАРГАЛТАЙ” МАЛЫН МАХ

Э.ЗОРИГТ

Европын “аз жаргалтай” малын мах гэх шинэ ойлголт нь монголчуудын хувьд байдаг л зүйл ажээ. Бага залуу малыг нядалдаггүй монгол уламжлал, 100 хувь органик, эрх дураараа бэлчээрлэж өвсний шимтэй, усны тунгалгаар ундаалж өсдөг учраас л европчууд “Happy animal” буюу “аз жаргалтай малын мах” гэдэг аж.

Монголчууд мах экспортлох тухай 20 жил, махыг брэнд болгох талаар хэд хэдэн Засгийн газар дамжин ярьсан. Гэхдээ Уралын нурууг давсан нь үгүй. Улаан-Үүд, Эрхүүгээс хол явсангүй. Юутай ч брэнд бий болгох мөрөөдөл, дотооддоо эрүүл аюулгүй хямдхан мах идэх зорилгоо хэрэгжүүлэхийн тулд цөөнгүй асуудлыг шийдэх болоод байна.

Монгол малын мах экспортлоод зогсохгүй улсынхаа нэрийг дэлхийд гаргах брэнд бүтээгдэхүүн бий болгох ёстой гэдэгт монголчууд итгэдэг.

Брэндийг хэрэглэгчийн болон үйлдвэрлэгчийн гэж ялгаатай авч үздэг аж. Бид өөрөө өөрсдийнхөө үзэл бодол саяхан хийсэн сонголтоороо өөрийгөө тодорхойлж байдаг. Мөн үйлдвэрлэгч талаасаа брэнд бүтээгдэхүүн өрсөлдөгчөөс нь ялгах бүхий л шинж чанаруудын нийлбэр, хэрэглэгчдэд өгөх амлалтын цогц гэдэг. Тэгвэл бид тэдэнд ямар амлалт өгч чадах вэ. МҮХАҮТ-ын санаачилгаар хэрэгжиж буй “Үндэсний брэндийн маркетинг” хөтөлбөрийн удирдагч, олон улсын маркетингийн зөвлөх Стивен Креппел “Бидний том зорилго бол Европын зах зээл. Дэлхий нийт тэр дундаа европчууд байгальд ээлтэй байх тал дээр ихээхэн анхаардаг болжээ. Цэвэр байгалийн, органик, үл харгислал (cruelty-free) бүхий мах хэрэглэх хандлага европчуудын дунд ажиглагдах болсон нь монголчуудын хувьд сайхан боломж” гэсэн юм. Европын нэгэн



ФОТОГ Э.Зориг

судалгааны байгууллагаас Европ хүмүүсийн 40 орчим хувь нь “аз жаргалтай” малын махыг хүнсэндээ хэрэглэхийг эрмэлздэг гэх судалгаа гаргасан байна. Тэдний энэ шинэ ойлголт нь монголчуудын хувьд байдаг л зүйл. Учир нь, бага залуу малыг нядалдаггүй монгол уламжлал, 100 хувь органик, эрх дураараа бэлчээрлэж өвсний шимтэй идэж, усны тунгалгаар ундаалж өсдөг махыг л европчууд “Happy animal” буюу “жаргалтай малын мах” гэдэг аж. Европын зах зээлд бэлчээрийн малын мах арилжааны зорилготой үржүүлсэн малынхаас хэд дахин үнэтэй. Тэгэхээр монголчууд бэлчээрийн малын махаа сурталчилж чадвал боломж байна гэсэн үг. Органик, “жаргалтай” малын мах Монголын брэнд.

Монгол Улс малынхаа махыг экспортлох эрмэлзлэлтэй. Гаднынхан ч Монголоос мах авах сонирхолтой. Урд, хойд хоёр хөрш төдийгүй Зүүн өмнөд Ази, Ойрхи Дорнодын орнууд монгол малын мах авах санал ирүүлдэг. Учир нь, Монгол мал аж ахуйн орон. Өнгөрөгч оны эцэст манай улс нийт 40.9 сая толгой мал тоолуулсан. Гэхдээ эрэлт нийлүүлэлтийн хүсэл сонирхол байгаа ч экспортод гардаг дээрээ гацчихдаг гэмтэй.

Монгол Улс жилд дунджаар 10 гаруй мянган тонн мах экспортолдог гэх тойм мэдээ бий. Экспортын махны 90 гаруй хувийг нь уламжлалт харилцаатай хойд хөрш рүү гаргадаг бол Япон улс адууны мах маш бага хэмжээгээр авдаг. Түүнчлэн урд хөрштэй Засгийн газрын түвшинд дулааны аргаар боловсруулсан махыг экспортлох гэрээ хэлэлцээр хийсэн боловч одоогоор бичиг цаасны түвшинд яваа аж. Махны экспортын өнөөгийн байдал малаар баян Монголын хувьд чамлалттай үзүүлэлт. Дээрээс нь өнгөрөгч оны дундаас махны экспорт огцом буурчээ. Экспорт хумигдсан шалтгаан нь Засгийн газрын махны экспортод тавьсан хоригтой холбоотой. Хэрвээ уг хориг гараагүй бол Монголын махны холбоо /ММХ/-ны тооцоолсноор өнгөрөгч онд 20 мянган тонн мах экспортлох боломжтой байсан гэнэ. Тус холбооны гүйцэтгэх захирал М.Жадамбаа “Засгийн газраас махны экспортыг өнгөрсөн оны арванхоёрдугаар сараас энэ оны гуравдугаар сарыг дуустал хориглох шийдвэр гаргасан. Энэ нь дотоодын махны үнэ хэт өссөнтэй холбоотой. Ер нь Засгийн газар махны экспортын асуудлыг төдийлэн авч хэлэлцэхгүй байх шиг санагддаг. Эхлээд дотоодын хэрэгцээгээ бүрэн хангах. Цаашлаад онц байдалд хэрэглэх нөөц бүрдүүлсний дараа үлдсэн махаа экспортлох талаар ярьдаг. Харин хувийн хэвшлийнхэн махаа экспортолж, дэлхийн зах зээлд өрсөлдөхийг хүсдэг” гэв. Дотоодын зах зээлд махны үнэ толгойны өвчин болдог нь үнэн. Бодлого тодорхойлогч нар махны нийлүүлэлт, түгээх арга хэлбэр оновчгүй, экспорт хяналтгүй байгаа нь дотоодын зах зээлд үнэ хөөрөгддөг гэж үздэг. Гэхдээ дээрх асуудлуудын аль аль нь шийдэгдсэн нь үгүй. Угтаа бол эдийн засгийг төрөлжүүлэх гэдэг утгаараа монгол малын махыг экспортын чиг баримжаатай болгох нь зөв баймаар. Цаашлаад брэнд болгон “алдаршуулах” нь уг бүтээгдэхүүний дотоод, гадаад асуудлыг шийдэх гарц гэдгийг мэргэжилтнүүд онцлон хэлж байна.

Эрүүл ахуйн асуудал эдийн засгийг төрөлжүүлнэ

Монгол малын мах эрүүл ахуйн асуудалд хасах үнэлгээ авдаг нь гаднын хэрэглэгчдийг монгол махнаас татгалзахад хүргэдэг. Тиймээс гаднынхан Монголд дэлхийн стандарт бүхий махны томоохон үйлдвэр байгуулах санал тавьдаг гэнэ. Гэхдээ үйлдвэр барихаасаа урьтаж малаа зөв тоолох, гарал үүслийн болоод бэлчээрийн дэлгэрэнгүй мэдээллийн сан бий болгох учиртай аж. Францын мал аж ахуйн хүрээлэнгийн ажилтан Беатрис Балвэ “Махны нийлүүлэлт, түгээх арга хэлбэр оновчгүй. Хэн хаанаас ямар мах авдаг нь тодорхойгүй байдлыг халах, цаашлаад мах экспортлогч орон болохын тулд юуны түрүүнд мал сүргээ бүртгэлжүүлэх хэрэгтэй” гэсэн юм. Хүнсний аюулгүй байдал монголчуудын хувьд тулгамдаад байгаа өнөө үед ямар ч баталгаагүй, эрүүл ахуйн шаардлага хангаагүй махыг ард иргэддээ өндөр үнээр зарах нь хэтэрхий аз сорьсон хэрэг гэдгийг Стивен Креппел хэлсэн. Дээрээс нь Монгол мал дураараа бэлчээрлэж, өвсний шимтэйг сорчлон иддэг. Тэр утгаараа манай нутаг бүрийн малын мах өөр өөрийн онцлог шинж чанартай. Тиймээс малыг бүртгэлжүүлэхэд бэлчээрийн хувьд ангилах асуудлыг хамруулах нь гаднынхан аль маханд өндөр үнэ төлөх вэ гэдгийг судлах боломжийг бүрдүүлэх юм. Тухайлбал, Монголын тал хээрийн болон хангайн бүсийн хонины мах, адуу, үхрийн мах брэнд болох боломжтой гэдэг судалгааг ММХ гаргасан байна.

Махны үйлдвэрлэлд дараагийн нэг тулгамдсан асуудал нь эгзэгтэй цэгийн хяналт буюу Hazard analysis and critical control points / HACCP/ гэх чанарын системийг нэвтрүүлэх аж. Гаднын аль ч оронд мах экспортлохын тулд уг чанарын системийг зайлшгүй нэвтрүүлэх шаардлагатай байдаг. Уг стандарт нь малын үүсэл гарлаас эхлээд хүнсний бүтээгдэхүүн болох хүртэлх бүхий л шатны үйл ажиллагааны эрүүл ахуйн асуудлыг даадаг дэлхийн стандарт юм. Одоогоор HACCP-ийг “Мах маркет”, “Дархан мийт фүүдс” зэрэг ганц хоёр компани л нэвтрүүлээд байна.

Зөөж чадахгүй бол зарж чадахгүй

Нөгөө л логистикийн сул хөгжил дотоодын махны үнэ, экспортод саад болдог хэвээрээ. Монголд мах бэлтгэлийн нэгдсэн ситем үгүйлэгдээд 20 гаруй жилийг үдэж байна. Стивен Креппел “Логистик гэдэг бол тухайн бүтээгдэхүүн хэрхэн бий болохоос эхлээд хэрэглэгчид эрүүл аюулгүй бараа бүтээгдэхүүн хүрэх үйл явц юм. Тухайлбал, монгол малын махыг хэрэглэгчдэд эрүүл аюулгүй хүргэхийн тулд 21 аймаг, алслагдсан сумдаас ирж байгаа махыг нэгдсэн нэг тээвэрлэлтээр нэг газар төвлөрүүлэх. Тухайлбал, Сэлэнгэ аймагт хүргэх ч юм уу. Тэндээсээ Улаанбаатар хот орох,

цаашлаад гадагш гаргах төвлөрсөн тээвэрлэлтийн системтэй болж чадвал логистикийн асуудал эмх цэгцэнд орно" гэв. Монголд нэг үеэ бодоход байдал арай дээрдэж байна гэж хэлж болох. Одоогоор "Мах маркет" компани 11 аймагт мах боловсруулах үйлдвэртэй бөгөөд малчны хотноос нэг малыг ч гэсэн зах зээлийн үнээр авдаг аж. Энэ нь малчдад дундын зуучлалгүйгээр арилжаа хийх орчинг бүрдүүлснээр малаа ашигтай зарах боломжийг бий болгодог байна. Тиймээс "Мах маркет"-ийн туршлагад тулгуурлан логистикийн сүлжээг орон даяар бий болгох тал дээр Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам, Монголын махны холбоо хамтраад малчин, бэлтгэн нийлүүлэгч компани хоёрын харилцааг сайжруулах хуулийн төсөл дээр ажиллаж байгаа гэсэн. Малчин малаа бэлтгэн нийлүүлэгчид хэн нэгнээр дамжуулалгүй шууд зарсан тохиолдолд тодорхой хэмжээний урамшуулал олгох талаар уг хуульд оруулах аж.

Бас нэгэн эрэлт

Ойрхи Дорнод, Хятад болон Арабын орнууд удаан чанаж болгосон маханд дуртай байдаг аж. Харин монгол малын мах чанах тусам амт ордог. Тиймээс энэ эрэлтэд тулгуурлан махаа экспортод гаргаж болох юм. Стивен Креппел "Монгол Улсын хувьд Ойрхи Дорнод, Арабын орнуудад махаа брэнд болгох гарц байгаа. Тухайлбал, Францын тогооч нартай хамтарч болно. Тэдэнд махыг чанах тусам амт оруулдаг нууц жор бий. Харин монгол мах чанах тусам амт, үнэр, зөөлөн чанар нь гойд сайжирдаг онцлогтой. Тиймээс Франц тогооч нарыг эх орондоо авчирч тэдэнтэй хамтарч, зөвхөн тэдэнд зориулсан мах бэлтгэвэл бас нэгэн шинэ брэнд үүсэх боломжтой" гэлээ.


Сонголт хийхийн тулд

Европод ч гэсэн бидэнд өрсөлдөгч бий. Тухайлбал, Японы "Вагюү" нэртэй брэнд мах дээрх зах зээлд хэдийнэ танил болжээ. Уг үхрийн мах нэг килограмм нь л гэхэд 330 гаруй мянган төгрөгийн үнэтэй аж. Ийм үнэтэй байдаг нь олон зүйлээс шалтгаалдаг.

Европын дэлгүүрт ороод мах авлаа гэхэд Та зөвхөн мах бус чанарын баталгааг хамтад нь худалдаж авдаг аж. Мөн худалдан авагчийн зүгээс үйлдвэрлэгчдэд өндөр шаардлага тавьдаг болсон. Тухайлбал, 20 эсвэл 30 жилийн өмнө аливаа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж буй улс орон, үйлдвэрлэгч компани худалдан авагчдад заавал таалагдах албагүй байжээ. Харин өдгөө худалдан авагч өөрийн сонголтоо хийхийн тулд үйлдвэрлэгч компанийн оршин буй газар орон, нэр хүнд, компанийн засаглал, үйл ажиллагааны ил тод байдал, мөн тухайн компанийн үнэт зүйл нь юу вэ гэдэгт ихээхэн анхаардаг болсон байна. Энэ мэт олон шаардлагыг хангаж чадвал махны үнэ тэнгэрт гарсан ч худалдан авагчаа алддаггүй. Хэрвээ үйлчлүүлэгчийн зүгээс ямар нэг санал, гомдол гарвал тухайн махыг боловсруулсан үйлдвэр, нядалсан газар цаашлаад үржүүлж өсгөсөн эзэнд нь хүртэл хариуцлага тооцдог байна. Тиймээс Монгол Улсад үйлдвэрлэсэн юм бүхэн найдвартай гэх ойлголтыг бий болгох, түүнийгээ батлах нь брэндийн хамгийн том шалгуур ажээ.

Арааралаа дүүрэн ай түмэн адуутай, өвөрөөө дүүрэн үй түмэн хоньтой монголчууд таван хошуу малаа уулынхаа аманд хураагаад л байх уу. Эсвэл Монголын гэх цоо шинэ брэнд бий болгох уу. Хэрвээ Монгол Улс малынхаа махыг брэнд болгож чадвал малчид маань Монголын төдийгүй дэлхийн санхүү, эдийн засгийн нөлөө бүхий тоглогчид болж "тамирчин" малын махыг таван тивийн хүмүүс амтлах боломжтой болох юм. ■

Мах үйлдвэрлэл /тонн/



Малын тоо толгой/сая/

Аймаг сум	Малын төрөл	2009	2010	2011	2012
Улсын дүн	Бүгд	43,981.01	32,729.53	36,335.78	40,920.92
	Адуу	2,221.31	1,920.34	2,112.93	2,330.43
	Үхэр	2,599.33	2,176.00	2,339.70	2,584.62
	Хонь	19,274.73	14,480.40	15,668.53	18,141.36
	Ямаа	19,651.52	13,883.21	15,934.56	17,558.67
	Тэмээ	277.05	269.577	280.062	305.835
Баруун бүс	Бүгд	10,888.36	7,418.46	8,525.36	9,670.83
Хангайн бүс	Бүгд	16,716.23	12,216.47	13,472.39	15,379.51
Төвийн бүс	Бүгд	10,484.07	7,557.95	8,448.84	9,463.89
Зүүн бүс	Бүгд	5,491.54	5,273.76	5,610.28	6,098.22
Улаанбаатар	Бүгд	400.825	262.881	278.919	308.46

Эх сурвалж: УСХ

www.mongolianeconomy.mn

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

ТУСГАЙЛАН СОНИРХОХ ТУСГААР МОНГОЛ

Б.ЭНХЦЭЦЭГ

Оновчтой тодорхойлолт хүнд сэтгэл хөдлөл мэдрүүлдэг гэж аялал жуулчлалын брэндийг тодорхойлжээ.

Энэг хүн тэнүүчилж, ухаант хүн жуулчилдаг" хэмээн Их Британийн зохиолч, санваартан Томас Фүллэр нэгэнтээ хэлсэн байдаг. Хил давсан бүхэн гийчин гэвэл өрөөсгөл. Хүний нутагт хүний хүн шиг бус өөриймсөг хандаж, сэтгэлийн цэнгэл эдлэх боломжийг аялал жуулчлалын зөв менежмент, маркетинг олгодог. Өнөөдөр дэлхий дахинд ихээхэн яригдаж буй Тогтвортой аялал жуулчлалын үндэс нь байгалийн болон уламжлалт соёлын хамгаалалт. Модны үндсийг нэгэнтээ газарт суулгасан бол иш, нахиаг нь ч үндэснээс дутуугүй тордох нь зүйн хэрэг. Тэгвэл Монголын аялал жуулчлалын салбар нүүрээ угаан, нуухаа цэвэрлэж, бусдын өөдөөс Монгол гэсэн өвөрмөц дүрээр инээмсэглэх цаг нь болжээ.

Монгол "төрхийг" гаднынхан хэрхэн төсөөлдгийг тайлбарлах хэцүү. Чингисийн нутаг, нүүдэлчин соёл, үзэсгэлэнт байгаль, уул уурхай гэхчлэн олон тийш савчсан ойлголттой. Нэг үеэ бодвол Монголыг мэдэх хүн олширсон ч Хятадын муж улс цаашлаад оршин тогтнодог эсэхийг мэддэггүй хүмүүс ч бий. Сүүлийн үед уул уурхайд орж ирэх хөрөнгө оруулалтаас үүдэн дэлхийд Монголыг "Уул уурхайн тэсрэлт орон" гэж нэрийдэх боллоо. Бусдын алжаалыг тайлах, сэтгэлийн цэнгэл эдлүүлэх зорилготой аялал жуулчлалын салбарынхны хувьд энэ нь хүсэхээр таних тэмдэг биш. Монгол "Discover Mongolia" гэх уриагаар уул уурхайн салбараа дэлхийд хүргэж чадсан шиг аялал жуулчлал ч энэ хэмжээнд нэрээ гаргах боломж бий гэдэг. Монголын аялал жуулчлалын холбооноос салбарын имиж бий болгоход учирч буй бэрхшээлийг төрийн нэгдсэн бодлогогүй, тогтворгүй уриа, нэрээр олон улсын үзэсгэлэнд оролцдог, хувийн хэвшил, ТББ-ынхан тусдаа сурталчилгаа хийдэг зэрэгтэй холбон тайлбарласан байдаг. "Жуулчдыг Монголд ирэхийг уриалж, сурталчилгаандаа их мөнгө зардаг ч дорвитой үр дүн гардаггүй. Энэ нь маркетинг сурталчилгааны нэгдсэн зөв ойлголтгүй байгааг харуулж байна" хэмээн "Нью жуулчин" компанийн захирал Ш.Нэргүй хэлсэн юм.

Улс цаашлаад салбар, орон нутгийг төлөөлөх брэнд бий болгох асуудал хурцаар гарч ирж байгаа. Өнгөрсөн хугацаанд аялал жуулчлалын компаниуд байгаа боломж, бололцоогоо бүтээгдэхүүнээр тодруулж, гаднынханд худалдаж ирсэн нь төрд тоогдож байгаагүйгээс улбаатай гэх хүн цөөнгүй. Нэг яамны халааснаас нөгөө рүү шилжиж өдийг хүрсэн аялал жуулчлалын салбар өдгөө Соёл, спорттой нийлээд байгаа. Атгасан гар шиг зангидах нэгдсэн бодлого, чиглэл хэрэгтэй байгааг салбарынхан өөрсдөө ч хүлээн зөвшөөрч, цэгцэнд нь оруулаад өгөөч гэж гуйх нь холгүй байна. Соёл, спорт аялал жуулчлалын яам олон ажил хийхээр төлөвлөж байгаагаа хувийн хэвшлийнхэнд танилцуулсан. Үүний нэг нь Монгол брэнд. "Цэрэн турс" компанийн захирал Э.Цэрэндолгор "Монголын аялал жуулчлал асар үнэтэй өвөрмөц салбар гэдэг имижийг дэлхийд өгөх нь чухал" хэмээн онцолсон юм. Нүүдэлчин соёл, унаган байгаль, түүх соёл, ховор ан амьтан зэрэг Монголыг төлөөлөх олон зүйл бий. Гэвч яг алиныг нь тэргүүндээ залах вэ гэдгийг тогтох нь зайлшгүйг салбарынхан төдийгүй олон улсын мэргэжилтнүүд

хэлж буй. Мөн тэдний зарим нь гаднын томоохон мэргэжилтнүүдийг Монголын брэндийг бий болгоход татан оролцуулах хэрэгтэй ч гэж үзэж байна.

Аялал жуулчлалын салбараа дэлхийд хүлээн зөвшөөрүүлнэ гэдэг тухайн улс нэрээрээ дамжуулан тодорхой онцлог шинжээ хүний төсөөлөл, хүртэхүйд шууд хүргэж чаддаг болно гэсэн үг. Аливаа орон руу аялахад тухайн улсын бусдаас ялгарах онцлог шинж нь санаанд буудаг. Дэлхийн аялал жуулчлалын судалгааны байгууллагын ерөнхийлөгч Аластэр Моррисон "Бусад улс шиг болохыг хичээх бус тэднээс хэрхэн ялгарч болохыг Монгол анхаарах нь зүйтэй. Монголд нүүдэлчин соёл, Чингис хаан, аугаа түүх зэрэг онцлог олон байна" хэмээн Монголын аялал жуулчлал 2013 чуулган дээр хэлсэн юм. Тус чуулганы үеэр нүүдэлчин Монгол, морьтон Монгол гэх зэрэг имижтэй болох санал оролцогчдоос гарсан. Гэтэл Монголд морины тоног хэрэгслийг мэддэгүй, морь унаж үзээгүй, малаа танихгүй залуус олширч буй. МУИС-ийн Аялал жуулчлалын тэнхимийн багш Э.Цоморлиг "Имиж гэдэг тухайн улсын салхи, хүнийх нь харцнаас мэдрэгддэг. Тийм имижийг л олох нь зүйтэй. Үүнийг зөвхөн сурталчилгаанд гоёо болгож ашигладаг бус салбарынхан болоод нийт иргэд нь ойлгодог байх ёстой" хэмээв.

Аялал жуулчлалын брэндинг гэдэг өнгө, үнэр, амт, дүрс, мэдрэмж, сэтгэл хөдлөл, төсөөлөл, хүндлэл, хүсэл зэргийг төрүүлж чадахуйц хэмжээнд байх ёстой гэж аялал жуулчлалын брэндингээр мэргэшсэн "Total marketing destination" компани үйлчлүүлэгчдээ зөвлөдөг.

Дэлхийн бусад улсын хувьд ерөнхий бодлого, чиглэлийг Засгаас зангидаж, Үндэсний аялал жуулчлалын байгууллага хэмээх институциар дамжуулан маркетинг хийдэг жишиг бий. Жишээ дурдъя. Австрали улсын Аялал жуулчлалын комиссоос анх 1995 онд өрнүүлсэн "Brand Australia" хэмээх санаачилга тус улсыг гадаад ертөнцөд уул уурхайгаас гадна аялал жуулчлалаараа танигдахад том түлхэц болсон байдаг. Эрх чөлөө, амар амгалан, өөдрөг сэтгэлгээг илтгэдэг гэж үздэг "Land down under" гэх гурван үг нь одоо аялал жуулчлал төдийгүй тус улсын үндэсний нүүр царайг тодорхойлох хэмжээнд хэрэглэгдэж байна. Австралийн аялал жуулчлалын Америк дахь PR менежер Зоё Шурголд "Бидний хувьд зөвхөн үзээд өнгөрөх бус энэ тивийг эд эсээрээ мэдрэх, бие сэтгэлийн эргэх холбоог бий болгох ерөнхий дүр зургийг бүтээнэ гэдэг том сорилт байлаа. Үүнийг бид Австрали нөлөөлөл гэдэг" хэмээн тэрбээр улсынхаа амжилтыг тодорхойлжээ. Энд мөн 1973 онд Тайландын аялал жуулчлалын газраас маркетингийн "Amazing Thailand" кампанит ажлыг эхлүүлсэн бөгөөд одоог хүртэл тус имижээ хадгалсаар байгааг онцолж болохоор байна.

Аль нь вэ?

Аялагчдыг уламжлалт болон тусгай сонирхлын гэж ангилдаг. Хувь хүний хүсэл сонирхлын дагуу зохион байгуулдаг аяллуудыг тусгай сонирхлын аялал жуулчлалд багтаадаг. Монголын аялал жуулчлалын салбарын үйл ажиллагаа нь олон улсын ангиллаар тусгай сонирхлын бүлэгт ордог байна. Манай улс тусгай сонирхлын аялал жуулчлалд өвлийн аялал жуулчлал, нүүдэлчин соёлтой танилцах, гэрэл зураг, ан агнуур палеонтологи зэрэг онцгой сонирхолд нийцсэн аяллын багцад багтааж, бүсчилж хөгжүүлэхээр төлөвлөж буйг Соёл, спорт, аялал жуулчлалын сайд Ц.Оюунгэрэл салбарын чуулган дээр хэлсэн. Аялал жуулчлалын сургалт судалгааны төв ТББ-ын тэргүүн Н.Гансүх тусгай сонирхлын аялал жуулчлалын талаар "Хэт олон зүйлд анхаарлаа хандуулахын оронд тодорхой нэг зорилттой байх нь бидний хувьд оновчтой хувилбар байж болох ч хамгийн зөв нь гэж хэлэхгүй" хэмээсэн юм.

Олон улсын зах зээлд санал болгох бүтээгдэхүүн олонтой нөхцөлд тэр дундаас улсынхаа нүүр царай болохыг нь сонгоно гэдэг толгой гашилгасан том сорилт гэдгийг дэлхий даяараа хүлээн зөвшөөрдөг. Дэлхийн аялал жуулчлалын судалгааны байгууллагын ерөнхийлөгч Аластэр Моррисон "Шинээр гарч ирж буй зах зээлийн хувьд тусгай сонирхлын аялал жуулчлал нь сайн стратеги. Энэ бол зөвхөн Азийн нэг хэсэгт дэлгэрээд байгаа бус дэлхийн аялал жуулчлалын нийтлэг хандлага болж байна" гэсэн юм.

Монголын аялал жуулчлалын салбарынхныг дэлхийд тахалдаг албан бус нэрийн хуудас бол нүүдэлчин соёл. Үүнийг Монголын аялал жуулчлалын 2013 оны чуулган дээр "Go nomadic, Experience Mongolia" хэмээх уриаг сонгосон салбарынхны санал хураалт харууллаа. Хэдий тийм ч аялал жуулчлалын удаан хугацааны тогтвортой имиж байж чадах эсэхт эргэлзэх хүн цөөнгүй. "Нүүдэлчин амьдрал хотжиж устана гэдэг бусдад гайхуулж, үзүүлэх соёлын маш том хэсэг алга болж байна гэсэн үг" хэмээн "Цэрэн турс" компанийн захирал Э.Цэрэндолгор хэлсэн юм. Бусад тив улсад нүүдэлчин соёл байдаг ч мөн чанараа алдаж тэнүүлчин, ядуу зүдүү гэх ойлголтыг төрүүлэхүйц хэмжээнд хүрсэн байдаг тухай баримт олон бий.

Монголоор овоглосон дэлхийд брэнд бүтээгдэхүүн болж болох нүүдэлчин ардын соёлоос улбаатай бүргэдийн баяр, тэмээний баяр, мөсний баяр тэргүүтэй арга хэмжээ монголд цөөнгүй бий болсон. Түүний нэг нь жил бүрийн баяр наадмын гурав дахь өдөр зохион байгуулдаг "Дээлтэй Монгол" хэмээх арга хэмжээ юм. Бусад улсад олон янзаар сэдэвлэсэн парад байдаг ч үндэсний хувцастай гэх тодотголтой нь байдаггүй гэх юм билээ.

Улс, хот, бүс нутаг болгон бусдаас ялгарах аялал жуулчлалын онцлогоо тодорхойлох нь нэн тэргүүнд тавигдах ёстой. Оновчтой тодорхойлолт хүнд сэтгэл хөдлөлийг мэдрүүлж, хүлээлт үүсгэдэг гэж аялал жуулчлалын брэндингийг тодорхойлжээ. Үүнээс үзэхэд манай улс юуг брэнд болгон хөгжүүлэхээс гаднынхан Монголыг тусгаар улсын тусгай улс хэмээн онцлон зорих нь. Брэнд бий болгох нь амар биш гэдгийг дэлхий орнуудын хэдэн арван жилийн туршлага харуулдаг. Тиймээс төр, хувийн хэвшил хамтран мэргэн оюунаа уралдуулан "сэрж", сэдэж, олон улсад дүрээ тодотгох шаардлага аялал жуулчлалын салбарт ирээд байна. ■



WAGNER ASIA AUTOMOTIVE LLC Tel: 99118301, 99118375, 99108303, 99108368



Ханийн ухаан, нөхрийн чанар, хүлгийн жолоо

Эр хүний илэрхийлэл...

НООС, НООЛУУР

БРЭНДЭД ОЙРХОН ИРЭЭДҮЙ

И.ОТГОНЖАРГАЛ



Гадаад зах зээл дээр брэнд болох зорилт тавьсан бол эхлээд хэрэглэгчийн анхаарлыг татах, сонирхлыг өдөөх, эдэлж чанарыг нь танихыг хүсэмжлэх, худалдан авах гэсэн брэндийн маркетингийн дөрвөн суурь үйлдэл байдаг.

Эхлэл

Могой жил гармагц Монголын хөдөө аж ахуйн салбарынхны цовхи өөдөө байна гэж хэлж болохоор. Хувийн хэвшил , мэргэжлийн холбоод, салбарын яамны мах, арьс шир, ноос, ноолуурын асуудал хариуцсан мэргэжилтнүүд тун завгүй. Тийм ч хурал, ийм ч семинар, тэр ч сайд дээр асуудал танилцуулах, энэ ч яаман дээр хуралтай гэдэг үгээр ам руу “шавхуурдах”. Сураглаад, мөрөөр нь мөшгөхөөр үнэхээр л завгүй, ярьж байсан асуудлаараа яг хуралтай байж таарах. Завгүй байх сайхан, аргагүй л Монголын хөдөө аж ахуйн салбараас брэнд төрөх гээд байгаа юм болов уу гэсэн гэрэлт бодол тээхэд гэмгүй. Ялангуяа ноос, ноолуурын салбарынхан өнгөрсөн сард олон ажил амжуулав. Тухайлбал, Цагаан сарын дараахан болсон “Үйлдвэржилтийн эрин үе ба ноос, ноолуурын салбар” сэдэвт улсын зөвлөлгөөнд өмнө байгаагүй олон төлөөлөгч оролцож, хагас өдөр хамаг л сайн муугаа ярьж амжиж, шинэ бодлого, зорилтоо тодорхойлж, төр засагт үгээ хүргэсэн. Түүнчлэн Хөдөө аж ахуйн биржийн бараанд тавих ямааны ноолуур, хонины ноос, сарлагийн хөөврийн шаардлагатай стандартуудыг шинээр баталж, орчин үеийн тоног төхөөрөмжтэй, олон мянган ажилтантай “Могол” ноосны үйлдвэр Төв аймгийн Зуун модод үүдээ нээсэн гээд чихэнд чимэгтэй мэдээлэл ар араасаа цуварсан. Ажил амьдрал буцалж байгаад баяртай байна. Нөгөө талаас Монголын эдийн засгийн чуулганы “Брэнд ба боломж” гэсэн шинэлэг сэдэв тус салбарынхныг ийнхүү бодлоо цэгцэлж, үгээ хурцлах түлхүүр болсон байж ч болох талтай. Монголд дэлхийн брэндэд ойрхон ирээдүйтэй салбар бий. Тэр нь ноос , ноолуур. Ингэж үзэх олон шалтгаан бий. “Говь”, “Гоёо”, “Буян”, “ Алтай кашмер” гээд ноолуурын үйлдвэрүүдийг хүмүүс андахгүй. Бараа бүтээгдэхүүнийг нь хот, хөдөөгүй хэрэглэдэг болсон. Брэнд бий болоход эрэлт байх ёстой. Тэгвэл монголчууд саяхан болтол /4-5 жилийн өмнө/ ноолууран бүтээгдэхүүнийг чинээлэг давхаргынхны эдэлж хэрэглэдэг тансаг бараа гэж үздэг байсан. Гэтэл сүүлийн жилүүдэд эл ойлголт өөрчлөгдөж, дулаан, биед

эвтэйхэн учраас ноолууран хувцасыг монголчууд өмсөх л ёстой юм байна гэсэн ойлголт нийгэмд хавтайрав. Цамц, малгай, хүрмээр тогтохгүй баяр ёслолоор ноолууран дээлээр гангардаг моод дэлгэрээд багагүй хугацаа өнгөрч байна. Мөн хэдэн жилийн өмнө бөхчүүд, урлаг, улс төрийн гээд олны танил хүмүүс ноолууран дээлээр гангарахыг чухалчилдаг байсан бол өдгөө Цагаан сарын бэлгэнд Баянхоногор аймгийн Баацагаан суманд суугаа малчин Доржид хүүхдүүд нь "Говь"-ийн 700.000-800.000 төгрөгийн үнэтэй зуун хувийн ноолууран дээл Цагаан сар, Шинэ жилийн бэлэг болгон өгөх нь энүүхэнд. "Говь" компани жилийн жилд Цагаан сарын үеэр ноолууран дээлний захиалгад дарагддаг болсон нь үнэн. Залгаад ноолууран пальтоны дотоод, гадаад захиалга ихэсдэг байх жишээтэй. Үүгээр юуг хэлэх гээд байна вэ гэхээр түүхий эдийн чанарын үзүүлэлтээрээ дэлхийд өрсөлддөг монгол ноолуурт монголчууд өөрсдөө итгэдэг болжээ. Итгэл гэдэг бол брэнд бий болгох үндсэн үзүүлэлтүүдийн нэг. Үйлдвэрлэгчид ч ноолууран бүтээгдэхүүнийг зөвхөн Монголдоо зараад зогсох биш, гадаад зах зээлд гаргахад анхаарч ирэв. "Говь" компани л гэхэд энэ чиглэлээр тодорхой бодлого төлөвлөгөөтэй ажлууд хийсээр байгаа юм билээ. Ноосны салбарт бол "Эрдэнэт хивс" компани олон өөрчлөлт, шинэчлэлтийг хийж буй аж. Нэг талаасаа үүнийг тухайн бизнесийн байгууллагын орлогоо нэмэгдүүлж, ашиг олох үйл явц гэж үзэж болох ч нөгөө талаасаа Монголоос нэг ч гэсэн брэнд төрүүлэх нь чухал. Брэндгийн талаар "Говь" компанийн Гадаад худалдааны газрын захирал Б.Ариунаатай уулзахад "Брэнд гэдэг нь нэр, лого гэхээсээ илүүтэй чанарыг тогтмол хадгалж байдаг баталгаатай бүтээгдэхүүн юм. Манай компани 2011 оноос гадаад дахь салбар дэлгүүрүүдийг хөгжүүлэх зорилго тавин ажиллаж байна. Одоогоор 11 улсад 36 салбар дэлгүүртэй. АНУ, Итали, Герман, ОХУ, Чех, Польш, Нидерланд, Австри, Латив, Казахстан зэрэг оронд өөрийн нэрийн дэлгүүр ажиллуулдаг. Сүүлийн хоёр жилийн хугацаанд дээрх улсуудад дэлгүүрээ нээж чадсан нь чамлахааргүй амжилт юм. Ирэх гурван жилд дэлгүүрийн тоогоо 100-д хүргэх зорилт тавьсан" гэв. Мөн эднийх 22 улсад "говь" логог бүртгүүлээд байгаа бөгөөд 2010 онд АНУ-ын үндэсний бүртгэлийн газарт бүртгүүлсэн анхны монгол компани болсон байна. Ариунаа захирал ч ноолууран бүтээгдэхүүний хэрэглээ зөвхөн дотоодод төдийгүй дэлхий нийтэд өөрчлөгдөж байгааг онцоллоо. Тэрбээр "Өмнө нь ноолууран бүтээгдэхүүнийг үнэтэй, 40-өөс дээш насныхан хэрэглэдэг гэсэн ойлголт байсан. Харин сүүлийн үед залуучууд их хэрэглэдэг болсон. Мөн ZARA цайвар шаргал, бор, хөх саарал гэсэн үндсэн дөрвөн өнгөтэй байдаг. Энэхүү байгалийн органик үйлдвэрлэл нь дэлхийд танигдах Монгол брэнд байж болох. Мөн тус компани 2010 оноос дэлхийн сүлжмэлийн салбарт алдар хүндтэй Италийн загвар зохион бүтээгч Saberio palatella-тай хамтарч ажиллаж "Gobi Saberio palatella" коллекци гаргажээ. Энэ мэт Монголын гэх онцлогийг гаргасан шилдэг загвар дизайнтай брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр манай ноолуурын үйлдвэрийнхэн хичээж байна. Ганц "Говь" ч гэлтгүй том, жижиг бусад үйлдвэрийнхэн ч ийнхүү анхаардаг гэсэн үг.



мэтийн дундаж өртөгтэй брэнд дэлгүүрүүд ч ноолууран бүтээгдэхүүн борлуулах сонирхолтой болсноос шинэ хандлагыг харж болно" гэсэн юм. Үүнээс гадна "Говь" компани шинэ төрлийн брэнд бүтээгдэхүүн гаргаж ирэхэд ихээхэн анхаардаг. Тухайлбал, өнгөрөгч нэгдүгээр сарын 30-нд үйлдвэрийнхээ дэргэдэх нэрийн барааныхаа дэлгүүрийн хажууд "Gobi Organic Mongolian cashmere" нэртэй шинэ брэндийн дэлгүүр нээжээ. Тус дэлгүүр нь ямар ч будаг ороогүй байгалийн үндсэн дөрвөн өнгөөр гаргасан ноолууран бүтээгдэхүүн борлуулах зорилготой. Монгол ямааны ноолуур цагаан,

Mongolian Noble Fibre

Монголын ноос, ноолууран бүтээгдэхүүн дээрх нэрээр дэлхийн зах зээлд гарна. Өнөөдөр манай ноолуурын компаниудад гаднаас багагүй захиалга ирдэг ч захиалгын дагуу нийлүүлсэн ноолууран бүтээгдэхүүн дээр хэзээ ч манай "Говь", "Гоёо" гэсэн үйлдвэрийн шошго тавигддаггүй гэж хэлж болно. Нэг үгээр дэлхийн ноолуурын зах зээлийн 20 гаруй хувийг үйлдвэрлэдэг Монголын бараа бүтээгдэхүүний талаар дэлхий нийтэд мэдлэг мэдээлэл тун хомс байгаа нь харамсалтай. Тэгвэл АХБ-ны Хөдөө

аж ахуйн бүтээгдэхүүний маркетинг, брэндийг хөгжүүлэх төслийн захирал Юрган Мендритцки “Брэнд гэдэг бол итгэл үнэмшил юм. Дотоод зах зээл, гадаад зах зээлээ ялгаж салгадаг байх хэрэгтэй. Дотоодын брэндийн хувьд Монголын хүн амын тоо газар нутагтайгаа харьцуулахад харьцангуй бага учраас магадгүй богино хугацаа зарцуулж болох. Гэхдээ Монголын ноолууран бүтээгдэхүүний брэндийн хувьд би гадаад зах зээлийн асуудал яригдах байх гэж бодож байна. Дэлхийд брэндийг таниулахад доод тал нь таван жил шаардагддаг. Нэг үгээр, хүүхэд төрүүлж өсгөхтэй адил. Гадаад зах зээл дээр брэнд болох зорилт тавьсан бол эхлээд хэрэглэгчийн анхаарлыг татах, сонирхлыг өдөөх, эдэлж чанарыг нь танихыг хүсэмжлэх, худалдан авах гэсэн брэндийн маркетингийн дөрвөн суурь үйлдэл байдаг. Энэ дөрвөн үе шатыг биелүүлэх явцад олон алдаа гардаг. Брэндийн хөгжлийн ойлголт Монголын ноос ноолуурын жижиг үйлдвэрийнхэнд бараг байхгүй, томоохон компаниудын хүмүүсийт суусан байна. Жижиг үйлдвэрүүд бүтээгдэхүүн үйлдвэрлээд, зарахаа л боддог. Тэд үнээр л өрсөлдөж байна” гэв. АХБ-ны дээрх төсөл өнгөрсөн оны есдүгээр сараас хэрэгжсэн бөгөөд Монголын ноос, ноолууран бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлтэй холбох чиглэлээр тодорхой зүйл хийгээд байгаа аж. Төслийнхөн Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам, Монголын ноос, ноолуурын холбоо, хот, хөдөөгийн үйлдвэрлэл эрхлэгчидтэй холбоотой ажилладаг. Төслийн гол зорилго нь Монголын ноос, ноолууран бүтээгдэхүүнийг Mongolian Noble Fibre /MNF/ гэсэн чанарын батламжит шошготойгоор дэлхийд таниулах юм. Өөрөөр хэлбэл, аль нэг улсын нэртэй брэндийн сүлжмэл бүтээгдэхүүн дээр MNF шошго давхар зүүлгээтэй байхыг Та харж магадгүй. Тэгсэн тохиолдолд уг шошго нь монгол ямааны чанартай ноолуураар хийсэн дээд зэрэглэлийн зах зээлд зориулсан бүтээгдэхүүн гэдгийг илтгэх юм. Оюуны өмчийн газар болоод бусад холбогдох байгууллагаар бүртгэж батламжилсан уг дээрх шошгон дээр “...тал дүүрэн тааваараа идээшилж, аз жаргалтай өсөн үржсэн экологийн цэвэр бүтээгдэхүүн болох монгол ямааны нарийн ширхэгт ноолуур юм... гэх мэтээр онцлог шинжийг илэрхийлсэн сурталчилгааны үг өгүүлбэрүүд дурайх аж. Энэ хүрээнд ердийн болон нарийн ширхэгт гэсэн хоёр брэнд бүтээгдэхүүн гарах гэнэ. Нарийн ширхэгт брэндийн ноолуурын голч 15 микроны үзүүлэлттэй байх бол ердийн ширхэгт бүтээгдэхүүний ноолуурын голч үзүүлэлт 16.5 микронтой байх аж. Дэлхийн загварын аж үйлдвэрт хамгийн дээд зэргийн чанартай бүтээгдэхүүн брэнд болдог учраас монгол ноолуурын ширхэгтээс гадна тослог гэх мэт бусад үзүүлэлтийг нь ч нарийн тусгаж. Зөвхөн ноолуур төдийгүй сарлагийн хөөвөр, торомны ноосоор хийсэн бүтээгдэхүүн ч MNF-д хамаарна. Монгол ноолуур хэдий чанартай,үндэсний үйлдвэрүүд хаа ч гологдохооргүй бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэж, экспортолдог ч гадаад зах зээлд үйлдвэрлэгчийн нэрээр гараад байх боломжгүй учраас MNF гэсэн бүрэлдэхүүн брэндээр гаргах нь Монголын ноолууран бүтээгдэхүүнийг дэлхийд таниулах оновчтой шийдэл байж болох.

Гэхдээ энэ нь бүрэн шийдэгдчихсэн зүйл биш. Төслийнхний ярьж буйгаар MNF батламжийг Хөдөө аж ахуйн яам эзэмших бөгөөд гэрчилгээ олгох үйл ажиллагааг нь брэндинг менежментийн агентлаг гэсэн төрийн бус байгууллага эрхлэх нь зөв гэнэ. Юрган Мендритцки “Бусад орны туршлагаас харахад энэ үйл ажиллагааг маркетингийн мэргэжлийн төрийн бус байгууллага илүү үр дүнтэй авч явдаг. Төрийн бус байгууллага нь хяналтын зөвлөлтэй байна. Хяналтын зөвлөлд мэргэжлийн холбоод, Засгийн газар, худалдан авагчийн төлөөлөл, олон улсын стандарт, ширхэгтийн гэх мэт холбогдох байгууллагуудаас төлөөлөл байж болно. Монголын Засгийн газар брэнд менежментийн агентлаг байгуулахыг дэмжинэ гэдэгт итгэж байна. Энэ нь ухаалаг, урт хугацаанд үр дүнгээ өгөх шийдвэр байх болно ” гэв.

Ямар нэртэй байх нь хамаагүй ямар ч гэсэн хөдөө аж ахуйн маркетинг менежментийн бие даасан хараат бус байгууллага байгуулах нь брэндийн чанарт хяналт тавих, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх зэрэг олон чиглэлээр үр дүнтэй үйл ажиллагаа явуулах боломжтой гэдгийг гаднын зөвлөх онцолж байна. Мөн дээрх шошгоор Монголын ноолуурыг дэлхийд таниулахад тавигдах нэг шаардлага нь мэргэжлийн лабораторийн асуудал. Тиймээс төслийнхөн Нэхмэлийн хүрээлэнд энэ ажлыг даатгах боломжтой гэж үзэж байна.



Мөн Монгол Улс АХБ-ны төслийн дэмжлэгтэйгээр бүрэлдэхүүн брэнд гаргах гэж байгаа гэдгээрээ өнгөрсөн онд дэлхийн ноос, ноолуурын хоёр ч том хуралд давуу эрхтэй оролцож MNF-ийн сурталчилгааг эхлүүлээ. Түүнчлэн брэнд гаргаж байгаа тохиолдолд ямааны нуруун дээрх ноолуур пальто болох хүртэлх үе шатуудад гардаг алдаа дутагдал, асуудлуудыг нэг бүрчлэн шийдэх үүрэг хариуцлага малчид,

үйлдвэрлэгчид, төр засагт ногдож байгааг хэлэх хэрэгтэй болов уу.

Асуудал ба шийдэл

Монголын компани өөрийн хөрөнгөөр гадаад зах зээлд брэнд бий болгоно гэдэг маш хэцүү даалгавар гэдгийг Юрган Мендритцки хэлсэн. Мөн "Говь" компанийн Гадаад худалдааны газрын захирал Ариунаа "Бидэнд гадаад зах зээлд гарах өргөн боломж бий. Жишээ нь Европын холбооны улсууд руу Монголын ноолууран бүтээгдэхүүн импортын татваргүй байдаг. Үүнийг ашиглаж чадахгүй сууна. Үүнд төр, засгийн дэмжлэг хэрэгтэй. Бидний зүгээс гаднын компаниуд руу бүтээгдэхүүнээ байнга санал болгож, танилцуулдаг ч төрийн нэгдсэн дэмжлэг үгүйлэгддэг. Гадаад орнууд дахь Монголын Элчин сайдын яам бүрт Худалдаа, эдийн засгийн асуудал хариуцсан хүн бэлээхэн байдаг. Тэдэнд Засгийн газраас сууж буй орон бүртээ Монголын брэндийг хэрхэн гаргаж болох талаар судалж, идэвхтэй ажиллах хэрэгтэй гэсэн үүрэг чиглэл өгөх юм бол илүү үр дүн гарна. Европын холбооны улсууд руу гарах бараа бүтээгдэхүүний жагсаалтад Монголын ноолууран бүтээгдэхүүнийг оруулах нь чухал. Нэгэнт жагсаалтад орсон хойно бол ямар бараа нийлүүлж, харилцагчаа яаж татах нь бидний асуудал" гэсэн юм. Европын холбоо бол ноолууран бүтээгдэхүүний хамгийн том зах зээл. 500 гаруй сая хэрэглэгчтэй. Мэдээж хойд хөршийг мартаж болохгүй. Түүнчлэн Герман, Австрали, шинэ Зеланд зэрэг оронд сарлагийн хөөвөр, тэмээний ноосон бүтээгдэхүүний зах зээл бий аж.

Мөн Монгол Улсын 40 гаруй сая толгой малын 20 орчим сая нь ямаан сүрэг. Манай ямаанаас байгалийн натурал өнгийн ноолуур түлхүү гардаг бөгөөд дэлхийн зах зээлийн 70 хувийг хангаж буй Хятадын ноолууртай өрсөдөхүйц давуу чанар бий. Гэхдээ Монголын цөөн үйлдвэртэй, барааны нэр төрөл урд хөршийнхтэй харьцуулахад олон биш зэрэг шалтгаан нь нэгж бүтээгдэхүүний өртөг, зардал өндөр тусахад нөлөөлдөг байна. Өөрөөр хэлбэл, энэ нь гадаад зах зээлд өрсөлдөх чадварыг муутгадаг гэсэн үг. Дараагийн нэг асуудал нь жилийн 15-20 гаруй хувийн хүүтэй зээлээр үйлдвэрлэл явуулах нь ноолуурынханд өндийх боломж өгөхгүй байгаа аж. 2011 онд 100 тэрбумын бондоор дэмжсэнийг үйлдвэрлэл эрхлэгчид "Үүлний цаанаас нар гарах шиг болсон" хэмээн олзуурхан ярьж байна.Тэр мөнгөөр чанар сайтай түүхий эд бэлтгэсний үр дүнд сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ сүүлийн хоёр жилд 30 хувиар нэмэгдсэн гэнэ. Тиймээс энэ салбарынхан төрөөс жил бүр 300-500 тэрбумын эргэлтийн хөрөнгөөр дэмжих юм бол гурван жилийн дотор хөл дээрээ зогсох боломжтой хэмээн учирлаж байна. Шаардлагатай хөрөнгө оруулалт хийгдээд чанартай түүхий эдээ ахиу базааж, тоног төхөөрөмжөө шинэчилсэн тохиолдолд асуудал бүрэн шийдэгдчихгүй. Ажиллах хүчний асуудал хурцаар тавигдах хэмжээнд хүрчээ. Харьцангуй боловсон хүчин сайтай салбар байсан ч сүүлийн 20 гаруй жил боловсон хүчний сэлбэлт хийгээгүй учраас нарийн мэргэжлийн ажилтнууд дутагдах хэмжээнд хүрчихээд байгаа юм. Өнөөдөр тус салбарт 8000 орчим ажлын байр бий бөгөөд төрийн дэмжлэг авч, үйлдвэрлэл хөгжих аваас дээрх ажилтны тоог даруй 20.000 улмаар 80.000-д ч хүргэх боломжтой гэнэ. "Буян" компанийн захирал Б.Жаргалсайхан салбарынхаа нөөц боломжийн талаар хэлэхдээ " Өнөөдөр нэг тонн зэс 8000 ам.долларын үнэтэй байгаа бол нэг тонн самнасан ноолуур 125000 ам.долларын үнэтэй. Нэг тонн нүүрснээс 300 дахин илүү үнэтэй гэсэн үг. Шавхагддаг баялагт дулдуйтаж биш, нөхөн сэргээгддэг баялагтаа тулгуурлан ажил хийж, амьдрах хэрэгтэй байна" хэмээн ярьсан. Түүнчлэн одоо улсын хэмжээнд сүлжмэлийн үйлдвэрийн 4000 машин ажиллаж байгаа бол хэрэглээг хангасан үйлдвэрлэл явуулахын тулд дахиад 2000-3000 машин хэрэгтэй бөгөөд өнөөдрийн үйлдвэрлэж буй 1.2 сая ширхэг сүлжмэл бүтээгдэхүүнийг 2-3.8 саяд хүргэх шаардлагатай байгаа юм. Тийм хэмжээний эрэлт байгаа гэсэн үг. Ноос, ноолуурын салбарынхан өнгөрсөн сард болсон зөвлөлгөөнөөсөө 2013-2020 хүртэл үе шаттай хэрэгжүүлэх томоохон зорилтыг дэвшүүлсэн билээ. Чингис бондын мөнгөнөөс энэ салбарын үйлдвэрлэлийг дэмжих юм бол ноос, ноолуурынхан ямархуу үйлдвэрлэл явуулаад, хэзээ, хэрхэн үр дүн гаргах бодит тооцоолол нь ч бэлэн байгаа гэсэн. Монголын ноос, ноолуурын салбар мөдхөн хөгжин дэвжиж дэлхийн брэнд болно гэдэгт найдъя. ■

Чанарын үзүүлэлтээрээ дэлхийд өрсөлддөг монгол ноолуурт монголчууд өөрсдөө итгэдэг болжээ. Итгэл гэдэг бол брэнд бий болгох үндсэн үзүүлэлтүүдийн нэг.

МЭРГЭЖЛИЙН ХҮНИЙ ҮГ

ҮНДЭСНИЙ БРЭНД “ТӨРҮҮЛЭХЭД”

ЗАСГИЙН ГАЗРЫН ДЭМЖЛЭГ ХЭРЭГТЭЙ

Р.ШАРБАНДИ, Г.МӨНХБАЯСГАЛАН
/МУИС-ийн Худалдааны сургуулийн багш нар/

Үндэсний брэнд бүтээх нь аливаа улсын нэр хүнд, онцлог, давуу талыг дэлхий дахинд таниулах, сурталчлах, үндэсний брэндийн бодлогыг тодорхойлох, удирдах, сайжруулахад чиглэсэн онол, практикийн цогц үйл ажиллагаа бөгөөд урт хугацааны, залгамж халаатай, тасралтгүй үйл явц юм.


“Nation brand” гэсэн нэр томъёог Simon Anholt “Өдгөө дэлхий нэг зах зээл болсон. Иймд улс орон, цаашилбал хот, бүс нутаг бүр дэлхий дахины хэрэглэгчид, жуулчид, хөрөнгө оруулагчид, бизнес эрхлэгчдийн анхаарлыг өөртөө татахын төлөө өрсөлдөж байна” хэмээгээд үндэсний брэнд (nation brand)-ийн Аялал жуулчлал, Экспорт, Засаглал, Хөрөнгө оруулалт, Цагаачлал, Соёл уламжлал гэсэн чиглэлээр тодорхойлогдох зургаан талт схемийг боловсруулсан.

Харин Их Британийн профессор YingFan 2010 онд хэвлүүлсэн “Branding the nation: Towards a better understanding” өгүүлэлдээ үндэсний брэндийн үзэл санааг дараах байдлаар тайлбарлажээ. Тэрбээр Экспортын, Аялал жуулчлалын, Улс төрийн, Соёлын брэндүүд нэгдэж үндэсний брэндийг тодорхойлдог гэж үзээд, брэнд бүтээх үе шатыг тодорхойлсон.

Эрдэмтэн Wally Olins Үндэсний брэнд бүтээх үйл явцыг:

1. Үндэсний брэнд бүтээх баг, байгууллага, хамт олныг бүрдүүлэх
2. Үндэсний брэндийн танигдсан байдал, үнэ цэнийг үнэлэх
3. Улс орны давуу, сул талыг үнэлэх
4. Үндэсний брэндийн үндсэн үзэл санааг тодорхойлох
5. Үндэсний брэндийг таниулах арга замыг сонгох
6. Үндэсний брэндийг сурталчилах, таниулах
7. Үндэсний брэнд бүтээх үйл явцад хяналт тавих, засаж сайжруулах гэсэн үе шаттайгаар тодорхойлжээ. Түүний тодорхойлсноор Үндэсний брэнд бүтээхдээ нэн түрүүнд эхний хоёр үе шатыг хийж, холбогдох шийдлийг гаргах хэрэгтэй. Үүнд үндэсний брэндийн танигдсан байдал, үнэ цэнийг дараах дөрвөн хүрээнд тодорхойлогдоно гэж үзсэн байна.

Үндэсний брэнд бүтээх арга зүйг эрдэмтэд дээрх байдлаар тодорхойлсон бол дэлхийн орнууд үндэсний брэнд бүтээх харилцан адилгүй арга, туршлагуудыг хэрэгжүүлж байна. Зарим улс брэнд бүтээх тусгай хөтөлбөр хэрэгжүүлж, байгын ажиллагаатай бие даасан байгууллага ажиллуулах, өөрийн орны тухай сөрөг төсөөллийг өөрчлөх, эерэгээр хоногшуулахыг хичээж байхад нөгөө хэсэг нь төдийлэн ач холбогдол өгөхгүй байна.



Дэлхийн орнуудын туршлагаас харахад үндэсний брэндийн бодлого хариуцсан Засгийн газрын агентлаг, алба байгуулах, эсвэл Засгийн газрын дэмжлэг, олон нийтийн болон хувийн хэвшлийн үүрэг оролцоотойгоор үндэсний брэнд бүтээх гэсэн хандлагууд байдаг. Гэхдээ аль ч тохиолдолд Засгийн газар голлох, тэргүүлэх үүрэгтэй оролцдог байна.

Үндэсний брэндийг оновчтой бүрдүүлснээр улсын нэр хүнд, ард иргэдийн үнэлэмжийг өсгөх, бараа, үйлчилгээний өрсөлдөх чадвар дээшлэх, экспортын нэр төрөл, тоо хэмжээ өргөжих, аялал жуулчлал, хөрөнгө оруулалтын салбарт гадаадынхны оролцоо нэмэгдэх зэрэг олон ач холбогдолтой учраас Монголын үндэсний брэнд бүтээх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Үндэсний брэнд бүтээх ажил зарим талаар ажил хэрэг болж эхэлсэн нь сайшаалтай байна. Тухайлбал, УХААЯ, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо, МҮХАҮТ, Их Британийн Hat Factory зөвлөх багтай хамтран 2011 онд Mongolian National Marketing and Coordination Office-ийг байгуулсан бөгөөд манай улсын экспортын үндэсний брэндийг бий болгох зорилготой ажээ. Мөн МҮХАҮТ-аас экспортыг хөгжүүлэх үндэсний стратеги боловсруулсан, 2012 онд УХШХ, МҮХАҮТ, ГХЯ, Монголын Маркетингийн холбоо хамтран “Олон улсын зах зээлд Монгол Улсын үндэсний брэнд бий болгох бодлогын асуудал” форум зохион байгуулсан гэх мэт ажлууд хийсэн нь үндэсний брэндийг хөгжүүлэх ажлын үндэс суурь болж байна.

Энэ эхлэл суурийг бэхжүүлэхийн тулд манай улсын тухайд үндэсний брэнд бүтээх үүрэг хариуцлагыг Засгийн газрын дэргэдэх тусгай байгууллага хариуцах нь оновчтой байж болох юм. Учир нь, үндэсний брэнд бүтээх үйл явц нь ашгийн бус зорилготой, дотоод, гадаад зах зээлийг хамарсан өргөн цар хүрээнд судалгаа шинжилгээ, үйл ажиллагаа явуулах шаардлагатай, үүнийг дагалдан ихээхэн хэмжээний хөрөнгө, ур чадвар шаардах ажил юм. Гэхдээ зөвхөн Засгийн газарт даатгаад орхих биш төр, бизнесийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааны үр дүнд дэлхийд Монгол Улсыг таниулах үндэсний брэнд бүтээнэ.

Монгол Улс дэлхий дахинд өөрийн орны түүх, соёлыг илэрхийлсэн бусдаас ялгарах давуу тал, онцлогоо оновчтой тодорхойлсон үндэсний брэндтэй болох цаг айсуй. ■



СҮҮН ЦАГААН ИМИЖ

Б.ҮҮРИЙНТУЯА

Эрүүл биед саруул ухаан оршино гэдэг. Хөвөн цагаан өвлийг утааны улирал гэж нэрийдсээр олон жилийг үдэж буй монголчуудын эрүүл мэнд өдгөө хутганы ирэн дээр дэнжигнэх болж. Гэтэл өндөр хөгжилтэй орнуудад улс, үндэстний оршин тогтнох ул суурийн чухал хэсэг нь эрүүл мэнд бөгөөд эрүүл үндэстнийг бий болгоход сүү, сүүн бүтээгдэхүүн амин чухал үүрэгтэй гэж үздэг аж. Ийм ч учраас олон улсад органик бүтээгдэхүүн, тэр дундаа сүү, сүүн бүтээгдэхүүнд брэнд бий болгож, төрийн бодлогоор “хамгаалдаг” байна.

Уудам нутгийнхаа гүн дэх баялгаар анхаарлыг олзолсон монголчууд түүнийхээ шимийг хүртэх нь цаг хугацааны хэрэг болсон. Гэвч Монголын жинхэнэ баялаг газар дор бус гадарга дээр ил оршиж буйг санах нь зүйтэй болов уу. Байгаль эхийн өвөрт “эрхлэх” Монгол мал сүргээс гарах бүтээгдэхүүн бүрт “экологийн цэвэр” гэх шошго зүүвэл эзнээ олсон “шагнал” мэт. Дэлхий нийт органик бүхэнд хошуурч буй өнөө үед бид байгалийн энэхүү баялгаа эрүүл мэндийн хөшүүрэг болгох тал дээр хэрхэн хандаж байгаа бол. Ялангуяа сүү, сүүн бүтээгдэхүүний Монгол брэнд хэрэглэгчдэд хүрэх цаг хэр ойр байна вэ?

Экологийн бөгөөд амьд

Хүн өдөрт 430 мг сүү, сүүн бүтээгдэхүүн хэрэглэх нь зохимжтой бөгөөд түүний 175 мг нь цэвэр, шингэн сүү байна гэх олон улсын дундаж жишиг байдаг аж. Харин манай улсад ийм төрлийн нарийвчилсан судалгаа байдаггүй гэхэд хилсдэхгүй. Хэдийгээр Эрүүл мэндийн сайд дээрх жишгийг хэвшүүлнэ гэж буй ч эл тоо дөнгөж 100 мг байна гэж тооцжээ.

Өдгөө манай улсад “Сүү”, “Монсүү”, “Сүүн сондор” зэрэг хуруу дарам цөөн үндэсний гэх компани үнээний цэвэр сүүг бүтээгдэхүүнийхээ эх болгож байна. Сүүнд хүний биед шаардлагатай эрүүл мэндэд тустай эрдэс, бодисууд оршиж байдаг нь тус бүтээгдэхүүнийг экологийн төдийгүй амьд шинж чанартай болгодог аж. Шингэн нөхцөлд уг чанараа тавхан хоног хадгалдаг цэвэр сүүний хэрэглээг нэмэгдүүлэхийн тулд дотоодын үйлдвэрлэлээ дэмжихийн зэрэгцээ саалийн эрчимжүүлсэн фермерийн аж ахуйг хөгжүүлэх нь энэ төрлийн бүтээгдэхүүний үндэсний брэндийг бий болгох нэг гарц хэмээн Монголын сүүний нэгдсэн холбооны тэргүүн О.Амарцэнгэл сонирхуулсан юм. Мөн сүү, сүүн бүтээгдэхүүний эрүүл мэнд болоод үндэсний аюулгүй байдалд үзүүлэх ач холбогдлыг иргэдэд сурталчлах нь брэнд бүтээх тэргүүний алхам ажээ.

Брэнд гэх нэршил асар их нэр хүндийг дагуулдаг. Тухайн орны олон улсын нэрийн хуудас болох нь ч бий. Гэтэл манай улсад хүссэн бүхнээ ийнхүү нэрийдэх нь хэвийн болж. Чухам энэ ташаа ойлголтыг “журамлах” улмаар Үндэсний жинхэнэ брэндийг бий болгох талаар энэ оны Монголын эдийн засгийн форумын үеэр хэлэлцэх юм.


Эхлээд өөрсдөө…

Хүнсний аюулгүй байдлын тухай хуульд мах, гурил, улаан буудайн үр, ус болон сүүг стратегийн бүтээгдэхүүн хэмээн тодорхойлсон. Эдгээрээс мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүнийг брэнд болгох талаар эрх баригчид ярьж буй. Хоёрдогч зах зээлд өрсөлдөхүйц сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэж чадах эсэхт эргэлзэх нь олон. Гараа сайн бол бариа сайн гэж монголчууд билэгшээдэг. “Хөрс нь бий. Ажиллах л хэрэгтэй” хэмээн Монголын ууган сүүний үйлдвэр гэгдэх “Сүү” компанийн захирал Д.Мөнхжаргал хэлсэн юм. Тэрбээр “Монгол гэсэн брэндийг олонд таниулахын тулд имижээ зөв бүрдүүлэх хэрэгтэй. Аялал жуучлалыг брэнд нэрийн хуудас болгож байна. Энэ нэрийн хуудсаа зөв “хэвлэх” нь чухал. Ингэхгүй бол бусад салбараа хөлдөө чирэх эрсдэлтэй” гэсэн юм. Түүний эдгээр үг гадаад зах зээлд Монголыг таниулах алхмыг эхнээс нь зөв хийх хэрэгтэйг илтгэх. Гадаад зах зээл рүү тэмүүлэхийн тулд дотоод асуудлаа цэгцлэх шаардлага байгааг тэрбээр онцолж байлаа. Сүү, сүүн бүтээгдэхүүний Монгол брэндийг бий болгоно гэдэг мөрөөдөл биш. Энэ талаар сүүлийн 10 гаруй жил ярьж буй ч нэгдсэн шийдэлд хүрээгүйн улмаас замхарсан гэж үзэж болох. Харин Шинэчлэлийн Засгийн газар дорвитой алхамуудыг эхлүүлээд буй.

Гэвч үйлдвэрлэгчдийн үзэж буйгаар иргэдийнхээ сүүний хэрэгцээг бүрэн хангах нь нэн тэргүүнд шийдвэрлэх асуудал аж. Өнөөдөр нийслэлчүүдийн сүү, сүүн бүтээгдэхүүний жилийн дундаж хэрэглээг 75 сая литр сүү хангах



Монгол Улсад үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан сүүний нийт хэмжээ /сая литр/ 2012 оны байдлаар



Эх сурвалж: “Сүү” ХК



учиртай гэнэ. Гэтэл Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны өнгөрсөн жилийн судалгаанаас үзэхэд дөнгөж 41.8 сая литр сүү, сүүн бүтээгдэхүүнийг үйлдвэрийн аргаар боловсруулсан байна. Түүнчлэн дээрхийн ердөө 10 сая орчмыг үнээний цэвэр сүү бүрдүүлсэн бол үлдсэн хувийг нь хуурай сүүгээр орлуулсан гэх тоо бий.

Боломжийн үүд

Монголын сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээ арвин. Булганы айраг, Архангайн ааруул, Говийн ингэний ундаа зэрэг нутаг нутгийн "албан бус" брэнд Монголд цөөнгүй. Харин дэлхийд данстай брэндийг ааруул байх боломжтой хэмээн монголчууд үздэг.

Зах зээл эрэлт, нийлүүлэлтийн зарчмаар хөгждөг. Хэдийгээр ааруулын зах зээлийн эрэлт, хэрэгцээ байж болох ч брэндийн хэмжээнд хүргэх асуудалтай гэдгийг салбарын мэргэжилтнүүд дуу нэгтэй хэлж байна. Дэлхийн зах зээлд сүү, сүүн бүтээгдэхүүний экспортолж болох үндсэн гурван бүтээгдэхүүн байдаг аж. Тодруулбал, хуурай сүү, масло болон казеин. Монгол Улсын хувьд сүү, сүүн бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд нийлүүлэхийн тулд багадаа нэг тэрбум тонн сүү боловсруулах шаардлагатай. Гэтэл иргэдийнхээ хэрэгцээг бүрэн хангах хэмжээнд хүрээгүй атлаа хоёрдогч зах зээлийн эрэлтийг бий болгох гэх нь хэтийн гэрэлт ирээдүй аж. Боломжгүй зүйл гэж үгүй. Гэхдээ эрэлтгүй бүтээгдэхүүнийг брэндээр тодорхойлох нь учир дутагдалтай болохыг салбарын үйлдвэрлэгчид анхааруулж байна. Үүний оронд импортын хуурай сүүг халж, үндэсний үйлдвэрлэлд цэвэр сүүний хэрэглээг нэмэгдүүлэхийн тулд эрүүл өрсөлдөөнийг бий болгох нь чухал болохыг "Сүү" ХК-ийн захирал хэлсэн. Тэгвэл үүний гол тулгуур нь бүтээгдэхүүний чанар хийгээд хэрэглэгчдийн шаардлага гэдгийг "Бодлого судлалын төв" ТББ-ын мал эмнэлгийн мэргэжилтэн О.Уламбаяр учирласан юм. Тэрбээр "Дотоод хэрэглэгчдийнхээ хүсэлтийг хангаж, чанар, хариуцлагын нэгдсэн систем бий болсон нөхцөлд гадаад зах зээлийн шаардлагаас дүрвээд байх зүйл үгүй" гэсэн юм. Ингэснээр сая нэг Үндэсний брэнд жинхэнэ утгаараа бий болох талтай. ■

MADE IN MONGOLIA

ХААЛГАА НЭЭГЭЭЧ, ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ



Х.БӨРТЭ

..."Цогт оршихуй" компани АНУ дахь "Рио Тинто" компанийн Кеннекот Ютагийн зэсийн уурхайн ажилчдад зориулан 12 төрлийн өвлийн ажлын дулаан хувцас экспортолж байна. Энэ нь манайд боломж байгааг харуулах тод жишээ...

Монгол ур ухаан шингэсэн дулаан хийгээд, нимгэн загвар сайтай, хүрэм, богино ханцуйтай цамц, даашинз гээд дэлхийд алдартай брэндийг ардаа орхисон "Made in Mongolia" шошготой хувцсыг монголчууд төрөл бүрээр нь урлаж байна. Магадгүй манай урчуудын, үйлдвэрүүдийн хувцас ZARA, GUCCI, LOUIS VUITTON, VERSACE, PRADA зэрэг брэндээс бүх талаараа дутахааргүй байж ч болох. Гэвч дэлхийн зах зээл Монголд үүдээ хараахан нээгээгүй байна. Нээж, ороход юу хэрэгтэй вэ.

ҮХААЯ-ны Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилт, зохицуулалтын газрын мэргэжилтэн Н.Нарангэрэл "Монголчууд аль ч брэндээс дутахааргүй чанар, хийцтэй хувцас хийж чадаж байгаа ч гадаад зах зээлд гарах хууль, эрх зүйн орчин таагүй байна. Татвар өндөр байгаа нь Монголыг дэлхийд төлөөлөх брэндийг гаднын зах зээл хүлээж авах цаг хугацааг хумсалж буй гол шалтгаан" гэсэн юм.

Эрс тэс уур амьсгалтай орны хувьд ойролцоо уур амьсгалтай орнуудад дулаан хувцас экспортлох чадвар, нөөц, боломж манай дизайнер, оёдолчид, үйлдвэрүүдэд байгаа эсэх талаар ШУТИС-ийн Хувцас судлалын төвийн захирал ▸▸

Ч.Алтанцэцэг “Монголын дизайнер, оёдолчдын чадвар дэлхийн хэмжээнд хүрсэн. Гэвч бидэнд хямд түүхий эд, технологи алга. Дулаан хувцасны түүхий эдийн хувьд манайх бусад орноос давуу тал ихтэй ч үйлдвэрлэлийн технологи алга. Ажиллах хүч дутагдаж байна. Ихэнх хүн уул уурхай зэрэг цалин өндөртэй салбар руу “урвасан”. Үнэтэй түүхий эдээр хийсэн бүтээгдэхүүнээ хямд борлуулж болохгүй учраас хэрэглэгч цөөтэй байна. Төрийн бодит дэмжлэг, оёдлын салбарынхны хичээл зүтгэл нийлбэл бидэнд маш их боломж бий. Дэлхийн зах зээлээс түрүүлж, дотоодын эрэлтээ хангах тухай ярих хэрэгтэй” гэж ярив.

Мөн “Дээд өнгө” компанийн захирал Н.Цэрэннадмид “Хэрвээ техник, технологи, хүчин чадал нэмэгдүүлэх болоод гаднын зах зээлд гаргах хууль, эрх зүйн орчныг нь таатай болгоод өгвөл эрэлтэд нийцсэн бүтээгдэхүүн үйлдэрлэхээс татгалзах хүн гарахгүй нь лавтай. Гэвч үйлдвэрүүдийн ихэнх нь хөл дээрээ одоо л тогтох гэж байна. Тэдэнд санхүүгийн болоод технологийн шинэчлэлийн дэмжлэг хэрэгтэй” гэв. Оёдлын салбарт хөлөө олсон болоод дөнгөж эхэлж байгаа компаниуд эргэлтийн хөрөнгө хийгээд технологийн шинэчлэлийн туслалцаа төрөөс харж, хүсч байгаа нь илт.

Хасах 50 хэмийн хүйтэнд халуу төөнүүлэх дулаан хувцсыг монгол оёдолчид л хамгийн сайн үйлдвэрлэж, бүтээж чадна гэдгийг тэрбээр онцолж байв. Хамгийн гол нь түүхийг бүтээх үйлдвэрүүд өдгөө дөнгөж хөл дээрээ тогтох гэж байгаа нь дэлхийд брэнд хувцас бий болгохыг хүсэгчдэд дэндүү яарсан хэрэг аж.

30 жил хөгжсөн, түүнээс ч олон жил дэлхийд Монголын нэрийг гаргасан ноос, ноолуур бусад шиг брэнд болж хараахан амжаагүй байхад бараг 100 хувь импортын хувцсаар гангардаг монголчуудад ойрын 30 жилд боломж байгаа гэж үү?


Байгаа гэнэ. 2011 оны сүүлчээс АНУ-д ажлын хувцас экспортолдог болсон “Цогт оршихуй” ХХК-ийн захирал Ч.Баясгалан “Бид гурван хүнтэйгээр үйлдвэрээ нээгээд байхдаа Оюутолгой компанийн ажилчдын хувцсыг үйлдвэрлэх тендерт ялж, улмаар үйл ажиллагаагаа өргөтгөн өдгөө АНУ дахь “Рио Тинто” компанийн Кеннекот Ютагийн зэсийн уурхайд 12 төрлийн өвлийн ажлын хувцас экспортолж байна. Хүчин чадал болоод ажилчдынхаа тоог нэмэгдүүлээд, шинэ боломж гарч ирвэл өөр улсад ч экспортлох боломжтой” гэсэн. Тус компани өдгөө есөн ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна.

АНУ, ОХУ, Ираны хотуудад бараагаа экспортлоод дөрвөн жил гаруй болж буй “GB of Mongolia” дотуур хувцасны үйлдвэр сард 7-8 загварын унтлагын хувцас, 18-20 загварын хөхөвч үйлдвэрлэдэг. Дэлхийн дотуур хувцасны ертөнцөд Монголын нэрийг гаргахыг зорьж яваагаа тус компанийн захирал Ш.Энхцэцэг хэлж байсан. Мөн үндэсний хувцас, түүний соёл уламжлалыг дэлхийд таниулахыг эрмэлзэж буй “Монгол костюмс”, пүүз, ботинк зэрэг импортыг орлох европ загварын арьс, ширэн гутал үйлдвэрлэж буй “Ноён гутал” зэрэг үйлдвэрүүдийг нэрлэж болно. Тэдний гаднын зах зээлд Монголын хувцас загварыг төлөөлж, тоогдсон гол зүйл бол “Бүтээгдэхүүн бүртээ монгол зан заншил, өв уламжлалаа шингээж, хамгийн гол нь хүний биед эвтэйхэн, энгийн загвартай байхад анхаарсан явдал” гэж байв. Хэдий ам бардам ийм үг хэлж байгаа ч үнэндээ үндэсний, Монголын гэх хувцас дэлхийн зах зээлд хараахан гарч

График 1. Оёмол бүтээгдэхүүний экспорт /мянган ам.доллар/



График 2. Оёмол бүтээгдэхүүний нийт борлуулалт /сая төгрөг/



чадаагүй байгаа билээ. Загвар, өнгө, шийдлийн хувьд одоохондоо Монголд орон зай, боломж байхгүй байж болох ч эрс тэс уур амьсгалд зохицсон дулаан хувцасны үйлдвэрлэлд эрэлт байгааг гаднынхан тайлбарлаж байна. Дэлхийд өвлийн улиралтай 13 орон байдгийн нэг нь. Бусдаасаа хамгийн хүйтэн, ширүүн уур амьсгалтайд тооцогддог. Ийм орны иргэдийн жирийн өдрүүдэд өмсдөг хувцас гаднынхны онцгой нөхцөлд өмсөх “аврал” болдог аж.


Н.Нарангэрэл “Оёмол болон бусад хувцас хэрэглэлийг гаднын зах зээлд хүргэе гэвэл хилийн боомтуудад ойр үйлдвэр байгуулах шаардлагатай. Хамгийн түрүүнд Алтанбулагийн хил дээр нэхий эдлэл, гутал, дулаан хувцас, оёмол бүтээгдэхүүний томоохон үйлдвэр барих хэрэгтэй юм. Ингэснээр хил орчмын гаднын хүмүүс манай бүтээгдэхүүнийг худалдан авч, улмаар өргөжих боломж бий” гэсэн. Энэ нь эхлээд эрэлтийг хангахуйц “Made in Mongolia” шошготой хувцас үйлдвэрлэх үйлдвэр олноор байгуулах асуудал юм.

Түүнчлэн уул уурхай эрчимтэй хөгжиж буй болон хөгжлийн тулгуур төв болгож буй аймгуудад оёдлын үйлдвэр байгуулах хэрэгтэйг дурдаж байв. Ажлын хөдөлмөр хамгааллын, бээлий, оймс, машин, техникийн хийгээд гал тогоо, цэвэрлэгээнд хэрэглэх алчуур, даавууг импортоор бус үндэсний үйлдвэрийнхээ бүтээгдэхүүнээр хангах нь дотоодод өрсөлдөөн нэмэгдэхийн дээр гаднын зах зээл рүү тэмүүлэх том алхам болохыг онцолж байв.

Энэ салбарт төр, засгийн зүгээс юм хийгээгүй биш хийж байгаа. Тухайлбал, “Оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх” гурван үе шаттай хөтөлбөр хэрэгжүүлж буй. 2003-2015 оныг дуустал. Хугацаа урт болоод ч тэр үү, төслийн хэрэгжилт нэлээд унтаа байдалд байгааг шүүмжлэх хүн цөөнгүй байна. Гэхдээ уг төслийн ачаар оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зориулалтаар импортлох сэлбэг, түүхий эд, үндсэн болон туслах материалыг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн. Энэ нь дээрх



График 3. Оёмол бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл /сая төгрөг/



жижиг үйлдвэрүүд бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд томоохон түшиц болж өгч байгааг дурдах нь зүйтэй. Мөн “Импортыг орлох үйлдвэрлэлийг дэмжих зорилтын хүрээнд монгол хонь, тэмээний ноосны хаягдлыг ашиглан Higt+tech технологийг ашиглан дулаалгын WINTEX материалыг гарган авч, цаг агаарын эрс тэс уур амьсгал, хүйтний улиралд өмсөх найман төрлийн хувцас үйлдвэрлэн туршиж эхэлсэн байна. Энэ нь тун удахгүй цаг агаарын хүнд нөхцөлтэй орнуудад уг хувцсыг экспортлохын эхлэл гэдгийг салбарын мэргэжилтнүүд онцолж байв. Дэлхийн зах зээлийн хаалгыг татахад хэдхэн алхам үлдлээ. Тэр нь ердөө хамтраад шийдвэрлэх бодлогын асуудал гэдгийг хэн хүнгүй мэдэж байгаа.

Цагтаа Монголын эдийн засгийн гол тулгуур салбарын нэг байсан оёдлын салбар сүүлийн 20-иод жил “уналтад” орсон ч шинэчлэлийн салхи сэвэлзэж эхэллээ. Эдийн засгийн төрөлжилт, өгөөж хийгээд үр дүнтэй зохицуулалтын дүнд дэлхийд Монголыг төлөөлөх брэнд хувцас удахгүй “мэндлэх” биз ээ. ■

XacBank
Зөв Банк

ТЭНГЭР
САНХҮҮГИЙН НЭГДЭЛ

Компанийн засаглал болон нийгмийн хариуцлагаар ТЭРГҮҮЛЭГЧ БАНК



МАНЛАЙЛАЛ

- Зээлийн багцын чанараар урт хугацаанд тэргүүлэгч
- Байгууллагын засаглал болон удирдлагын ур чадвараар олон жил манлайлагч нь байж ирсэн
- Харилцагч төвтэй үйлчилгээг эрхэмлэж, бүтээгдэхүүний чанар болон хүртээмжийг сайжруулах тал дээр мэдлэг, ур чадвараа бүрэн зарцуулдаг мэргэжлийн баг хамт олонтой
- Тогтвортой болон ил тод байдлаар тэргүүлэгч банк
- Олон улсын банк санхүүгийн тэргүүн туршлага, шинэлэг төсөл хөтөлбөр, орчин үеийн техник технологийг хамгийн түрүүнд нэвтрүүлэгч
- "Үйлчилгээний Төгөлдөршил" хөтөлбөрийг банкны салбарт анхлан нэвтрүүлэгч
- Монголд Ногоон Банк гэдэг ухагдахууныг анх бий болгосон ба ЭКО хэлтэстэй цорын ганц банк
- Нийгмийн хариуцлагаар тэргүүлэгч байгууллага

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Олон улсын санхүүгийн үнэлгээний байгууллагуудаас ХасБанкны зээлжих зэрэглэлд **B** болон **B1** гэсэн үнэлгээнүүдийг өгч Банкны санхүүгийн үзүүлэлтүүдийн цаашдын хандлагыг **"ТОГТВОРТОЙ"** гэж үнэлсэн.

FitchRatings	**B**	ТОГТВОРТОЙ
Moody's	**B1**	ТОГТВОРТОЙ

Хаяг: Амарын гудамж, No.20А,
Ш/Х–72,Улаанбаатар–14200,
Монгол Улс

И–мэйл: info@xacbank.mn
Веб: www.xacbank.mn
www.amar.mn

Утас: 1888
318185
Факс: 328701

ҮНДЭСНИЙ БҮТЭЭН БАЙГУУЛАГЧ
МОНГОЛЫН АЛТ
КОРПОРАЦИ





Үндэсний хөрөнгө оруулалттай, Монгол Улсын тэргүүлэх компаниудын нэг “Монголын Алт” корпораци нь 1993 онд анх үүсгэн байгуулагдсан юм.





Манай компани уул уурхай, аялал жуулчлал, хөдөө аж ахуй, нисдэг тэрэгний үйлчилгээ, геологи хайгуул, барилгын материалын үйлдвэрлэлийн төсөл гэсэн чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.









Бид үйл ажиллагааныхаа туршид улс, орон нутгийн төсөвт татвар төлөлтөөрөө тогтмол тэргүүлэгч байж ирсэн бөгөөд 2010 онд 99,1 тэрбум, 2011 онд 168 тэрбум, 2012 онд 145 тэрбум төгрөгийг төлсөн. Монгол Улсын Засгийн газар, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимаас хамтран зохион байгуулдаг “ТОП 150 аж ахуй нэгж”-ийн шалгаруулалтад хоёрдугаарт жагссан юм.




Үүний зэрэгцээ бид үйл ажиллагааныхаа туршид дэлхийд тэргүүлэх сүүлийн үеийн дэвшилтэт техник технологийг үйл ажиллагаа, үйлдвэрлэлдээ нэвтрүүлж улс эх орныхоо хөгжил, эдийн засагт даацтай хувь нэмэр оруулах томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхлээд байна. Эдгээр амжилт бүтээлийг мэргэжлийн өндөр ур чадвар бүхий үндэсний боловсон хүчнийхээ оюун ухаан, зүрх сэтгэл, урам зориг, мэргэшсэн ажилтнуудынхаа хүч хөдөлмөрөөр бий болгосон юм. Бид цаашдаа улс эх орны хөгжил, эдийн засагт бодитой хувь нэмэр оруулах, жилд 1 сая тонн цемент үйлдвэрлэх Хөх цавын Цементийн, 405 мян.м3 барилгын дүүргэгч материал үйлдвэрлэх Хийт бетоны, 14,6 сая тн хүдэр олборлон боловсруулах Цагаан суваргын зэс-молибденийн төслүүдийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Мөн “Дорнод МАК” хүрэн нүүрсийг шингэрүүлж, нүүрсийг гүн боловсруулах төслийг хэрэгжүүлэхээр холбогдох ТЭЗҮ, судалгааг гадаадын нэр хүнд бүхий инженерингийн компаниудаар боловсруулан бэлтгээд байна.









СУДАЛГАА

БРЭНД БИЙ БОЛГОЖ, ХӨГЖҮҮЛЭХ НЬ



Э.ГАНБАТ
“Отгонтэнгэр” их сургуулийн Эдийн засгийн тэнхимийн эрхлэгч

Брэнд гэж юу вэ?

Бидний өдөр тутмын хэрэглээнд дэлхийн олон орны төрөл бүрийн брэнд нэмэгдсээр байгаа ч хэн бүхэнд танил “Монгол брэнд” гэсэн ойлголт харьцангуй бага байгаад анхаарлаа хандуулах цаг нэгэнт болжээ. Хамгийн энгийн үгээр тайлбарлавал, брэнд гэдэг нь үйлдвэрлэгчийн зүгээс хэрэглэгчдэд өгч буй амлалтууд бөгөөд тэдний сэтгэл зүйд хоногшсон дүр төрх, лого, нэр, уриа, сав баглаа боодлыг багтаасан цогц ойлголт юм. Брэндийг бий болгоно гэдэг нь үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнийхээ гадаад байдлыг өөрчлөх болон шинэ баглаа боодлоор бүрж будан маск зүүлгэх зүйл огт биш. Иймээс брэндийг бий болгохдоо дараах үндсэн дүрмүүдийг анхаарах шаардлагатай. Үүнд:

1. Нэг л брэндийг бий болго: Жижиг компанийн хувьд эхний ээлжинд зөвхөн нэг л брэнд бий болго гэсэн зарчим байдаг. Учир нь брэндийг бий болгох үйл явц харьцангуй удаан хугацаанд үргэлжилдэг.
2. Брэндээ хадгал: Хамгийн сайн санааг олж түүнийгээ цааш нь хөгжүүлж, хадгал. Ингэснээр таны брэнд хэрэглэгчдийн сэтгэл зүйд хоногшин үлдэх болно.
3. Бусдынхаас ялгаатай бай: Таны брэнд бусад ижил төрлийн бүтээгдэхүүнээс ямар нэгэн зүйлээрээ ялгагдаж байх ёстой. Хэрэв ямар нэгэн ялгаварлал байхгүй бол таны брэндээрээ дамжуулан хэлэх гэсэн санаа тань бүдгэрэх болно.
4. Брэндээ амьдруул: Өөрийн брэндийг хэрэглэгчдийн сэтгэл зүйд амьдруул. Ингэж чадсанаар таны бизнесийн үйл ажиллагаа тогтвортой үргэлжлэх болно.
5. Өөрийн санаагаа давт, давт бас дахин давт: Брэндээр дамжуулан өөрийн санаагаа хэрэглэгчдийн сэтгэл зүйд хоногших хүртэл байнга давт.

Брэндийг бий болгохын ач тус нь юу вэ?

Өнөөдөр үндэстэн дамнасан корпорациудаас эхлээд орон нутгийн жижиг үйлдвэрлэгч хүртэл, автомашины үйлдвэрээс талхны цех хүртэл бизнесийн бүхий л салбарт брэнд бий болгодог бөгөөд тэдэнд брэндийн ашиг тус адилхан оршиж байдаг. Бизнес эрхлэгч брэндийг бий болгож, брэнд эзэмшихийн ашиг тусыг дурдвал:

-Брэнд бүтээгдэхүүн нь энгийн бүтээгдэхүүнээс илүү үнэ цэнэтэй тул хэрэглэгчид илүү үнээр худалдан авдаг,

-Жижиглэн худалдаачид брэндийг дэлгүүртээ нүдэнд харагдахуйцаар байрлуулдаг,

-Брэнд эзэмшигч бүтээгдэхүүний болон зах зээлийн өргөжилтөөс шалтгаалж шинэ бүтээгдэхүүнийг худалдаанд гаргах шаардлагагүй,

-Брэнд эзэмшигч сайн ажиллагсадыг тогтоон барих, өөртөө татахад хялбар байдаг,

-Брэнд эзэмшигч илүү үр дүнтэй ажиллагааг явуулдаг учир нь тэдний гаргаж байгаа бүх шийдвэр брэндийн амлалтыг хадгалах, алсын хараа, зорилгодоо нийцсэн байдаг,

-Брэнд эзэмшигч компанийн үнэ цэнийн өсөлт, хөрөнгө оруулагчдын дэмжлэгийн өсөлт, зах зээлд эзлэх хувь хэмжээний өсөлтүүдээс үр ашиг хүртэж байдаг.

Брэндийн үнэ цэнэ гэж юу вэ?

Аливаа бизнес эрхлэгч өөрийн брэндийн үнэ цэнийг нарийвчлан танин мэдэж байх ёстой бөгөөд энэ нь брэнд эзэмшигчийн цаашдын үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой байдаг.

Брэндийн үнэ цэнийн пирамид нь дөрвөн үе шатаар тодорхойлогддог.

Брэндийн тодорхойлолт: Брэндийн онцлог шинжийг тодорхойлох энэ үе шатанд үйлдвэрлэгч брэндийн тухай бүрэн ››

төгс мэдээлэлтэй байх ёстой. Өөрийн брэндийг маш сайн тодорхойлж чадсанаар брэндийн үнэ цэнийн пирамидын суурь бат тавигдана гэж ойлгож болох юм.

Брэндийн илэрхийлэх утга: Энэ үе шат нь уран дүрслэл болон гүйцэтгэл гэсэн хоёр хэсгээс бүрдэх бөгөөд уран дүрслэл нь хэрэглэгчдэд тухайн брэндийн харагда байдлаар, гүйцэтгэл нь тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, өнгө, үзэмж, хэрэгцээг хангах байдал зэргээр тодорхойлогддог. Энэ үе шатаар өөрийн брэнд бүтээгдэхүүнийг бусад адил төрлийн бүтээгдэхүүнээс ялгагдах ялгааг бий болгоход түлхүү анхаарах хэрэгтэй байдаг.

Брэндийн үнэ цэнийн пирамид



Хариу үйлдэл: Энэ үе шат нь хэрэглэгчид тухайн брэндийг хэрхэн мэдэрч байгаа байдал болон тэдний шүүмжлэлийг үйл ажиллагаандаа тусгах үе шат юм.

Харилцаа: Энэ үе шат нь брэндийн нэр хүндийг эрчимтэйгээр өсгөх харилцаагаар тодорхойлогддог.

Брэндийн ямар төрлүүд байдаг вэ?

Брэндийн үндсэн таван төрөл байдаг бөгөөд эдгээрээс хамгийн нийтлэг хэрэглэгдэж байгаа нь бүтээгдэхүүний, компанийн, үйлдвэрлэгчийн брэндүүд байна.

Бүтээгдэхүүний брэнд: Компани олон төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэгээс зөвхөн нэг бүтээгдэхүүний брэндийг бий болгосон байдаг. (Жишээ нь: HLL-ийн Dove саван)

Компанийн брэнд: Компани өөрийнхөө нэрийг брэнд болгон худалдаалагддаг. (Жишээ нь: Philips, GE г.м.).

Үйлдвэрлэгчийн брэнд: Брэндүүдийг үйлдвэрлэгч нь эзэмшдэг (Жишээ нь: Nestle).

Хувийн шошго: Брэнд эзэмшигч үйлдвэрлэгч нь биш. Ихэнх хувийн шошгоны эзэмшигч нь жижиглэн худалдаачид, худалдааны төлөөлөгчид байдаг. (Жишээ нь: Дэлгүүрийн шошго)

Бүс нутгийн брэнд: Бүтээгдэхүүнүүд нь нэг газраас болон нэг бүс нутгаас ирдэг. Бүс нутгийн брэндүүд нь тухайн бүс нутгаар тодорхойлогдох хүчирхэг нэр хүндтэй байдаг. Эдгээр бүтээгдэхүүний эзэмшигч нь салбарын байгууллага байх ба тэд тухайн брэндийн нэрээр худалдаалж байгаа бүтээгдэхүүнд чанарын хяналт тавьдаг.

Брэндийг хэрхэн бий болгох вэ?

Зах зээлд танигдаж, хэрэглэгчдийн итгэлийг хүлээж чадахуйц брэндийг бий болгон хөгжүүлэх нь нэг удаагийн шинэчлэлтээр хийх ажил биш бөгөөд брэндийг бий болгоход дараах үе шатуудыг дамжина.



Үе шат 1: Юуг брэнд болгохоо шийдэх

• Компанийн, үйлчилгээний, бүтээгдэхүүний брэнд бий болгох гэж байна уу.

• Бүс нутгийн эсвэл жижиглэн худалдааны брэнд үү гэдгээ шийдэх үе шат юм.

Үе шат 2: Судалгаа хий

1. Зах зээлийнхээ тухай мэдэж болох бүх зүйлийг олж мэд.

-Ирээдүйн хэрэглэгчдийн судалгаагаар эхэл. Тэд хэн болох, хаана байна, тэдний худалдан авах шийдвэрт ямар идэвхжүүлэлт хэрэгтэй байна вэ.

-Өрсөлдөөний шинжилгээний тусламжтайгаар өрсөлдөгчдийнхөө зах зээлд аль хэдийн гаргасан ямар шийдлүүд байсныг илрүүлж, түүнээс таны брэндийн ялгаатай болон сайн талыг тодорхойл.

2. Бүтээгдэхүүн, үйлчилгээний тухай мэдэж болох бүхнийг мэд.

-Хэрэглэгчийн хүсэл, хэрэгцээг хэрхэн шийдэх болон ямар онцлог шинжтэй бүтээгдэхүүн үйлчилгээ байхыг тодорхойлох, ямар онцгой санал хүлээж авахаа мэдэх хэрэгтэй.

-Яагаад хэрэглэгчид таны бүтээгдэхүүнийг худалдан авахыг хүсч байна вэ.

Үе шат 3: Бүтээгдэхүүн, үйлчилгээний байр суурь

-Хэрэглэгчдийн зах зээл, тэдний сэтгэл зүйд өөрийн бүтээгдэхүүний эзлэх байр суурийг тодорхойлохдоо:

1. Зөвхөн хэрэглэгчийн хэрэгцээнд хаягласан бүтээгдэхүүн үйлчилгээний байр суурь, мөн чанарыг тодорхойлох,

2. Ялгаатай байдлаар өөрийн санаагаа дамжуулах,

3. Хэрэглэгчийн сэтгэл зүйд болон зах зээл эзлэх онцгой байр сууриа тодорхойлох.

Үе шат 4: Бүтээгдэхүүнийхээ тодорхойлолтыг бич.

-Таны брэнд юу илэрхийлж байгаа тухай үнэн мэдээллээр брэндээ тодорхойл.

-Юу санал болгож байна,

-Яагаад үүнийг санал болгов,

-Яаж таны санал бусдаас ялгагдахаар, илүү сайн байна,

-Таны хэрэглэгчид ямар үр ашигтай вэ?

-Таны бизнесийн хэрэглэгчидэд та юу амлаж чадах вэ?

Үе шат 5: Уриа, лого, нэрийг хөгжүүлэх

-Нэр: Нэр нь хэрэглэгчийн сэтгэл зүйд брэндийн төрхийг онгойлгох түлхүүр юм.

-Лого: Лого нь брэндийн нүүр царай болдог тэмдэглэл юм.

-Уриа: Таны уриа нь зах зээлийн байршил, брэнд, бүтээгдэхүүний үзүүлэлтийг түргэн хугацаанд тогтоохуйц байх хэрэгтэй. Хувийн болон компанийн байршлыг нэр болон лого тодорхой илэрхийлдэггүй бол уриаг энэ зорилгоор ашиглагдаг.

Үе шат 6: Брэндээ зах зээлд нэвтруулэх

Таны брэнд хоёр үе шатаар зах зээлд анхлан нэвтэрдэг. Үүнд:

1. Дотооддоо худалдаанд гаргах – Брэндээ хэрэглэгчдэд танилцуулахаасаа өмнө таны бизнест хамаатай бүх хүнд үзүүлж тэдний зөвлөгөөг ав. Хэрэв тэдэнд ямар нэгэн зүйл нь таалагдахгүй байгаа бол түүнийг дахин нягталж, дутагдалтай талыг нь засах хэрэгтэй.

2. Гадагш худалдаанд гаргах – Таны брэндээ зах зээлд нэвтрүүлснээс хойш та түүнийг засварлах боломжгүйг ойлгох хэрэгтэй.

Үе шат 7: Брэндээ хамгаалах болон удирдах

-Брэндийн сайн менежмент нь “тууштай байдал” гэдэг ганцхан үгэн дээр тогтдог.

-Брэндийн ашиг тусыг тууштайгаар харах,

-Брэндийн төсөлдөө тууштайгаар зохицон ажиллах,

-Тууштайгаар бүтээгдэхүүн, үйлчилгээгээ бий болгож, тууштай харилцааг эрхэмлэх, бүтээгдэхүүний чанарын түвшинг тууштайгаар нэмэгдүүлэх,

-Брэнддээ тууштай үнэнч байх ,

-Ажилчиддаа итгүүлэх,

-Өөрийн брэндийн тодорхойлолтыг жагсаан бич,

-Брэндийн лого, өнгө, үсгийн фонтын бичиглэлийн хэлбэр зэргийг бэлтгэ, Загварыг нэг бүрчлэн тодорхойлж бичээд компанийн болон бүтээгдэхүүний худалдааны тэмдэгтийн ашиглалтыг хяна,

-Хэрвээ та брэндээ хамгийн сайнаар тодорхойлж чадсан бол та брэндээ хамгаалах цагдаагийн үүргийг гүйцэтгэнэ гэсэн үг юм.

Үе шат 8 : Өнөөгийн байдлаа хадгалан өөрийн брэндээ шинэчил

-Өөрийн брэндийг үгүй болгосоноос эхэлсэн компани гэж байдаггүй,

-Одоогийн нэр хүндээ хадгалан брэндийг хөгжүүлэх үйл явцын үе шатыг эхнээс нь эхлэн шинэ брэндийг бий болгож, хамгаал ,

-Брэндийг бий болгоход гарах бүх зардлаар дэд брэнд бий болгохоос зайлсхий,

-Брэндийг баллах хамгийн амархан арга бол нэрийг нь бүх зүйлд ашиглах явдал юм.

Дүгнэлт

Брэндийг хөгжүүлэх нь бизнесийг удаан хугацаанд оршин тогтнох боломжийг бүрдүүлэх бөгөөд дотоодын үйлдвэрлэгчид өөрийн нэрийн брэнд бий болгох чиглэлд анхааран ажиллах нь тэдний ашиг орлогыг нэмэгдүүлэх, цаашид гадаад зах зээлд нэвтрэх, дэлхийн нэр хүнд бүхий брэндтэй өрсөлдөх боломжыг бүрдүүлэх сайн тайлтай юм. Нөгөө талаар брэндийг бий болгоход компанийн үйл ажиллагаа бүхэлдээ чиглэх нь тодорхой зорилгод хүрэхэд нөөцөө бүрэн дайчлах сайн талтай гэж үздэг байна. ■

DHL GLOBAL FORWARDING



DHL GLOBAL FORWARDING

Агаарын болон далайн ачаа тээвэрлэлт, аж үйлдвэрийн ба төслийн тусгай ачаа тээвэрлэлтэд бид дэлхийд тэргүүлэгч юм

Монгол дахь салбар 2005 онд “DHL Global Forwarding” төлөөлөгчийн газраас “DHL Global Forwarding” нэртэй тээвэр зуучийн компанийг нээх эрх олгогдон үйл ажиллагаагаа явуулж байна.



195 ЖИЛИЙН ТҮҮХТЭЙ ДЭЛХИЙН 220 ГАРУЙ УЛСАД

30.000 ажиллагсад
72.000 тээврийн хэрэгсэл
820 терминал
400 онгоц
70 гаруй өндөржүүлсэн хамгаалалттай газрууд
20.000-с дээш чиглэлд

Бид танд дараах үйлчилгээг санал болгож байна

Бүх төрлийн Экспортын ачаа
Бүх төрлийн Импортын ачаа
Жижиг дунд үйлдвэрлэлийн төслийн ачаа
Тусгай ачаа
Аж үйлдвэрийн ачаа
Түүвэр ачаа
Холимог ачаа
Нисэх буудлаас нисэх буудалд
Хаалганаас хаалганд

Бид танд дараах баталгааг гаргаж өгнө

Өндөр хүчин чадал
Боломжийн үнэ
Найдвартай
Шуурхай үйлчилгээ
Чадварлаг хамт олон
Таны хүсэлд нийцүүлэн даатгалд хамруулах гэх мэт









Хаяг: DHL компанийн байр,
Энхтайваны өргөн чөлөө 10/5
Улаанбаатар-14210
Монгол Улс

Утас: 976-70114458
976-70114416
Факс: 976-70114458

И-мэйл: dgf.mongolia@dhl.com
Вэб: http:/www.dhl.com

ХӨРШҮҮД

БРЭНД БИЙ БОЛСОН ТҮҮХЭЭС



Б.ТУЯА

Оросуудын “дайн”

Дэлхийн зах зээл дэх ОХУ-ын нэр хүндийг архигүйгээр төсөөлөхөд бэрх. Тэгвэл нэгэн цагт оросууд брэндийнхээ эзэмшлийн төлөө шүүхийн хаалга татаж, тэр ч бүү хэл үйлдвэрлэх эрхээ хасуулах дөхсөн удаатай.

Оросын архины үйлдвэрлэл ашиг арвин тул барууны бизнес эрхлэгчид эл бүтээгдэхүүнийг ихэд сонирхож, зах зээлийг нь гартаа оруулах хүсэлтэй байсан гэх. Ингэхийн тулд тус бүтээгдэхүүний нэр хүндийг унагаах, заль хэрэглэх эсвэл патентын маргаан хийх зэргээр олон арга хэрэглэж байж. Учир нь, архи үйлдвэрлэх эрхийг Зөвлөлтөөс “булаана” гэдэг эрх мэдэл, эдийн засгийн боломж байсан тул баруунынхан “Водка бол оросуудын бүтээгдэхүүн биш” гэж олны тархийг угаах үйлсэд хамаг анхаарлаа хандуулж байсан юм. Үүгээр ч зогсохгүй Зөвлөлтөөс барууны төдийгүй АНУ-д нийлүүлж байсан хэд хэдэн согтууруулах ундааны брэнд бүтээгдэхүүний худалдааг зогсоож “водка” нэрийг ашиглахгүй байхыг шаардаж байв.

Водка үйлдвэрлэх патентын төлөөх өрсөлдөөн дэлхийн эдийн засгийн гол байлдагчид болж байсан Зөвлөлт холбооны улс, АНУ хоорондын улс төрийн дуэлийг хурцатгаж, худалдааны зах зээлийг эзлэх гэсэн сөргөлдөөний чухал бай болж байсан юм. Зөвлөлтийн водканы экспортыг хориглож дөнгөвөл тус улсын төсөв алдагдал хүлээх учиртай байж. Хэрэв хойд хөршийнхөн тус ундааг үйлдвэрлэх эрхээ алдсан бол

Харуулаас хаан сэнтийд

Тоон ертөнцийг ахалж буй брэнд бол Хятадын Леново. Компьютерийн топ таван үйлдвэрлэгчийн жагсаалтыг тэргүүлэгч “Леново” компанийн түүх 1984 оноос эхтэй ч амжилт гэдэг зүйл зүүд, зэрэглээ байсан нь саяхан.

Леново компьютерийн борлуулалт дотооддоо чамлахаргүй байв. Гэвч энэ нь тус компанийн удирдлагуудын хүссэн эцсийн дүн биш байсан юм. Тэд гадаад зах зээлийг эзлэхээр санаархсан авч эвээ нэг л олохгүй байсаар багагүй хугацаа үдсэн. Гэсэн ч тэд мөрөөдөлдөө хүрэх эхний алхмыг 2005 онд тавьсан нь АНУ-ын алдарт IBM компанийн компьютерийн үйлдвэрлэлийг худалдан авсан явдал байлаа. Умгар өрөөнд үйл ажиллагаагаа эхэлж байсан “Леново” компанийн хувьд гадаад зах зээлд бүтээгдэхүүн нэвтрүүлэх амаргүй байсан нь дамжиггүй. Леновогийнхон “IBM” компанийн төлөөлөгчидтэй арай ядан ойлголцож, тив хоорондын соёлын ялгааг зүхэхээс наагуур байж компанийнхаа “амь”-ийг таслахгүйхэн өдөр, хоногийг элээж байсан гэдэг. Гурван жил уйгагүй хөдөлмөрлөсөн ч тус байгууллагын гишүүд тэднийг цагаан тугаа өргөх цаг ойртсон гэлцдэг байжээ.

Хэдий Леновогийн түүхэн замналын нэгээхэн хэсэг бүрэнхий байсан ч тус компани өдгөө компьютерийн ертөнцийн хаан сэнтийд хэдийнэ заларчээ. Өнгөрсөн жилийн гуравдугаар улиралд л гэхэд нэгэн цагт дэлхийн топ гэгдэж байсан Hewlett-Packard (HP)-ыг борлуулалтаараа ардаа орхиж чадсан билээ. Түүнчлэн Япон, Герман зэрэг суурин компьютерийн томоохон үйлдвэрлэгчийг тэртээ өндөрлөгөөс ажин суух болсон. Үүгээр ч зогсохгүй ухаалаг гар утасны зах зээлийг хэдийнэ онилсон тухай олон улсын шинжээчид цуурхах болжээ. “Хамгаал, тэгээд дайр” гэх уриатай Леново брэндийн амжилтын нууц чухам юу байв?

Дөрвөн жилийн тэртээ удирдлагыг авсан даруйдаа Яанг Юанкинг түргэн “хөдөлж” эхлэв. Түүний эхний шийдвэр ажилчдыг цомхотгох байв. Удаах алхам нь тус байгууллагын цорын ганц найдвар болох дотоодын зах зээлээ аврах байсан юм. Үүний хажуугаар тус компани бусад төрлийн дэвшилт технологи үйлдвэрлэж байсан ч IBM компанийн нэр хүндийг унагаж байна гэх мэдээ тархах болсон. Харин өнгөрсөн онд Леновогийн зүгээс уг яриаг няцааж, гэрээ хийснээс хойш IBM-ийн компьютерийн борлуулалт таван хувиар өссөн баримтыг

архины зах зээл бүхэлдээ АНУ-ын эрхшээлд орохоос гадна бусад оронд үйлдвэрлэхийн тулд АНУ-аас тусгай зөвшөөрөл хүсэх шаардлагатай тулгарах байжээ. Үүний эсрэг тэмцэхээр 1917 оны арванхоёрдугаар сард хуучин Зөвлөлтийн Засгийн газар тус бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг зогсоосон бөгөөд зургаан жилийн турш водкаг худалдаанд гаргаагүй юм. Тэдний энэ шийдвэр водканы жинхэнэ эзэд хэн болохыг харуулсан хэмээн түүх судлаачид үздэг байна. Учир нь, тус бүтээгдэхүүний эрэлт, хэрэгцээ хумигдсан бөгөөд үүнтэй холбоотойгоор Олон улсын арбитрын байгууллага тус бүтээгдэхүүний патентийн асуудлаар заргалдаж буй улсуудыг маргааныг эцэслэхүйц итгэл үнэмшилтэй баримт дэлгэхийг шаардаж эхэлсэн. Үүний дараагаар гадаадын компаниуд заргаа татсан юм.

Амаргүй ялалтын дараа Зөвлөлтийн Коммунист намын төв хорооны тогтоолоор 1923 оны наймдугаар сарын 26-ны өдөр дээрх бүтээгдэхүүнийг дахин үйлдвэрлэх тогтоол гаргасан. Гэвч маргаан дуусаагүй байв.

Оросын эзэнт гүрэн бий болохоос өмнө буюу Польшийн Хаант улсын үед цагаан архийг тус бүсэд анх үйлдвэрлэж эхэлсэн хэмээн Польшийн эрх баригчид үзжээ. Түүнчлэн архины төрлийн бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлд водка гэж нэрийдэхийг зөвхөн Польш улсад зөвшөөрөх, Зөвлөлт холбооны улсын брэнд болж байсан архины нэрсийг өөрчлөх шаардлага тавьж байсан юм. Ийм замаар Польшийн эрх баригчид согтууруулах ундааны олон улсын зах зээлд монополь тогтоох хүсэлтэй байлаа.

Шотланд вискийг 1490-1494 онд анх хийж байсан бол коньякыг 1334 онд үүссэн зэргээр дэлхийд данстай брэндүүдийг түүхэн хуудаснаа мөнхөлсөн байдаг. Гэтэл дэлхийн зах зээлд “төрсний гэрчилгээгүй” байсан водканы хувьд маргааныг дуусгавар болгоход бэрх байлаа. Домог мэт яриаг баталгаажуулах нь Олон улсын арбитрын шүүхийнхэнд чамгүй хүндрэл учруулсан нь лавтай.

Ингээд Олон улсын арбитрын байгууллагаас холбогдох улсуудад баримт, нотолгоо цуглуулах хугацааг 1978 оны эхээр өгсөн байдаг. Эхний ялалтдаа бардаж суусан оросуудын хувьд асуудлыг төдий л нухацтай хүлээж аваагүй юм. Брэндийнхээ гарал үүсэл, түүхийг судлах оролдлого хийсэн ч тодорхой үр дүнд хүрсэнгүй зургаан сарыг үдсэн тус улсын Гадаад худалдааны сайд холбогдох мэргэжилтнүүдийг татан оролцуулах нь зүйтэй хэмээн шийджээ. Ингэсний эцэст анх 1439 онд Кримлинээс холгүй орших Чудов гэх сүмийн Исидор ламтан цагаан архи нэрэх туршилтыг амжилттай хийсэн гэсэн баримт олжээ. Мөн 1533 онд тус ундааг “Царийн зоогийн газар” нэртэй архины мухлагт худалдаалдаг байсныг тогтоосон нь хоёр дахь чухал нотолгоо болсон юм. Эдгээрийг үндэслэн Олон улсын арбитрын шүүхээр 1982 онд тус бүтээгдэхүүн Зөвлөлтийн брэнд гэдгийг хүлээн зөвшөөрсөн юм.

Үндэсний брэндээ бусдын гарт алдах дөхсөн хойд хөршүүд алдаагаа давтахгүйн тулд 1998 онд водканы анхны музейг архины хаан гэгдэх Смирнофын “төрөлх” хот Угличид байгуулжээ. Мөн 2003 онд Орос архины музейг Смоленск хотноо сүндэрлүүлэв.

дэлгэсэн юм. Түүнчлэн Леновогийн Хятадын зах зээлийн өгөөж нийт ашгийн 45 хувийг бүрдүүлж байгааг онцолсон байдаг. Тус компанийн Энэтхэг дэх салбарын захирал Амар Бабу “Хятад дахь зах зээлээ авч үлдэхийн тулд хэрэгжүүлсэн алхам бусад хөгжиж буй оронд үнэтэй сургамж болох учиртай. Бүтээгдэхүүнээ хэрэглэгчдэд ойр байлгах үүднээс 50 км тутамд брэндийн дэлгүүрээ нээж байсан нь Леновогийн зах зээлийг эзлэх стратегийн нэг байсан” гэв.

Өнгөрсөн онд гадаад зах зээлээ өргөтгөх зорилгоор сурталчилгаа, брэндинг болон маркетингэд зарцуулсан тус компанийн хөрөнгө 248 сая ам.долларааар өсчээ. Үйл ажиллагаагаа өргөжүүлэх бас нэг арга бол худалдан авалт. Леново 2011 онд Европын нэр хүнд бүхий “MEDION” элэктроникийг 738 сая ам.долларааар худалдан авсан нь тус компанийн Германы компьютерийн зах зээл дэх нөлөөг хоёр дахин нэмэгдүүлсэн байна. Мөн тухайн онд Японы алдарт “NEC” компанитай худалдааны хамтын гэрээ үзэглэсэн. Үүгээр ч зогсохгүй улирагч онд Бразилийн хамгийн том компьютер үйлдвэрлэгч “CCE”-ийг 148 сая ам.долларааар өөрийн болгосон байгаа юм. Хэдий 14 сарын турш компьютерийн зах зээл найман хувиар хумигдсан ч Леновогийн борлуулалт өссөн үзүүлэлттэй гарсан. Түүнчлэн дэлхийн 12 оронд үйл ажиллагаагаа явуулж байсан бол эл тоо өдгөө 34-т хүрсэн аж. “Ашиг бол урт хугацааны зорилго” гэж Леново компанийн захирал Яанг Юанкинг хэлэх дуртай гэнэ. Тэрбээр үргэлжлүүлэн хөрөнгө оруулалт хийж, улмаар зорилтот зах зээлийхээ ашгийг хамгийн багадаа 10 хувьд хүргэх аж. Тус компанийн санхүүгийн ахлах мэргэжилтэн Вонг Вай Минг “Леновогийн татварын дараах ашиг ирэх жилүүдэд хоёр хувиар өсөн гэдэгт итгэлтэй байгаа” хэмээн мэдэгджээ. ■



ХӨГЖЛИЙН АСУУДЛУУДЫГ ХАМТДАА ШИЙДВЭРЛЭХ НЬ



РОБЕРТ ВИТОЛ
Азийн хөгжлийн банкны
Зүүн Азийн газрын захирал



РОБЕРТ ШОЭЛЛХАММЕР
Азийн хөгжлийн банкны,
Монгол дахь суурин төлөөлөгч

Хорин жил хамтдаа

Эдийн засаг нь унаж, ард иргэдийн хувьд ихээхэн эргэлзээтэй тодорхой бус байдал бий болчихоод байсан 1991 онд, Монгол Улс Азийн хөгжлийн банк /АХБ/-ны гишүүн болсон юм. Тэр үед хуучин Зөвлөлт Холбоот улсаас өгдөг байсан татаас үгүй болж, ажилгүйдэл газар авч, иргэдийн худалдан авах чадвар эрс буурч, нийгмийн үйлчилгээний цогц тогтолцоо задран унаж байлаа. Энэхүү дүр зураг өнөөдөр асар их өөрчлөгдөж, Монгол Улсын эдийн засаг хурдацтай өсч, ядуурал бууран, Монгол иргэд боловсролынхоо өндөр түвшинг хадгалж чадсан.

АХБ Монгол Улстай ойр дотно хамтран ажиллаж байгаадаа бахархаж, тус улсын энэхүү эрс өөрчлөлтөд хувь нэмрээ оруулсанд баяртай байна. Өнгөрсөн 20 жилийн хугацаанд АХБ Монгол Улсад нэг тэрбум гаруй ам.долларын буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл олгож, тус улсын хувьд хөгжлийн олон талт санхүүгийн дэмжлэг үзүүлэгч хамгийн том эх үүсвэр байсаар ирлээ.

1990-ээд оны үед АХБ Монгол Улсын эдийн засгийн шилжилтийг дэмжиж, тээврийн дэд бүтцийг бэхжүүлж, боловсрол, эрүүлийн мэндийн үйлчилгээг шинэчлэхэд тус улсын Засгийн газартай нягт хамтран ажиллаж байв. Үүний дараа АХБ хотын дэд бүтцээс эхлээд хөдөө аж ахуй, эрчим хүч, санхүү, нийгмийн хамгаалал, Улаанбаатар хотын тээврийн шинэтгэл гээд төрөл бүрийн салбарт санхүү, техник арга зүйн болоод бодлогын дэмжлэг үзүүлэв.

АХБ-ны үйл ажиллагааны гол цөм нь бага сургуулийн бяцхан сурагчдаас эхлээд, Улаанбаатар дахь олон улсын нисэх онгоцны буудлаар үйлчлүүлж буй ажил хэрэгч хүмүүс, ихэнх гэр хорооллын бүст эмнэлгийн үйлчилгээ авч буй өвчтөнүүд, дэлхийн хамгийн хүйтэн энэхүү нийслэл хотод халаалт дулаанаар найдвартай хангагдан, санаа амар аж төрөн суугаа хотын оршин суугчид гээд эгэл иргэдийн амьдралыг өөрчилсөн бодит төсөл хөтөлбөрүүд бай даг.

Макро эдийн засгийн бодлогыг онцлох нь

Монгол Улсын эдийн засгийн дунд хугацааны хэтийн төлөв нь хөгжлийнхээ эхэн шатанд явж буй Тавантолгойн нүүрсний уурхай болоод 2013 оны дундуур эхлэхээр төлөвлөсөн Оюутолгойн зэс, алтны уурхайн арилжааны үйлдвэрлэлээс үүдэн нэлээд таатай байх төлөвтэй.

Монгол Улс байгалийн асар их нөөцтэй байгаа нь азтай хэрэг төдийгүй энэ нь эдийн засгаа хөгжүүлэх онцгой боломж олгож байна. Уул уурхайгаас олсон орлогоор тогтвортой хөгжлийг хангах төрийн суурь үйлчилгээнүүд, нийгмийн хамгааллын хөтөлбөрүүд, үндсэн дэд бүтцүүдийг санхүүжүүлж, ядуурлыг бууруулах боломжтой.

Гэвч амьдрал дээр байдал ихээхэн өөр байх нь бий. Байгалийн нөөц ихтэй улс орнууд заримдаа байгалийн нөөц багатай орнуудаас хөгжлийн хувьд

хоцрогдож, хүний хөгжлийн үзүүлэлтүүдээр дорвитой үр дүнд хүрч чаддаггүй. Байгалийн нөөцөөс хэт хамааралтай байх нь орлогын тэгш бус байдлыг улам нэмэгдүүлдэг. Учир нь байгалийн нөөцийн олборлолт нь цөөн тооны ажлын байрыг бий болгож, хүн амын багахан хэсэг орлогын ихэнхийг хүртдэг. Тухайлбал, өнгөрсөн онд уул уурхайн салбар Монгол Улсад экспортын 90 хувь, төсвийн орлогын 17 хувь, ДНБ-ий 18.6 хувийг бүрдүүлсэн хэрнээ хөдөлмөр эрхлэлтийн ердөө хоёр хүрэхгүй хувийг бүрдүүлжээ.

Байгалийн нөөцөд хэт их анхаарал хандуулах нь “Голланд өвчин”-өөс үүдэлтэй эдийн засгийн эрсдэлийг учруулж, улмаар үндэсний валютын ханшийг чангаруулж, инфляцийг нэмэгдүүлэн, хувийн хэвшлийг хумигдахад хүргэж, гаднын шоконд өртөмтгий эмзэг болгодог. Монгол Улсад уул уурхайн үйлдвэрлэл хөгжлийнхөө эхэн шатанд явж байгаа хэдий ч Голланд өвчний шинж тэмдэг аль хэдийн илэрч эхлээд байна. Мөчлөг дагасан төсвийн бодлогын улмаас төсвийн зардал эрс өсч, тус улсын хувьд төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар тогтоосон хязгаарлалтуудаа дагаж мөрдөхөд амаргүй болоод байна.

Өнгөрсөн оны турш хоёр оронтой тооноос буугаагүй инфляцийг хяналтдаа байлгахын тулд Засгийн газар төсвийн болоод мөнгөний бодлогоо ихээхэн чангатгах хэрэгтэй байна. Хэт их тэлэлттэй төсвийн бодлого нь тус улсын эдийн засгийг гаднын шоконд улам өртөмтгий, эмзэг болгож байна. Цаашид дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнийн уналт Монголын эдийн засагт хүчтэй нөлөөлж, төсвийн санхүү, урсгал дансанд дарамт учруулж болзошгүй. Монгол Улс эрдэс баялгийн экспортоос хэт хараат, мөчлөг дагасан макро эдийн засгийн бодлогынхоо улмаас 2008-2009 оны дэлхийн эдийн засаг, санхүүгийн хямралд хамгийн ихээр өртсөн орнуудын нэг болсныг мартаж болохгүй.

Эдийн засгийг төрөлжүүлэх нь

Эрсдэл, эмзэг, өртөмтгий байдлыг шийдвэрлэх нь Засгийн газрын өмнө тулгараад байгаа гол асуудал юм. Макро эдийн засгийн бодлогоо бэхжүүлэхийн сацуу Монгол Улс уул уурхайн бус салбаруудад хийх хөрөнгө оруулалтыг дэмжиж, хүний нөөцөө хөгжүүлэх замаар эдийн засгийг төрөлжүүлж, хөдөлмөр эрхлэлтийг бий болгох хэрэгтэй байна.

Монгол Улс дотооддоо өндөр чанартай, үнэ цэнэтэй бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн нэмүү өртгийн сүлжээг



хөгжүүлэх замаар төрөлжүүлэлт хийх асар их боломжтой. Шинэ сүү, махнаас эхлээд төрөл бүрийн ноос, ноолуур, арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх өргөн боломж бий. Мал сүрэг, жимс жимсгэнэ гэх мэт түүхий эд элбэг байгаа нь өргөн боломжийг бүрдүүлж байна. Жинхэнэ Монгол үндэсний брэндийг бүтээж, бүтээгдэхүүний нарийн чанд стандарт, чанарын хяналтыг бий болгох нь Монголын компаниудыг гадаадын зах зээлд нэвтрэхэд тус дөхөм болно. Гэвч хөрөнгө оруулалт хомс, мэргэжлийн ур чадвар хязгаарлагдмал байгаагийн улмаас энэхүү боломжийг хараахан бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй байна.

Монгол Улсад үйлчилгээний салбар ихээхэн хөгжих боломжтой. 2012 онд үйлчилгээний салбар ДНБ-ий 43.3 хувийг, аж үйлдвэрлэл 6.2 хувийг бүрдүүлжээ. Уул уурхайн үйлчилгээний компаниуд жижиг хэдий ч хурдацтай өсч байна. Аялал жуулчлал багахан хэсгийг эзэлж байгаа ч цаашид Монгол Улсад энэ бизнесийн суурь улам бүр өргөжиж, хөдөлмөр эрхлэлтийг бий болгох ихээхэн боломж бий. Тээвэр, логистикийн салбар одоогоор дөнгөж эхлэлийн үе шатандаа яваа ч энэ нь цаашид өсөх ирээдүйтэй. Монгол Улс бол БНХАУ, ОХУ хоорондын тээврийн дамжин өнгөрөх цэг тодийгүй Төв Азийн бараа бүтээгдэхүүнийг Номхон далайн бүс нутагт хүргэх хамгийн дөт зам юм.

Бэрхшээлүүдийг даван туулахад нь АХБ маш олон талбар дээр Засгийн газартай хамтран ажиллаж байна. АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн хүрээнд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр, компаниудыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, хөдөө, суурингуудад хөдөлмөр эрхлэлтийг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлж, мөн брэнд бүтээгдэхүүний маркетингийг нэвтрүүлж байна.

10 орныг эгнээндээ нэгтгэсэн Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд АХБ, Монгол Улсыг хөрш зэргэлдээх зах зээлүүд түүний дотор БНХАУ болон Япон улс руу махан бүтээгдэхүүн экспортлох боломжийг олгох ариун цэврийн стандартыг бэхжүүлэхэд анхааран ажиллаж байна. Монгол Улс 40 гаруй сая толгой малтай гэдгийг санах нь чухал. Ийм ч учраас хөдөө аж ахуй, мал аж ахуйн салбар хэзээд уул уурхайтай харьцуулахад том ажил олгогч салбар хэвээр байх болно. Хил дамнасан малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх АХБ-ны санхүүжилттэй шинэ төсөл нь энэ чиглэлээрх бизнесийг хөгжүүлэхэд тус дөхөм болж байна.

Ажил, орлогыг нэмэгдүүлэх нь

Иргэдийг таатай бөгөөд тогтвортой ажлын байраар хангах нь тэднийг бололцоотой сайхан амьдрахад чухал ач холбогдолтой. Үүний тулд олон талт цогц арга хэмжээ авах шаардлагатай. Монгол Улсад уул уурхай нь экспортын орлого, өсөлтийг бий болгодог бол, ажлын байрны ихэнхийг жижиг, дунд үйлдвэрүүд хангаж байна. Ажлын байр бий болгохын тулд, нэгдүгээрт, аж үйлдвэрлэлийн хөгжлийн үндэс суурь болсон дэд бүтэц түүний дотор компаниудыг үйлчлүүлэгч, ханган нийлүүлэгчидтэйгээ хамтран ажиллахад чанартай тээврийн сүлжээ, найдвартай эрчим хүчний хангалтыг бий болгох хэрэгтэй.

Хоёрдугаарт, Монгол Улсад орчин үеийн чадварлаг ажиллах хүчнийг бэлтгэх хэрэгтэй байна. Эдийн засгийн бүтэц өөрчлөгдөж, улам бүр нээлттэй болж, технологи түүний дотор мэдээлэл, харилцааны технологийг өргөнөөр ашиглах болсон нь ур чадвартай ажиллах хүчний хэрэгцээг хурдацтай нэмэгдүүлж буй. Өнөөдөр ажиллах хүчний ур чадвар харьцангуй доогуур байгаа нь хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээг хангахгүй байна. Иймд ажилчдын ур чадварыг сайжруулж, зах зээлийн эрэлт хэрэгцээг хангаж, эдийн засгийн төрөлжилтийг дэмжиж, ядуу иргэдийн орлогыг нэмэгдүүлэх шаардлагатай.

Гуравдугаарт, санхүүгийн салбар бизнесийг дэмжиж, эрсдэлээс сэргийлэн ажиллахад нь хөрөнгөөр хангах чухал үүрэгтэй. Жижиг дунд үйлдвэрүүдийн хувьд аюулгүй, тогтвортой орчинг бүрдүүлэхэд санхүүгийн болоод төрийн бодлогын дэмжлэг хэрэгтэй байна.

Цаашдын хамтын ажиллагаа

Хамтран ажиллах хугацаандаа АХБ, Монгол Улсын хамт зах зээлийн эдийн засагт шилжих адармаатай даваа, дараалсан хүнд бэрх өвлүүд, хамгийн сүүлд дэлхийн эдийн засаг, санхүүгийн хямрал гээд олон бэрхшээлтэй тулгарав. Монгол Улс энэ бүх хямралуудыг гайхалтай даван туулж, өнөөдөр зах зээлийн эдийн засгийг байгуулахад хүрсэн амжилтаараа шилжилтийн орнууд дунд тэргүүлж явна. Монгол Улс саяхан Ази, номхон далайн бүс нутагт эдийн засаг нь хурдацтай өсч буй орнуудын эгнээнд болон мөн, доогуур дундаж орлоготой ороны тоонд тооцогдох болсон. Тус улсын эдийн засгийн чадамжийг үнэлж, 2011 онд Монгол Улс АХБ-ын хөнгөлөлттэй зээлийн хажуугаар энгийн эх үүсвэрээс санхүүжих эрхтэй болсон юм. АХБ-ны “ААА” зээлжих зэрэглэлийг ашиглан Монгол Улсад маш таатай нөхцөлөөр хөгжлийн төслүүдэд санхүүжилт олгож байна. АХБ одоо хотын дэд бүтэц, гэр хорооллын хөгжил, техник мэргэжлийн боловсрол, санхүүгийн салбарын хөгжил гээд төрөл бүрийн салбарт санхүү, техник арга зүй, мэдлэгийн дэмжлэг үзүүлж, Засгийн газартай хамтран ажиллаж байна. АХБ цаашид шинээр гарч ирж буй бэрхшээлүүдийг шийдвэрлэж, Монгол Улсад тогтвортой, бүх нийтийг хамарсан өсөлтийг хангахад нь туушталт хамтран ажиллах болно. ■

Б.ЦЭЦЭЭ

Доктор Профессор Найжл Финч нь Сиднейн Их сургуулийн Бизнесийн сургуулийн элсэлт хариуцсан захирлаар ажиллаж байна. Тэрбээр Ази болон хүч түрэн гарч ирж буй эдийн засагтай орнуудын хөгжил, бизнесийн хууль, эрх зүйн зохицуулалтаар мэргэшсэн нэгэн юм. Монголын бизнесийн зөвлөлийн гишүүн Найжл Финч одоогоор Австралийн олон улсын хөгжлийн агентлагт зөвлөхөөр ажилладагийн хувьд Монголын Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж зэрэг төрийн албадад мэргэжлийн зөвлөгөө өгч байна.



Фотог Э.Зоригт

ШИЙДЭЛ

ХЭТ ОЛОН ЭХЛЭЛ, ЗОГСОЛТ

-Монгол руу хөтлөгдөх болсон Таны шалтгаан юу байсан бэ?

-Хөгжиж буй зах зээлтэй орнуудыг сонирхдог байлаа. Ялангуяа тэдгээр улсын эдийн засгийн хөгжлийн явцад шаардагдах өр, хувьцаагаар илэрхийлэгдэх хөрөнгийн хэмжээг ихээхэн ажигладаг. Оюутолгойн гэрээг үзэглэж, ханцуй шамласнаас хойш төдийлэн урт хугацаа өнгөрөөгүй байна. Монгол Улсад 2009 оноос хойш ирсэн. Танай улсын зах зээл олон улсад нээлттэй хөгжөөд удаагүй байгаа. Магадгүй татагдсан шалтгаан минь энэ байх. Монголын хөгжлийн замналыг алдалгүй ажиж ирлээ. Ил тод нээлттэй байдал тааруухан учир мэдээлэл олж авахад хүндрэлтэй. Эдийн засгийн хувьд ч тэр жижиг учир цөөн тулгууртай улс. Тиймээс эдийн засагт юу болж байгааг мэдэхэд олон салбар руу савчих шаардлагагүй.

-Монголын Ардчилал дөнгөж 23-хан настай. Харин огцом өсөлтийн тухайд сүүлийн хоёр, гуравхан жилд л бий болсон үзэгдэл. Хурдацтай өсөлтийн хажуугаар Монгол Улс олон сорилтуудтай тулгарч буйг Та харж байна. Монголыг ямар томоохон эрсдэлүүд хүлээж байна вэ?

-Монголын байр суурь юу байх вэ. Энэ улсын хувьд хүн ам асар цөөн. Хятад улс шиг хэрэглэгч орон байх боломжгүй. Мөн Монголд өндөр хөгжсөн аж үйлдвэрлэл, эсвэл түүний чадамж бараг байхгүй. Тэгэхээр өндөр технологи, үйлдвэрлэлийн цогц орон байх боломжгүй. Монголд байгаа нь байгалийн баялаг. Энэ улсыг нээх, өөрчлөх хүч нь байгалийн баялаг юм. Түүнийг хэрхэн залах нь Монгол Улсын дэлхийн тавцан дахь байр суурийг тодорхойлно. Чухам энэ л Монгол Улсын ирээдүйн боломжуудын үүсвэр юм. Гэвч одоогоор Монголын эдийн засаг хэврэг байна. Хэрэгтэй хөрөнгө оруулалтыг татаж, байгалийн баялгаа дэлхийн ханган нийлүүлтийн сүлжээнд оруулж ирэх хэрэгтэй. Монголын хувьд өнөөдөр дэд бүтцэд чиглэсэн хөрөнгө оруулалт, болон гадаадын шууд хөрөнгө оруулалт ямар замаар, яаж орж ирэх нь энэ мэт бүрхэг үргэлжилбэл олон улсын хөрөнгө оруулагчид үргэж, илүү нээлттэй, хөгжиж буй бусад зах зээлийг сонгож магад. Энэ бол маш том асуудал.

Ардчилалд дөнгөж хөл тавиад буй Зүүн Азийн Мьянмар үүний тод жишээ. Байгалийн баялгийн асар их нөөц, усан боомтын гарцуудтай орон. »

Дээр нь хүн ам цөөн. Хятад улс арилжааных нь хамгийн том түншүүдийн нэг. Өнөөдрийн Монголоос харьцангуй хөгжил доогуур яваа тус улсын Засгийн газар хэрэгцээт хөрөнгө оруулалтыг зохих хэмжээнд татах, түүнчлэн гадаадын хөрөнгө оруулалтын аюулгүй байдлыг хэрхэн хангах вэ гэхчлэн асуудалд ихээхэн болгоомжтой бөгөөд мэдрэмжтэй хандахыг эрмэлзэж буй. Энэ улс өнөөдөр Монголын адил олны анхаарлыг зүй ёсоор татаж, хөгжиж буй орны нэг гэдгийг санах нь зүйтэй.

Өөр нэг асуудал нь гадаадын хөрөнгө оруулалттай холбогдсон хэт олон эхлэл, зогсолт. Олон улсын валютын сан Монгол Улсын 23 жилийн түүхтэй салшгүй холбоотой. Өнгөрсөн хугацаанд эдийн засаг нь бүдрэх бүрийд энэ байгууллага амь тариа хийж, зургаан удаа аварсан. Энэ нь дөрвөн жил тутамд нэг удаа гэсэн үг. Төлөвлөлт, гүйцэтгэл нь хоорондоо авцалдахгүй байгааг энэ мөчлөг харуулж байна. Ингээд тусламж эрэхээс өөр аргагүй байдалд Монгол орж байсан.

-Уул уурхайн ямар стратегийг Та Монголд санал болгох вэ. Өөрөөр хэлбэл, уул уурхай цэцэглэж, бусад салбар нь салгалж буй одоогийн нөхцөлөөс бид хэрхэн зайлсхийх вэ?

-Бусад салбарын уул уурхайд шахагдаж буй нь цалингийн инфляцитай холбоотой. Арван жилийн өмнө туршлагатай боловсон хүчний эрэлт барилгын салбарт хүчтэй байгаагүй учир өнөөдөр чадвартай мэргэжилтний дутагдалд орчихоод байна. Монголд өнөөдөр хэрэгцээтэй байгаа олон мэргэжил тав, арван жилийн өмнө байгаагүй. Хүмүүс шинэ ажил мэргэжлүүд рүү орж эхлэхэд цаг хугацаа нэлээд шаардах нь дамжиггүй. Гэвч үүний тулд ажилдаа туршлагажих боломж өгөх, сургалт зохион байгуулах гэхчлэн нөр их хүчин чармайлт хэрэгтэй нь мэдээж. Гаднын туршлагатай мэргэжилтнүүдийг урьж ажиллуулан, шийдсэн байдаг. Гаднын мэргэжилтнүүдийн мэдлэг чадварыг Монголын эдийн засагт шингээж авахын хажуугаар боловсон хүчнээ сургахад ашиглах. Туршлага шилжүүлэлтийн уг загварыг бий болгох нь зүйтэй. Гэвч өсөж буй эдийн засагт энэ тийм ч том бэрхшээл биш юм.

-Оюутолгойтой тэнцэх хэмжээний нөөцтэй дахиад 10 төсөл гарч ирэх боломж бий гэж байгаа. Үүнийг нэг дор гаргаад ирэх үү эсвэл ээлж дараатай байх нь манайд ашигтай юу?

-Хэрэгцээт дэд бүтцийг бүтээхийн тулд тодорхой төслүүдийг зэрэгцүүлэн хэрэгжүүлэх нь харьцангуй ашигтай. Дэлхийн хэмжээний томоохон төслүүдийг дагасан дэд бүтцийг байгуулна гэдэг асар өндөр өртөгтэй. Оюутолгойн бүтээн байгуулалтын эхний шатанд л гэхэд хэдий хэмжээний хөрөнгө оруулалт шаардсаныг хар. Монголын Улсын ДНБ-ийг хоёроор үржүүлсэнтэй тэнцэхээр болно гэж байна. Тус төсөл эхэлснээс хойш 10 мянга гаруй холбогдох бизнесийнхэн энэ зүгт татагдан орсон гэх мэдээ бий. Монголын бизнесийнхэн үүнээс ашиг хүртэж байгаа. Оюутолгой шиг төслүүд Монголд одоо л хэрэгтэй байна. Төслүүдийг зэрэгцүүлэн хэрэгжүүлж эхэлбэл олон төслийг тэжээх хүчин чадалтай цөөнгүй эрчим хүчний станц, гарц боломжийг бүрдүүлэх дэд бүтэц бий болгож болно. Эдийн засгийн бодит үр ашгийг хүртэхэд энэ л шаардлагатай.

Монголд уул уурхайтай эн зэрэгцэж түшиц болох салбарыг нэрлэхгүй юү?

Санхүүгийн салбар чухал үүрэг гүйцэтгэнэ. Хөдөө аж ахуй, уул уурхайн салбар голлодог Австралийн эдийн засгийг жишээлье. Тус хоёр салбар эдийн засгийн хурдыг



тодорхойлдог ч манай улсын эдийн засгаас үл хөдлөх болон санхүүгийн салбарыг салгаж ойлгох боломжгүй. Дэлхийн санхүүгийн системийн хөгжлийг авчирч, санхүүгийн бүрэн үйлчилгээг бий болгоно гэдэг боловсролын салбарт асар их хөрөнгө оруулалт шаардана гэсэн үг. Хөгжил доогуур хөрөнгийн зах зээл, үр хөврөлийн үе дээрээ яваа банк, даатгалын салбарыг харахад институцийн хүрээнд хүмүүсээ сургахаас эхлээд маш ихийг хийх хэрэгтэй нь тодорхой. Уул уурхайгаар эхлэсэн ч Монголын ирээдүй гэгээлэг байна.

-Монгол Улсын олон улсын зах зээл дээр босгосон 1.5 тэрбум ам.долларын бондыг зарцуулах гэж байгаа байдлыг хэрхэн дүгнэж байна вэ?

-Засгийн газарт хууль ёсны хөрөнгө босгох мандат нь байгаа. Хуучнаар Хөгжил, шинэтгэлийн хороонд төслүүдийн санал байсан. Хөгжлийн банкинд ч тэр юунд зарцуулж болохгүй вэ гэдэг хоригууд байгаа. Энэ мөнгийг төсвийн алдагдал тэргүүтэй зарлагуудад зориулах гэж босгоогүй.

Хөрөнгө оруулах ёстой тэргүүлэх салбарууд тухайлбал, зам, төмөр зам зэрэг нь тодорхой байсан. Өдөрт 200.000 ам.долларын хүүтэй мөнгийг. Бондыг дагах дээрх хүүгийн төлбөрийг Монголын Засгийн газар төлнө. Үндэсний эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөө гэж байх ёстой. Үүний дагуу голчлон ямар төслүүдэд хөрөнгө оруулахаа тодорхой заагаад өгчихвөл гаднын хөрөнгө оруулагчид хаана хөрөнгө оруулж болохыгоо шийдэх итгэл, баримжаа бий болно. Жишээлбэл, А хотоос Б хот руу төмөр зам тавилаа гэж бодьё. Энэ нь нөгөө талаар үл хөдлөх хөрөнгө болон үйлчилгээний салбарт хөрөнгө оруул гэсэн бизнесийн дохио. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн хөгжлийн голлох суурийг бүрдүүлэхэд бусад зах зээлийн оролцогчид аяндаа дагаад ирдэг гэсэн үг.

Одоогоор хөрөнгө оруулах төслүүдийг жагсааж буй. Гэвч яг ямар төслүүдийг сонгох нь тодорхойгүй нь Монголын хувьд бонд ашигтай байх эсэхэд эргэлзээ төрүүлж байна. Юу болоод байгаа нь хэт таамгийн шинжтэй. Үндэсний эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөөндөө түлхүүр салбаруудаа тодорхойлж, цаг хугацааны хуваарийг гаргах цаашлаад хөрөнгө оруулалтыг хэрхэн шийдэхийг зааж өгөх хэрэгтэй. Гаднынхан төдийгүй монголчуудад ч дээрх асуудлууд тодорхой биш байх шиг санагддаг.

-Тогтвортой хөгжил бүхий эдийн засагт Монголыг хөтлөх Австралийн ямар туршлагууд бидэнд хэрэгтэй вэ?

-Австрали улсад уул уурхайн гайхам туршлага, чадамж бий. Хууль, эрх зүйн бат бөх, ойлгомжтой бүтэц л “тогтворыг” бий болгодог юм. Мөн удаан хугацааны төслүүд. Уул уурхай бол үл хөдлөх хөрөнгө шиг хоёроос гурван жилийн дотор газар худалдаж авч, төлөвлөгөө зохиогоод, бариад зарчихдаг төсөл биш. Дор хаяж 30-50 жилийн хугацаа шаарддаг учир найдвартай хууль, эрх зүйн зохицуулалтаар дийлэнх үйл ажиллагаагаа явуулснаар үйл хэрэг болдог том ажил. Хууль, эрх зүйн тогтвортой орчин, санхүүгийн зах зээл л эдийн засгийн тогтвортой хөгжлийг тодорхойлно. Эдгээр нь Монголд сул хөгжсөн учир томоохон хэмжээний төслүүдийг хэрэгжүүлэхэд саадтай байна.

-Таныг Монголын Засгийн газрын зарим хэрэгжүүлэгч агентлаг, яаманд зөвлөхөөр ажилладаг гэж сонссон. Тэдэнд хаягласан зөвлөгөө гол төлөв юунд чиглэдэг вэ?

-Ашигт малтмалын тухай хуулийг ярьж байгаа энэ үед хөрөнгө оруулагчидтай хэлэлцээр хийж буй нь монголчуудын хувьд ихээхэн мэдрэмтгий үе болж байна. Өдийг хүртэл үндэсний хэмжээний дэд бүтцийн хөрөнгө оруулалтуудыг хэрхэн шийдэх нь тодорхойгүй байсаар байна. Олон улсын хөрөнгө оруулагчдын санаа зовниж буй нийт улсын эрсдэлийг тойрсон шүүмжлэл болон ил тод нээлттэй байдлыг сайжруулах асуудал Засгийн газрын толгой дээр байна гэдгийг санах хэрэгтэй.

Хаана яваагаа шалгаж болох хамгийн сайн арга бол Монголын зээлжих зэрэглэл. “Moody’s”, “Standard and Poor’s” зэрэг үнэлгээний байгууллагын зэрэглэл нь Монгол Улстай бизнес хийхэд ямар байхыг харуулж, зээлжих чадварыг нь үнэлж буй хэрэг. Одоогийн байдлаар Монголын зээлжих зэрэглэл хөрөнгө оруулалтын бус түвшинд яваа. Энэ нь хөрөнгө оруулалт орж ирэхгүй гэсэн үг биш. Гэвч гадаадын хөрөнгө оруулагчдад энэ нь том эргэлзээ өөрөөр хэлбэл хориг юм. Үүнээс гадна зэрэглэлийг тойрсон шинжээчдийн дүгнэлтүүд тэдэнд тухайн улсын сул талыг маш тод харуулдаг. Тиймээс Монголын Засгийн газар дээрх шинжээчдийн шүүмжлэлүүдийг анхаарч, авч үзэн дэлхийн жишгээс доогуур явж буй хэсгүүдээ сайжруулах механизмыг бүрдүүлэх хэрэгтэй. Зээлжих зэрэглэлээ дээшлүүлэх нь Монголын нийт эдийн засагт тусаа өгөх зүйл. Дээрх үнэлгээ зөвхөн Монголын Засгийн газрын хөрөнгө босгох өртгийг бууруулаад зогсохгүй. Одоогоор нийт хоёр тэрбум ам.доллар босгочихсон байгаа. Судалгаагаар Монголын эдийн засагт нийт 60-80 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай гэдэг нь харагдаж байна. Нэмж маш их мөнгийг дэлхийн зах зээл дээрээс босгоно гэсэн үг. Улсын зээлжих зэрэглэл ахиснаар энэ хэмжээ ч багасна. Дээрх хэрэгцээт 60 тэрбум ам.долларыг нэг бүхэл гэж үзье. Үүний хүүг нэг хувиар доогуур тогтоож чадвал жилдээ 500 сая ам.долларыг хэмнэнэ гэсэн үг юм. Хэрвээ дээрх шүүмжлэлүүдийг анхаарч, илэрхий дутагдлуудаа засч эхэлбэл зэрэглэл ахихад тодорхой нөлөөлнө. Гадаадын шууд хөрөнгө оруулагчид Монголд орж ирэх гарц саадгүй болохын зэрэгцээ банкууд өөрсдийн зэрэглэлээ ахиулах замаар олон улсын санхүүгийн зах зээлд өргөн хүрээнд оролцох улмаар хувийн хэвшлийнхэн гадаадын хөрөнгө оруулалтад хүрэх боломж илүү чөлөөтэй болно. ■

НОГООН ЭДИЙН ЗАСАГ

ШИНЭ СОЁЛ ИРГЭНШИЛ



Ч.ЛУТАА

Ногоон эдийн засгийн талаар судалдаг цөөхөн эрдэмтний нэг БОНХЯ-ны Ногоон хөгжлийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Т.Чулуунтай “Ногоон соёл иргэншил” гэх ойлголтын талаар ярилцлаа. Гэхдээ энэ удаа уламжлалт ярилцлагаас зайлсхийж бодит баримтад тулгуурлан шинжлэх ухааны үндэслэлтэй Монголын улс төр, нийгэм, эдийн засаг ногоон хөгжлийн замаар явах боломж болон эрсдэлийн талаар мэргэжлийн хүний дүгнэлтийг сонсохыг зорилоо.

Муу дүн

Тогтвортой хөгжлийг хэмждэг шалгуур үзүүлэлтээр Монгол Улс муу дүн авдаг. Энгийн жишээ дурдахад л Нийслэлийн агаарын бохирдол гамшгийн хэмжээнд буюу тоосонцор хэвийн хэмжээнээс 10-25 хувиар их, нэг шоо метр агаар дахь PM-10 бодисын хэмжээ 279 милиграмм буюу 13.95 дахин их. Нийт нутгаар цөлжилт ихэссэн. Баян, ядуугийн ялгаа нэмэгдэж, ядуурал хамгийн сүүлийн байдлаар 30 орчим хувьд хүрсэн. Эдийн засгийн өсөлт өндөр байгаа ч иргэддээ наалдахгүй, байгаль орчны асуудал хурцаар тавигдаж байна. Мөн усны нөөц багасч, хүнсний аюулгүй байдал алдагдаж байна гээд дурдаад байвал дуусахгүй. Тэгвэл тогтвортой хөгжил гэж юу вэ.

Т.Чулуун: Бидэнд хоёр дэлхий хэрэгтэй

Тогтвортой хөгжил гэдэг нь “Ногоон” буюу бүх талын тогтвортой хөгжлийг хэлнэ. Гэхдээ байгаль орчны асуудлыг арай түлхүү авч үздэг. Дэлхий нийт яг өнөөдрийнхөөрөө 2030 он хүртэл явах юм бол бидэнд хоёр дэлхий хэрэгтэй болно. Гэтэл хүн төрөлхтөн ганцхан дэлхийтэй шүү дээ. Тийм учраас л дэлхий нийт “Ногоон” хөгжлийг ярих болсон юм. “Ногоон” хөгжлийг ярихын тулд байгаль орчин, нийгэм, эдийн засгийн гэх гурван хүчин зүйлийг авч үздэг. Өнгөрсөн 20 жилд Монгол Улс ардчилалын замналаар явсан нь маш том ахиц дэвшил болсон уу болсон. Гэхдээ нийгмийн бүтэц буюу засаглал өөрчлөгдөж байгаа учраас янз бүрийн алдаа гарч ирсэн. Монгол Улс байгаль орчин болон нийгмийн хувьд сүйрэл рүүгээ явж байна. Сүйрэл рүүгээ явж буй хөгжлийг “хүрэн” эдийн засаг буюу буруу тогтолцоо гэдэг. Тиймээс энэ замаар удаан явах нь улс үндэстнийг мөхөөж ч магадгүй. Харин монголчуудын хүрэх ёстой оргил бол “Ногоон” хөгжил юм. Зорилгодоо хүрэхийн тулд Монгол Улс ардчилалд шилжихэд ард иргэдийнхээ үзэл бодлоос аваад, улс төр, эдийн засаг гээд бүх зүйлээ 360 градус эргүүлсэн шиг асар том өөрчлөлт хийх хэрэгтэй. Бид зүгээр нэг бүтцийн өөрчлөлт хийгээд хол явахгүй харин эдийн засаг, улс төр, нийгмийн гээд бүх талын бүтцийг эргүүлэх учиртай. Үүнийг шинжлэх ухааны талаас нь Кузинецийн муруй гэдэг. Энэ нь өөрийн гэсэн хэд хэдэн хөгжлийг эргүүлэх аргатай шинжлэх ухааны нэр томъёо. Тухайлбал, аливаа улс байгаль орчны асуудлаа умартан эдийн засгийн өсөлтөд анхаардаг. Тэгвэл эдийн засгийн өсөлтийг хөгжил болгохын тулд эргээд байгаль орчиндоо анхаарах хэрэгтэй. Ингэснээр нөгөө ногоон хөгжлийн үндсэн гурван хүчин зүйлийн нэг болох байгаль орчин нь сэргэдэг. Мэдээж байгаль орчноо сэргээх, хайрлан хамгаалахын тулд нийгмийн буюу хүний үзэл бодлыг байгальдаа ээлтэй буюу ногоон боловсролоор хүмүүжүүлдэг. Ингээд эдийн засаг, байгаль орчин, нийгмийн гурван хүчин зүйл харилцан уялдаатай хөгжих учиртай юм. Гэхдээ улс төрийн хүсэл зориг ногоон хөгжлийн асар том хөшүүрэг.

Антропоген гэх геологийн шинэ эрин

Хүний үйл ажиллагаа дэлхийн тогтолцоонд нөлөөлөх болсноор хүн төрөлхтөн Антропоген гэх геологийн шинэ эринд орсныг эрдэмтэд хүлээн зөвшөөрөх болов. Дэлхийн газрын гадаргын 30-50 хувь нь хүний үйл ажиллагааны улмаас өөрчлөлтөд орсон байна. Энэ нь уур амьсгалын өөрчлөлт, биологийн болон төрөл зүйл устаж, азотын эргэлт дэлхийн ашуулгүй тогтолцооноос давсан өнөөгийн нөхцөлийг бүрдүүлсэн аж. Гэсэн хэдий ч өдгөө капитал цэцэглэж, дээд боловсролтой хүний тоо өсөж, бодит ба хүмүүн капиталын нөлөөгөөр нэг хүнд ноогдох орлого өссөөр байна. Үүний үр дүнд хүний хөгжлийн индекс ч сайжирдаг. Хүн төрөлхтөн үүнийг хүсээгүй гэж үү.

Т.Чулуун: Доголон тогтолцоо

Хүн төрөлхтөн хүн байгаль хоёрын уялдааг мартчихаад нэг хэсэг эдийн засаг гэж хошуурсан. Ямар ч хамаагүй аргаар эдийн засгаа л хөгжүүлэх гээд байдаг. Харин байгаль дэлхийгээ анхаараагүйн улмаас экологийн сүйрэл нэгэнтээ дагуулчихаад байна. Энэ нь хүний хөгжил өндөр ч, экологийн сүйрэл дагуулсан “доголон” тогтолцоо юм. Дэлхий байхгүй бол хүн оршин байхгүй гэдгийг санах хэрэгтэй. Харин хүнтэй хүнгүй эх дэлхий хэдэн сая жил наслаж чадна.

Тиймээс хүн, улс үндэстэн бүр байгаль орчны өөрчлөлтөд зохицон амьдрахаас өөр аргагүй. Тэгвэл байгальдаа зохицсон хэрнээ эдийн засаг нь өсөлттэй, хүн ам нь жаргалтай хэрхэн хөгжих вэ. Асуултын хариулт нь таван харилцан үйлчлэх хэсгээс бүрдэх учиртай. Үүнд улс төрийн хувьд байгальд ээлтэй үйл ажиллагааг дэмжих, хууль батлах. Эдийн засгийн хувьд сэргээгдэх эрчим хүч тэргүүтэй байгальд ээлтэй үйл ажиллагаа явуулж түүнээсээ ашиг олох. Нийгмийн хувьд адаглаад ард иргэд нь хогийн савандаа хогоо хаядаг. Аль болох ус, хүнсний хэрэглээндээ хямгатай хандах учиртай. Мөн тухайн ард түмний соёл, ёс заншлыг сэргээх нь чухал. Энэ үед байгаль орчин, эдийн засаг, соёл уламжлал бүгд сэргээд ирнэ. Байгаль орчин нь сэргэх тутам цэнхэр гаргийн нас уртсаж, хүний аюулгүй ажиллаж, амьдрах орчин баталгаатай болдог.

Сөрөг байр суурь

Экологийн сүйрлийг арилгахын тулд хөрөнгө оруулалт ихээр хийх нь бодит капиталд оруулах хөрөнгө оруулалтыг бууруулж улмаар нэг хүнд ногдох орлого буурна гэх хэсэг бий. Хүмүүс эргээд “зэрлэгшиж”, Адам смит тэргүүтэй эдийн засагчдын онол үнэгүйдэж, ардчилалын үнэ цэнэ алдагдах гээж үү гэх нь ч бий. Товчхондоо ногоон хөгжил гэх нэрийн дор хүн төрөлхтөн өнгөрсөн рүүгээ ухрах вий.

Т.Чулуун: Сэргэн хөгжихүйн загвар

Ямар ч хөгжил эхэн үедээ хүчээ авч цаашлаад хөгжлийн чадамж, санах ойтой болдог. Харин дараа нь ямар нэг алдаанаас шалтгаалж хямралд ордог. Үүнийг “Resilience” гэдэг. Эл загвар нь улс үндэстний болон дэлхий дахины гэх харилцан хамааралтай. Энэ нь даяаршилтай холбоотой юм. Том гүрний хямрал дэлхий дахинд нөлөөлөх гэдэг ч юм уу. 2008 оны Америкаас улбаатай санхүүгийн хямралыг дурдаж болох юм. Тэгвэл хямралд өртөхгүй байх ямар арга байна вэ. Хямралд өртөхгүйн тулд хөгжлийн явцад бий болсон санах ойгоо ашиглах хэрэгтэй. Тэнд алдаа, онооны аль аль нь бий. XXI зуунд хүн төрөлхтөн хөгжих аргаа “Ногоон” гэж тодорхойлсон. Гэхдээ аливаа зүйлд сул тал байх нь зайлшгүй. Ямар ч алдаагүй Супер санаа гэж хаа ч үгүй. Үргэлж сайжирсаар л байдаг.

Зарим судлаачдын хэлдгээр ногоон хөгжил өнгөрсөн рүүгээ ухрах алхам гэдэг ч юм уу сөрөг байр суурийг хүлээж авах хэрэгтэй. Дээрх онолын дагуу “Ногоон” хөгжил ч гэсэн ялгаагүй хямралд өртөж магадгүй. Тиймээс бид өөрсдийн уламжлал, ёс заншлаа буюу санах ойгоо эргээд харах хэрэгтэй. Монголчуудад гайхалтай боломж бий. Бид байгальдаа зохицоод улс орноо өдий хүртэл хөгжүүлж чадсан нүүдэлчин соёл иргэншилтэй. Тиймээс тэр санах ойд байгаа зүйлсийн сайныг аваад мууг нь хаях хэрэгтэй.


Ногоон сорилт ногоон боломж

Монгол түмний олон мянган жил амьдарч ирсэн дадал заншил нь байгальтайгаа ойр, хамгийн бага хэрэглээтэй, байгаль орчноо тогтвортой ашигладаг тийм л ард түмэн байсаар ирсэн. Энд яриад байгаа ногоон хөгжил тэнд агуулагдсан байжээ гэдгийг хүнээр хэлүүлж, баримтаар баталгаажуулаад байхаргүй бодитой зүйл. Тиймээс БОНХЯ-наас “Ногоон хөгжлийн стратегийн төсөл 2030” тогтвортой хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхээр болжээ. Уг төсөлд Монгол Улсын нутаг дэвсгэрийг зан заншил болоод түүхийн гэвэл таван хэсэгт хуваан хөгжүүлэх санаа дэвшүүлсэн байна. Үүнд, Нүүдлийн соёл иргэншлийн өв газар, Их говийн өв газар, Хангайн нурууны өв газар, Цагаан зээрийн өв газар, Тулгар төрийн өв газар багтаж байгаа аж. Тус яамны мэргэжилтэн Б.Доржготов “Монголчууд үндэсний брэнд бий болгох талаар ярьдаг болжээ. Тэгвэл төслийн хүрээнд дэлхий нийтийн чиг хандлага болох ногоон сэтгэхүйд тулгуурлан Монгол Улсын цоо шинэ нэр хүндийг бий болгож болох юм” гэв. Яагаад болохгүй гэж.

Үндэсний буюу бүс нутгийн брэнд нь тухайн үндэстний давуу талыг тодорхойлох хүчирхэг нэр хүнд байдаг. Өнөөдөр Швейцарь орны нэрийг сонсоход л хүмүүст худалдан авах, хөрөнгө оруулалт хийх, амьдрах газраа солих эсвэл аялал жуулчлалаар явах шийдвэрт нөлөөлөх дүр зураг буудаг шиг Монгол гэх нэрийг сонсоод л онгон зэрлэг байгаль, түүх соёл, ногоон эдийн засгийн талаар төсөөлдөг байж яагаад болохгүй гэж. Гэхдээ энэ мөрөөдлийг биелүүлэхийн тулд багагүй ажил хийх хэрэгтэй аж. Адаглаад байгаль орчин, эдийн засаг, нийгэм, засаглалын гэвэл харилцан уялдааг хангах. Өөрсдийн өвөрмөц давуу талыг маркетингийн болон бусад аргаар дэлхий нийтэд таниулах. Өндөр үр ашигтай технологи, ногоон стандартыг нутагшуулах гэвэл хийх ажил их. Т.Чулуун “Монголын цоо шинэ нэр хүндийг бий болгох “Ногоон” хөгжилд хөл тавихын тулд таван чиглэлээр найман зорилго, 45 зорилтыг дэвшүүлээд байгаа. Эдгээр нь бүгд хэмжиж болдог хэрэгжих боломжтой зорилго, зорилтууд юм” гэв. “Ногоон хөгжлийн стратегийн төсөл”-д зааснаар бол монголчууд хоёр үндсэн үе шаттайгаар ногоон соёл иргэншилд хүрэх аж.

Нэгдүгээрт, 2013-2020 он хүртэлх буюу шилжилтийн үе. Хоёрдугаарт, Ногоон соёл иргэншлийг цоцлоон бүтээх үе ба 2020-2030 он юм. Харин уг зорилгод хүрэхийн тулд 2020 онд эрчим хүчний хэрэглээний 20 хувийг сэргээгдэх эрчим хүчээр хангах. Байгалийн гамшгийн жилийн хохирлыг 2020 он гэхэд 2010 оны түвшнээс 10 хувь, 30 он гэхэд 15 хувь хүртэл бууруулах гэвэл олон зорилтыг дэвшүүлсэн байна. Харин эдгээр зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд дээрх шинжлэх ухааны болон эдийн засгийн аргыг хэрэглэж гэмээнэ тодорхой үр дүнд хүрэх учиртай ажээ.

Дэлхий нийт нэгэнт “Ногоон” хөгжлийн зүг хөлгийн жолоо залсан энэ үед монголчууд ч гэсэн хөгжлийн галт тэрэгнээс хоцрох учиргүй. “Ногоон” гэх тодотголтой галт тэргэнд суух тасалбар Монголын халаасанд бий. ■



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГАЗАР

MISHEEL GROUP
EXPO - FURNITURE - BUSINESS PARK

УЛААНБААТАР БАРИЛГА 2013

МАТЕРИАЛ - ШИНЭ ТЕХНИК ТЕХНОЛОГИ • ОРОН СУУЦ - ХОТ ТОХИЖИЛТ ҮЗЭСГЭЛЭН • 8 ДАХЬ ЖИЛДЭЭ

БАРИЛГЫН МАТЕРИАЛ ШИНЭ ТЕХНИК ТЕХНОЛОГИ - 2013

2013.03.01-04








ОРОН СУУЦ ХОТ ТОХИЖИЛТ - 2013

2013.03.15-18






МИШЭЭЛ ЭКСПО-д УТАС: 344393, 88077064

ОЮУТОЛГОЙ

АНХНЫ БАЯЖМАЛ

Б.БАЯРТОГТОХ

Монгол Улсын зэсийн баяжмалаас олж болох ашгийн “алтан үе” айсуй.

Монголын аймаг бүр өөрийн брэндтэй гэдэг. Өмнөговь ингэний хоормог, Баянхонгор ааруул, Увс чацаргана, Ховд тарвас, Булган Сайхан сумын айргаараа алдартай. Гэвч үүнийг дэлхий мэдэхгүй нь харамсалтай. Архангайн цагаан идээ, Говь-Алтайн арвайн гурил, Хөвсгөлийн цагаан загасыг амталж үзээгүй хүн цөөхөн монголчууд дунд олон бий. Манайд л ганцхан бий гэж хэлж болохоор дээр өгүүлсэн бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлд сойх цаг хэдийнэ болсныг хэн хүнгүй хэлж, бичдэг. Гэтэл олон улсын зах зээлд Оюутолгойгоос өөр Монголын талаар анхаарал татахуйц сэдэв алга. Товчхондоо, Монгол Улсыг Олимпын аварга Оюутолгойн ордоор нь дэлхий нийт өнөөдөртөө мэдэж байна. Өмнө нь Чингис хаанаар төсөөлж, энэ зууны эхэнд XIII зууны төрхөөр бодох нь элбэг байж. Түүхээр бахархаж болох ч түүгээр амьдарч болдоггүй зах зээлийн нийгэмд Монгол Улс оршин тогтнож буй. Тиймээс өөр нэг брэндтэй байх ёстой аж.

Шууд брэнд болдог салбар манайд бий. Үүний нэг нь уул уурхай. Уул уурхайн салбарт од болж буй олон улсын чанартай ганцхан төсөл байгаа. Энэ нь Оюутолгой. Хэдий Монголыг уул уурхайн баялагтай орон гэж дэлхий нийт харах ч Оюутолгойн ордоор танин мэдэж байна. Оюутолгой орд Монголыг олон улсад таниулах нэрийн хуудас болохын зэрэгцээ зах зээлийн шинэ боломжийг дотоодын зах зээлд үндэслүүлж буй. Уг ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах төслийн хүрээнд Монголын дотоодын ханган нийлүүлэгч компани, аж ахуйн нэгжүүдээс бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авахад зориулж 1.1 тэрбум ам.доллар зарцуулжээ. Мөн орон нутгийн 53 бизнесийн байгууллагад “Бичил зээлийн сан”-гаар дамжуулан 1.2 сая ам.долларын зээл олгожээ. Өнгөрсөн онд хамтран ажилласан бүх ханган нийлүүлэгчийн 67 хувь нь Монголын компани, аж ахуйн нэгжүүд.

Цагаан сарын өмнө Оюутолгой орд зэсийн анхны баяжмалаа үйлдвэрлэсэн. Түүхэн үйл явдал өмнийн говьд тохиож, аж үйлдвэрийн салбар үсрэлт хийв. Ингэснээр монголчууд дэлхийн зэсийн зах зээлд “хос морьтой” болж байна. Нийт экспортын 28 хувийг эзлэх зэсийн баяжмалыг “Эрдэнэт” үйлдвэр өнгөрсөн хугацаанд дангаар нийлүүлж ирсэн. Манайх цэвэр зэсийн 36.3 сая тоннын нөөцтэй. Таамаг нөөц нь 1.2 тэрбум. Зэсийн түшиц орд нь Оюутолгой, Цагаан суварга, Эрдэнэт. 2020 он гэхэд дотоодын зэсийн нийт олборлолт хоёр дахин өсөх тухай Ашигт малтмалын газрын судалгаа бий. Энэхүү өсөлтийн 70 гаруй хувь нь Оюутолгой ордод ногдож байна.

Оюутолгой төсөл зэсийн баяжмалаа гадаад зах зээлд гаргаснаар экспорт харлах бус шарлахад түлхэц болох юм. Өмнө нь экспортын орлого нүүрсээр төрөлжиж байсан бол ирэх жилүүдэд Оюутолгой, Эрдэнэтийн зэс гадаад худалдаанд түүчээлэх нь. Өөрөөр хэлбэл, төсвийн орлого нүүрснээс бус зэсээс хамаарах



“урьдын шүтэлцээ” сэргэх аж.

Оюутолгой уурхайн Баяжуулах үйлдвэрийн хөвүүлэн баяжуулах хэсгийн ахлах инженер П.Мөнхтуяа “Энгийнээр хэлбэл хүдэр боловсруулж зэсийн баяжмал гаргадаг. Зэсийн баяжмалаас зэсээ ялгаж хайлуулна. Баяжмал хамгийн гол нь өндөр агууламжтай байх ёстой. Өнөөдрийн хувьд баяжмал дунджаар 24 хувийн зэсийн агууламжтай байгаа. Өөрөөр хэлбэл, 100 гр зэсийн баяжмал байлаа гэхэд 24 гр нь зэс. Бас дагалдах метал бий. Энэ агууламж өдөр бүр тодорхой хэлбэлзэлтэй” хэмээн онцолсон.

Экспортын өнгийг нүүрс тодорхойлж байсан бол өдгөө зэс, зэсийн баяжмал гадаад худалдааг өнгөлөх нөхцөл бүрдэж байна. Зэс экспортод тэргүүлэх хэд хэдэн шалтгаан бий. Үүнд Дэлхийн зах зээлд нэг тонн зэсийн үнэ 8000 ам.доллартай тэнцэж, ханшаа тогтвортой хадгалах болсон, Оюутолгой зэсийн баяжмалаа үйлдвэрлэж эхэлсэн, Эрдэнэт үйлдвэрийн экспортын орлого өссөн, БНХАУ-д зэсийн эрэлт үүссэн. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын зэсийн баяжмалаас олж болох ашгийн “алтан үе” айсуй.

Зэсийн үнэ дунд болон урт хугацаандаа өөдрөг байна хэмээн шинжээчид дүгнэж буй. Ийм цаг үеийг олж Оюутолгой төсөл анхны зэсийн баяжмалаа үйлдвэрлэж, төслийн бүтээн байгуулалт хоёр дахь үе шатанд шилжлээ. Бүтээн байгуулалт өмнийн говьд шинэ соёлыг ойртуулахын зэрэгцээ олон улсын стандартыг хангасан нисэх онгоцны буудлыг төвхнүүллээ.

Дэлхийн ашигт малтмалын зах зээлд Монгол Улс Оюутолгой гэсэн өөрийн брэнд бүтээгдэхүүнтэй болж байна. Оюутолгойн төслөөр Монголын уул уурхайн салбарын хөгжил, эдийн засгийн өрсөлдөх чадварыг хэмжих, тамир тэнхээг шалгах стандарт тогтож буй. Хариуцлагатай уул уурхайн сайн жишгийг Оюутолгой төсөл гэж үзэх болов. Дэлхийн хэмжээний төслөөр дамжуулан Монголыг дэлхийн хүмүүс танин мэддэг боллоо. Өмнө нь бидэнтэй түүхээрээ “танилцсан” бол өнөөдөр баялагтай нь “гар барьж” байна. Маргааш тантай уулзах биз ээ.



Манайх жинхэнэ брэнд болох бүтээгдэхүүнтэй ч дэлхий мэдэх нь эргэлзээтэй. Чингисийн Монголыг тив дэлхий мэддэг бол Оюутолгойг шинэ дэлхий нээн таниж буй. Оюутолгой ордоор нь Монголыг дэлхийн газрын зураг дээр заадаг болсон. Уг төсөлд ажиллахаар тив алгасан шинэ ажиллах хүч, шинэ технологи Монголд ирэх боллоо.

Монголын уул уурхайг хэн “од” болгосон бэ. Мэдээж, Оюутолгой. Оюутолгойг олж нээсэн хүмүүс нь монголчууд. Тэд брэнд бүтээгээгүй ч олж тогтоосон. Олсон эрдэнэсээ дэлхийн брэнд болтол нь менежмент хийсэн гэж хэлж болно. Оюутолгойг сонсоогүй нэг ч хөрөнгө оруулагч үгүй байх. Зөвхөн гаднын хөрөнгө оруулагчдад бус дотоодын жижиг, дунд үйлдвэрлэл, цэцэглэж буй зах зээлд өргөн боломж, нээлттэй сонголтыг “Оюутолгой” өвлүүлсэн. Тэдэнд хөгжих, хүч тэнхээ орох “витамин” болсон. Оюутолгой хэмээх хөрөнгө оруулалтын төслийг тойрод ханган нийлүүлэлт, банк санхүү, жижиг дунд үйлдвэрлэл, орон нутгийн дэд бүтэц, бүтээн байгуулалт зэрэгцэн хөгжиж буйг онцлон тэмдэглэе.

“Уг төсөл бол Монгол Улсын түүхэнд хийгдсэн хамгийн том, анхны хөрөнгө оруулалт бөгөөд хөрөнгө оруулагч нь эдүгээ дэлхийн дөрөв дэх том уул уурхайн компани болох “Рио Тинто”. Лондон, Брисбан хотуудад төвтэй Англи-Австралийн энэ компани Испанийн Хуелва мужийн Тинто голын сав газрын нэгэн уурхайг ашиглахаар 140 жилийн өмнө байгуулагджээ. Хөнгөн цагаан, төмрийн хүдэр, зэс, уран, нүүрс, алмаазын олборлолтоор дэлхийд тэргүүлэгч тус компанийн зах зээлийн үнэлгээ одоогоор 107 тэрбум доллар” хэмээн Эдийн засагч, нийтлэлч Д.Жаргалсайхан “Оюутолгой”-доо оюунлаг толгойгоор хандъя” нийтлэлдээ бичжээ. Та бидний хэзээний мэдэх Оюутолгой. Уг орд улс төрийн байнгын сэдэв болох ч Монголоос дэлхийн зах зээлд тодорч гарч буй брэнд аж. ■



Where logistic
solutions are needed..,

LANDBRIDGE LLC
INTERNATIONAL FREIGHT FORWARDERS



With its unrivalled growth history, professionally recognized for enjoying the strongest financial metrics in Mongolia and committed to sustainable growth, Golomt Bank is the perfect banking partner for all engaged in business in Mongolia, the world's fastest growing economies.

www.golomtbank.com

ture is allowed to increase by 18 percent in nominal terms in 2013. As our model is not based on a Social Accounting Matrix, it does not consider the full extent of government total revenue and expenditure. However, it considers government spending and tax revenues which are the parts of the government budget relevant to the system of national accounting. Assuming that nominal government spending will grow at the same rate as total expenditure as outlined in the 2013 budget (18 percent), we simulate the model for 2013 in four different environments—a baseline case, an optimistic case, a pessimistic case and a case without the FSL. In the baseline case, the price of main mining products follow what the government anticipates for 2013 which are substantially lower than those in 2012. For example, the price of coking coal and copper are expected to be about USD 80 and USD 6,329 per tonne respectively. In the optimistic case, we assume that the prices will remain the same as those in 2012—i.e., USD 106 for per tonne of coking coal and USD 7,471 per tonne of copper while everything else remains the same as those in the baseline case. In the pessimistic case, the price of the main mineral goods is uniformly 10 percent lower than those in the baseline case. We also simulate the model without imposing the FSL. More specifically, the growth rate of nominal government spending takes its historical average of 26.7 percent while everything else remains the same as those in the baseline case. The following table compares some macroeconomic variables across the cases in terms of their growth rates.

Macroeconomic variables (%)	Baseline	Optimistic	Pessimistic	Without FSL
Real export	38.07	38.78	39.35	37.71
Real GDP	23.59	23.65	23.23	23.60
Real imports	19.19	19.53	17.97	19.84
Tax revenue	25.50	27.13	26.03	25.75
GDP deflator	5.85	8.97	3.81	7.01
Mining sector output	44.30	44.64	43.93	44.30
Non-mining sector output	11.26	11.17	11.61	11.63
Real wage	12.34	12.44	9.98	14.28
Nominal national saving	34.97	42.72	29.82	34.88

As can be seen, there is significant volatility in the inflation rate measured by GDP deflator, real wage and nominal national saving whereas GDP growth, real export growth and growth of non-mining sector output are quite stable as we enter the production projection of the mining sector and the unemployment rate exogenously. Endogenising them depending on the price changes may lead to different results.

The following table shows the growth rates of gross output of selected industries. As can be seen, the results vary more noticeably at the micro level.

Growth rate of gross output (%)	Baseline	Optimistic	Pessimistic	Without FSL
Livestock	3.18	3.05	3.38	2.39
Other agriculture	0.68	0.58	0.37	0.06
Electricity	8.50	7.53	9.17	7.85
Manufacturing	3.87	3.60	9.18	2.79
Transportation	24.49	25.02	23.8	24.07
Construction	18.91	18.96	18.81	19.00
Health	4.80	4.39	2.35	8.52
Education	2.16	1.79	1.76	6.05
Public admin. and defence	4.03	3.64	2.78	10.52
Service	10.05	9.95	9.49	9.62

Given these results, we believe that the FSL is doing its job in a volatile environment. It is observed that the government budget deficit decreases in the first three cases as government spending increases at an exogenous pre-determined rate (18 percent) to meet the requirements set out in the FSL. Moreover, GDP growth is rather stable while national saving is more volatile as it absorbs the changes in the commodity prices. The results from without the FSL case in comparison to the baseline case also suggest that the FSL leads to lower inflation, lower current account deficit and an increase in non-mining industries except for health, education and public administration and defence.

We understand that there is room for improving the model's performance, especially for the period between 2005 and 2011 by choosing better values for the parameters. Nevertheless, we are not concluding that the model is not good enough. As an equilibrium model, it is doing a reasonably good job. There are about 10,000 variables and over 8,000 equations in the model. About 2,000 of them are exogenous variables so that their values are supposed to be entered in every simulation. It is, however, not practical as we simply do not know their values. The performance of the model depends on the usual suspects that are the quality of the data and the specification of the model. Ideally, we want a method which can choose the values of the parameters and the exogenous variables simultaneously in the process of minimising the difference around the targets. We will search for such a method and a programme in the literature. ■

[4] This approach is common in the literature. The reason is that traditional estimation approach of CGE model parameters has several problems. One of the main problems has been lack of information, mainly in developing countries. Given large number of parameters to be estimated, long time series data for numerous variables are required to provide sufficient degrees of freedom for estimation. For this reason, it is common to adjust parameters informally to meet target observed variables. However, we admit that adjusting parameter values in this way needs a more structured approach than ours and we will work on that in the future.

[5] In addition to these, we enter the projection of the productions of copper and coal industries in the model exogenously.

in the current environment where the mining sector is expanding so that the economy is more exposed to the volatility of commodity prices. Many experts, economists and politicians suggested that we should have saved more during the boom rather than spending so as to maintain the health of the economy during a crisis—i.e., countercyclical policy. As a result in 2011, the Mongolian parliament approved a Fiscal Stability Law (FSL) which spells out the rules for the stability of the growth rate of government expenditure. The parliament has recently approved the budget for 2013 which is constructed on the basis of the FSL.

In this research, we develop a dynamic and small open economy Computable General Equilibrium (CGE) model to examine the effect of the FSL on the Mongolian economy. Our CGE model is based on the Input-Output (IO) table of Mongolia which was constructed in 2005. It is a small open economy model—i.e., the country takes the prices of all goods exogenously. The model is also recursive dynamic as it has capital stock and foreign debt. In that sense, the model is an open economy, multi-sector extension of the Solow model. The model considers static expectations about the future events—i.e., the current events such as current inflation are used as proxies for the corresponding events in the next period. The model has the following equations in each period of time:

- Household demand for each product
- Investment demand for each product
- Government demand for each product
- Export demand for each product
- Industry (or producers') demand for each product and production factor
- Supply of each product and production factor
- Production cost and purchasers' price
- Normal profit conditions
- Market equilibrium for each product and production factor
- Various macroeconomic indicators such as GDP, GNP, a balance of payment, price indices, etc.

The transactions between the industries (suppliers of goods and services), final users (households, government, investors and exporters) over commodities and production factors (labour, capital, natural resources and land) are based on the decisions derived from the profit and utility maximisation problems.

The model parameters are calibrated (validated) to replicate the main characteristics of the economy as of 2012 to be used to predict the effect of the FSL over the next few years. In doing so, we first aggregate the 55 industries in the 2005 IO table to the following industries: Livestock, Other agriculture, Fishery and Forest, Oil, Gas, Thermal coal, Coking coal, Washed coal, NonOT copper, OT copper, NonOT gold, OT gold, NonOT minerals, OT minerals, Petroleum, Electricity, Manufacturing, Transport, Construction, Health, Education, Public administration and Defence, and Service. Then, we simulate the model by imposing certain targets consistent with the available data observed between 2005 and 2012 to generate the IO table as of 2012. The targets include the average GDP growth, the average GDP deflator inflation, the composition of GDP into consumption, investment, government expenditure and net exports, the average growth rates of gross output of some industries and the average changes of price indices in some industries (e.g., coal, gold and copper prices). From this simulation, we validate the parameter values. The results suggest that the model needs to improve in certain areas as some variables act quite differently from their observed values. This will certainly be the focus of our future research.

The main point of the FSL is that it restricts the growth of total government expenditure. Any excess government revenue will be saved in a Fiscal Stability Fund which contributes to the national savings. The fiscal stability fund is supposed to be at least 5 percent of GDP and the fund in excess of 10 percent of GDP can be invested into the economy through the Development Bank and the Human Development Fund subject to meeting certain conditions such as inflation. In this research, we are concentrating on the period between 2013 and 2015 which seems a natural given the newly-approved budget for 2013, and it is known as a medium term for the government. In that respect, investment from the Fiscal Stability Fund into the economy seems quite remote. In this report, however, we only present the results for 2013 from various simulations.

As mentioned earlier, the Mongolian parliament has recently approved the 2013 budget on the basis of the FSL. According to this, the total government expendi-

[1] The author would like to thank Economic Research Institute at the National University of Mongolia for financial support. Please notice that this is an ongoing project so that the results are preliminary.

